Батлав. Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Ж.Даш-Яйчил

Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

Иргэний нисэхийн ерөнхий газрын,
Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга Н.Батсайхан

"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал Китанака Такэфуми

Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байрлах "Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал, шатахууны агуулах"-ын Байгаль орчны менежементийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан - 2022 он

Хянасан:

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын мэргэжилтэн

П.Шинэцэцэг

Боловсруулсан:

"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн Төлөвлөлт, Зохицуулалтын газрын Төлөвлөлтийн менежер

Б.Энхсайхан

Иргэний нисэхийн ерөнхий газар,
Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа
Шинэ нисэх буудлын Шатахуун хангамжийн албаны дарга

Б.Борхүү

Улаанбаатар хот
2022 он

НЭГ. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН ТУХАЙ

1.1.1 Төслийн үндэслэл

Хэрэгжих болсон үндэслэл. Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Хөшигийн хөндийд Олон Улсын нисэх буудал барих албан ёсны хүсэлтийг Монгол Улсын Засгийн газар 2006 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Япон Улсын Засгийн газарт тавьсаны үр дүнд "Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл"-ийг хэрэгжүүлэхээр Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох "MON-P8" хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийг 2008 оны 05 дугаар сарын 01-нд байгуулж, мөн сарын 29-нд УИХ-аар батлсан байна. "Олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл"-ийг хэрэгжүүлэхэд Япон Улсын Засгийн газраас 28 тэрбум 807 сая иен (ойролцоогоор 300 сая ам.доллар)-тэй тэнцэх үнийн дүнтэй хөнгөлөлттэй зээлийг олгохоор шийдвэрлэж, Японы Олон улсын хамтын ажиллагааны банк, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай нэгдсэнээр, нэгдсэн нэг ЖАЙКА нэрийн дор уг төслийг хэрэгжүүлсэн[1].

Төслийн техник эдийн засгийн үндэслэл ба зураг төсөл. Шинэ нисэх буудал барих зураг төслийг Япон Улсын зөвлөх үйлчилгээ үзүүлэх "АЗУСА СЭККЭЙ/ОРИЕНТАЛ КОНСАЛТИНГ" компаниудын хамтарсан түншлэл урьдчилсан зураг төслийн хүрээнд шинэ нисэх буудлын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж ЗТБХБ-ын сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн үндсэн барилга байгууламжийн их загвар зургийг зөвшөөрүүлж, ерөнхий төлөвлөгөөг 2010 онд батлуулсан[2] нь 2007, 2010 онуудад захиалгаар мэргэжлийн байгууллагуудын гүйцэтгэсэн инженер-геологийн судалгаанд үндэслэсэн байдаг.

Төслийн гүйцэтгэгчид. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр Япон улсын "Мицубиши Чиёода" компанийн түншлэл ажилласан бөгөөд Хөшигийн хөндийд баригдсан Олон улсын нисэх онгоцны буудал барих төслийн ерөнхий туслан гүйцэтгэгч компаниар БНСУ-ын "Самсунг С&Т" корпораци сонгогдон Монгол улсад "Эс Си Ти И Си Эм" ХХК-ийг байгуулан 2013 оны 06 сараас онгоцны буудал барих ажлыг эхлүүлсэн[2].

1.1.2 Төсөл хэрэгжүүлэхэд оролцогсод

Зам Тээврийн Хөгжлийн Яам: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тус яамны чиглэлээр тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээж, эрхэлсэн асуудлын чиглэлээр Засгийн газарт зөвлөх үүрэг, хариуцлага хүлээж ажилладаг. Тус яамны "Агаарын тээврийн бодлого зохицуулалтын хэлтэс"-ийн үндсэн үйл ажиллагаа нь Зам, тээврийн хөгжлийн сайдаас иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах"-д[3] чиглэнэ.

[1] http://www.nubia.mn/, >Төслийн тухай> товч танилцуулга

[2] Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл хэрэгжүүлэх нэгж

[3] https://mrtd.gov.mn/, Агаарын тээврийн бодлогын хэрэжилтийг зохицуулахад асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Зам тээврийн хөгжлийн яамны эрхэм зорилго, зорилт (https://mrtd.gov.mn/[ов] (Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, 2.5.6.Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилт) –д агаарын тээврийн талаар дараах зорилтууд байна. Үүнд:

- Иргэний нисэхийн салбарын хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг зохион байгуулах, зохицуулах замаар иргэний нисэхийн тогтвортой, хүртээмжтэй үйлчилгээг хангах;
- Агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт, агаарын харилцаа, нислэгийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэгдсэн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах.

Хуулийн этгээд: Иргэний нисэхийн ерөнхий газар

Төслийн нэр:	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал, шатахууны агуулах
Төсөл хэрэгжүүлэгч:	Иргэний нисэхийн ерөнхий газар Улсын бүртгэлийн дугаар: 9013001003 Регистрийн дугаар 2628546
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа Утас: 976-11-282067 Майл хаяг: info@mcaa.gov.mn Вэб хуудас: https://www.mcaa.gov.mn/
Байрлал:	Төв аймгийн Сэргэлэн сум, 4-р баг, Бөхөгийн хөндий

Хуулийн этгээд: Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК

Төслийн нэр:	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал
Төсөл хэрэгжүүлэгч:	Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК Улсын бүртгэлийн дугаар: 000168199 Регистрийн дугаар: 3874095
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Төв, Сэргэлэн, 4-р баг, Эрдэнэ-Уул, /41090/ тахилт толгой Утас: 7128 7360, 7128 7385 Мэйл хаяг: info@nubia-llc.mn Вэб хуудас: https://www.nubia-llc.mn/
Байрлал:	Төв аймгийн Сэргэлэн сум, 4-р баг, Бөхөгийн хөндий

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 261 дүгээр тогтоолоор "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол-Японы хамтарсан "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийг Монгол Улсын талын 49 (дөчин ес) хувийн, Япон Улсын талын 51 (тавин нэг) хувийн оролцоотой байгуулах зөвшөөрлийг олгосноор 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдөр "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК байгуулагдаж, Улсын бүртгэлд бүртгүүлсэн. Тус компанийн 49 хувийг Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 150 дугаар тогтоолоор байгуулагдсан Хөшигийн Хөндий нисэх онгоцны буудал ТӨХХК, 51 хувийг Японы Мицүбиши корпораци, Нарита олон улсын нисэх буудал, Жатко (Japan Airport Terminal Co.,Ltd), Жалукс (JALUX Ltd) компаниудын хөрөнгө оруулалттай тусгай зориулалтын компани болох Жапан Эйрпорт менежмент ХХК эзэмшдэг.

2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээ "хөрөнгө оруулах-ашиглах-шилжүүлэх" нөхцөлөөр Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Японы хамтарсан "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК хооронд байгуулагдсан.

НУБИЭ ХХК нь уг концессын гэрээний дагуу шинэ нисэх буудлын менежмент, үйл ажиллагааг хариуцан ажиллах бөгөөд 2019 оноос компанийн үйл ажиллагаа албан ёсоор эхэлж нисэх буудлын нээлтийн бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Энэ хүрээнд нисэх буудлын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг 2020 онд эхлүүлэхээр төлөвлөж байсан боловч дэлхий даяар тархсан “COVID-19” цар тахлын улмаас хойшлогдож, 2021 оны 07 дугаар сарын 04-ний өдөр шинэ нисэх буудлыг нээж, анхны нислэг үйлдсэн.

“Чингис хаан” олон улсын нисэх буудлын эрхэм зорилго:

- Аюулгүй, тав тухтай нисэх буудал;
- Үйлчлүүлэгчдэд ойр, хариуцлагатай нисэх буудал;
- Өндөр түвшний чанартай үйлчилгэтэй нисэх буудал болох.

1.1.3 Ил тод байдал

Монгол улс нь Олон Улсын Иргэний Нисэхийн гишүүн байгууллага бөгөөд олон улсын агаарын тээвэрлэгч болон хэрэглэгчдэд аэродромын өгөгдөл болон мэдээллийг цаг алдалгүй www.ais.mn цахим хуудаст мэдээлж ажилладаг. Тус мэдээлэлд:

- Аэродромын байршил заах код ба нэр
- Аэродромын газар зүйн болон захиргааны өгөгдөл
- Үйл ажиллагааны цагийн хуваарь
- Газрын үйлчилгээ болон байгууламжууд
- Зорчигчдод үйлчлэх байгууламжууд
- Авран туслах, гал унтраах үйлчилгээ
- Улирлын чанартай цэвэрлэгээний үйл ажиллагаа
- Апрон, явгалах зам ба шалгах байрлал/байршлуудын өгөгдөл
- Гадаргуугийн хөдөлгөөнийг чиглүүлэх болон удирдлагын систем ба тэмдэглэгээнүүд
- Аэродромын саадууд
- Цаг уурын мэдээллийн хангалт
- Хөөрч, буух зурвасын бодит үзүүлэлтүүд
- Зарласан зайнууд
- Ойртолтын болон ХБЗ-ын гэрэлтүүлэг
- Бусад гэрэлтүүлэг болон цахилгааныг нөөц тэжээл
- Нисдэг тэрэгний буултын талбай
- НХҮ-ийн агаарын зай
- НХҮ-ийн холбооны байгууламжууд
- Радио навигацийн болон буултын туслах хэрэгслүүд
- Нислэгийн журмууд
- Нэмэлт мэдээлэл
- Аэродромд хамааралтай журмууд

Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК-ийн HYPERLINK "http://www.nubia-llc.mn"www.nubia-llc.mn цахим хуудаст:

- Компанийн бодлого, стратеги, зорилго, зохион байгуулалт;
- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал;
- Байгаль орчны менежмент;

- Хүний нөөцийн менежмент, нээлттэй ажлын байрны мэдээлэл, анкет бүртгэл;
- Худалдан авалт;
- Бизнесийн түншүүд, хамтран ажилладаг байгууллагууд;
- Холбоо барих, санал хүсэлт хүлээн авах;
- Үйл явдлын мэдээ, мэдээлэл багтсан байна.

"Чингис хаан" олон улсын нисэх буудлын www.ulaanbaatar-airport.mn цахим хуудаст:

- Нисэх буудлын үндсэн үйлчилгээ, үйлчилгээний газруудын байршлын мэдээлэл
- Нислэгийн хуваарь, аялалын зөвлөмж;
- Нисэх буудлын "Линк" бизнес танхимын талаар мэдээлэл;
- Нисэх буудлын аюулгүй ажиллагаа;
- Хил, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагуудын улсын хилээр нэвтрүүлхэд хяналт тавих дүрэм, журамууд;
- Карго терминалын үйлчилгээ, үнэ тариф;
- Нийтийн тээвэр, такси үйлчилгээ, дулаан гаражийн үнэ тариф;
- Валют арилжаа, цаг агаарын мэдээ;
- Үйл явдлын мэдээ мэдээлэл;
- Нисэх буудлын үйл ажиллагааны талаар болон байгаль орчинтой холбоотой өргөдөл гомдол, санал хүсэлт хүлээн авах, 1900-1980 мэдээллийн лавлахтай холбогдох линк зэрэг багтсан байна.

1.1.4 Төслийн зорилго

Төслийн үндэслэл: Хуучин Буянт-Ухаа дахь "Чингис хаан" Олон улсын нисэх буудалд учирч байсан хүндрэлүүдийг бүрэн шийдвэрлэхийн тулд шинэ нисэх буудал барих шаардлага тулгарсан. Үүнд:

- Уулын саадаар хязгаарлагдсан тул хоёр талаасаа хөөрч буух зурвас, нэмэлт зурвас төлөвлөх зай талбайгүй;
- Аэродромын хөөрч буух зурвас "Олон улсын иргэний агаарын тээврийн шаардлага болох 1%-ийн налуутай байх ёстой" гэсэн шаардлагад тэнцэхгүй;
- Өмнө болон баруун өмнө зүгээс том оврын онгоц буух боломж байхгүй;
- Улаанбаатар хотын утаанаас хамаарч өвлийн улиралд нислэг саатдаг;
- Зорчигчийн терминалын хүчин чадал хүрэлцэхгүй болсон;


Төслийн үндсэн зорилго:

- Дээрх хүндрэлүүдийг арилгах;
- Нислэгийн аюулгүй ажиллагааны хангалтыг дээшлүүлэх;
- Агаарын тээвэрлэлтийг тогтворжуулах;
- Эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих;


Төслийн үр дүн: Төслийн үндсэн зорилгыг биелүүлэх, зурвас ашиглалтыг 73-98 хувьд хүргэх, цаг агаарын тааламжгүй нөхцөлөөс шалтгаалсан нислэгийн саатлыг 2.3-0.5 хувь болгож бууруулах боломжтой.

1.1.5 Төслийн байршил

"Чингис хаан" олон улсын шинэ нисэх буудал Улаанбаатар хотын төвөөс 52 км зайд, Төв аймгийн Зуун мод хотоос 8 км зайд Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байршдаг.



Зураг 1. Шинэ нисэх буудлын байршил ба физик газар зүйн мужлал



Зураг 2. Улаанбаатар хот орчмын нисэх буудал бүхий бүс нутаг

"Чингис хаан" Олон улсын нисэх буудал нь Буянт-Ухаа нисэх буудлаас 27км, Налайх дахь цэргийн нисэх баазаас 40 км зайд оршино.

1.1.6 Газар олголт ба газар ашиглалт

ОУ-ын шинэ нисэх буудал барих газрын байршил, нисэх буудлын хил заагийг МУ-ын ЗГ-ын 2010 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн "Тусгай хэрэгцээний газарт хамааруулах тухай" 140-р тогтоолоор тогтоож, 2016 оны 154-р тогтоолоор хилийн заагийг өөрчлөн тогтоосон.

№	Хэнд	Зориулалт	Шийдвэр, дугаар	Нийт талбай /га/
1	Иргэний Нисэхийн Ерөнхий газар	Олон улсын нисэх буудал	Төв аймгийн Сэргэлэн сумын ЗД-ын 2020 оны 05 сарын 06-ны өдрийн А/269 дүгээр захирамж Улсын бүртгэлийн дугаар: 1419000027	1017
2	Улсын тусгай хэрэгцээ		ЗГ-ын 2016 оны 154 дүгээр тогтоол	12084.9
3	Зам, тээврийн хөгжлийн яам	Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх	ЗГ-ын 2016 оны 154 дүгээр тогтоол Гэрчилгээний дугаар: 000000004	2400


Хүснэгт 1. Газар олголтын шийдвэр, гэрчилгээжүүлэлт

Төв аймгийн Газрын Харилцаа, Барилга Хот Байгуулалтын Газарын 2020 оны I улирлын мэдээллээр ОУ-ын шинэ нисэх буудлын ойртолтын бүсэд нийт 4668 га талбайд иргэн, аж ахуйн нэгжүүдэд газар олгогдсон байна.

№	Ангилал	Нэгж талбарын тоо	Нийт талбай \га\
1	Орон сууц	6	365.2
2	Зам, шугам сүлжээ	10	1342.2
3	Амралт, аялал жуулчлал	2	14.9
4	Боловсрол, эрүүл мэнд	8	37
5	Гэр бүлийн хамтын хэрэгцээнд эзэмшил	326	18.4
6	Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлөл	710	49.3
7	Тариалан, хүнсний ногоо	10	117.2

№	Ангилал	Нэгж талбарын тоо	Нийт талбай \га\
8	Үйлдвэр, үйлчилгээ	128	2440.4
9	ХАА-н үйлдвэрлэл	15	283.4
	Бүгд	**1215**	**4668**

Хүснэгт 2. Нисэх буудал орчимд олгогдсон газар



Төв аймгийн Сэргэлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 08-ны 65 дугаар тогтоолоор Аэродромын аюулгүйн бүсийг тогтоосон.

Зураг 3. Нисэх буудлын аюулгүйн бүсийн зураг

1.1.7 Төслийн хүчин чадал

"Чингис хаан" Олон улсын шинэ нисэх буудал нь жилд 2,3 сая олон улсын зорчигч, үйлчлүүлэгчдийг хүлээн авах хүчин чадалтай олон улсын стандартыг хангасан, 30 гаруй барилга байгууламжтай иж бүрэн цогцолбор юм. Үүнд дараах барилга байгууламжууд хамаарна:

Том оврын агаарын хөлөг хөөрч, буух хоёр талын оролт, гаралттай, 3600 м урттай 45 м өргөнтэй зурвас, явгалах зам, 6 зорчигчийн гүүрэн хүзүүвч, 18 агаарын хөлгийн зогсоол, 9 баллын газар хөдлөлтөд тэсвэртэй нислэг хөдөлгөөний удирдлагын байр, өргөтгөх боломжтой 37000 м^2 үйлчилгээний талбай бүхий зорчигч үйлчилгээний барилга, захиргааны барилга, мөн түүнд холбогдох хүзүүвч, 42 мгватын хүчин чадалтай дулааны станц, цахилгаан дамжуулах 110 Кв-ын өндөр хүчний шугамын дэд станц, гүний худгийн барилга, хоногт 800 м^3 хүчин чадалтай ус цэвэршүүлэх болон бохир ус цэвэрлэх байгууламж, галын 9 дүгээр зэрэглэлийн шаардлагыг хангасан аврах, гал унтраах албаны барилга, ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга, газрын үйлчилгээний тоног төхөөрөмжийн байгууламж, аэродромын байгууламж, ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга, 1086 автомашины ил болон дулаан зогсоол, агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх газар доорх гидрант систем, нийт 8000 тонны багтаамж бүхий шатахууны агуулах сав, үерийн уснаас хамгаалах далан суваг, инженерийн шугам сүлжээний газар доогуурх 1.8 км урт цутгамал хонгил байна.

1.1.8 Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК, ИНЕГ-ын Иргэний нисэхийн үндэсний төвийн Шатахуун хангамжийн албаны тусгай зөвшөөрлүүд

Зөвшөөрөл, дүгнэлт	ИНЕГ, Иргэний нисэхийн үндэсний төвийн Шатахуун хангамжийн алба	Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК
1. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл Дугаар Хүчинтэй хугацаа Талбай	- Агаарын хөлгийг шатах тослох материалаар хангах үйлчилгээний байгууллагын гэрчилгээ Дугаар MCAA.144.008/20 Хүчинтэй хугацаа 2024/05/24 - Ашигт малтмал газрын тосны газар бүртгэлийн гэрчилгээ	- Эрчим Хүчний Яам "Ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл" Дугаар 2045/20, Хүчинтэй хугацаа 3 жил, "Цахилгаан түгээх тусгай зөвшөөрөл" Дугаар 04/2021, Хүчинтэй хугацаа 3 жил, "Цахилгаанаар зохицуулалттай хангах Тусгай зөвшөөрөл" Дугаар 05/2021, Хүчинтэй хугацаа 3 жил,

	Дугаар 081 Хугацаагүй - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл Дугаар: 685	- Төв аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл "Дулаан үйлдвэрлэх Тусгай зөвшөөрөл" Дугаар 04/2020, Хүчинтэй хугацаа 5 жил, "Дулаан түгээх Тусгай зөвшөөрөл" Дугаар 05/2020, Хүчинтэй хугацаа 5 жил, "Дулаанаар зохицуулалттай хангах Тусгай зөвшөөрөл" Дугаар 06/2020, Хүчинтэй хугацаа 5жил, - Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар "Рентген хяналтын аппарат ашиглах, хадгалах Тусгай зөвшөөрөл" Дугаар 2022/01-160, Хүчинтэй хугацаа 1 жил, "Ионжуулагч цацрагийн үүсгүүрийг ашиглах, хадгалах Тусгай зөвшөөрөл" Дугаар 2022/02-19, Хүчинтэй хугацаа 1 жил, - Харилцаа холбооны зохицуулах хороо "Радио давтамж ашиглах эрхийн бичиг" Дугаар 20511646, Хүчинтэй хугацаа 2 жил, - Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл "Нийтийн аж ахуйн үйлчилгээ эрхлэх Тусгай зөвшөөрөл" Дугаар 00445, Хүчинтэй хугацаа 3 жил
2. Тусгай зөвшөөрөл Дугаар Хүчинтэй хугацаа		Химийн хорт болон аюултай бодис ашиглах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл Дугаар 0001788, Хүчинтэй хугацаа 2 жил
3. Химийн бодис хадгалах ажлын байрны дүгнэлт		Төв аймгийн мэргэжлийн хяналтын газар "Химийн хорт болон аюултай бодисын тухай" хуулийн 10 дугаар зүйлд заасан химийн бодис хадгалах агуулахад тавигдах үндсэн шаардлага, Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахтай, Ерөнхий шаардлага MNS 6458:2014 стандартын шаардлагад нийцсэн тухай дүгнэлттэй. Дугаар 19-04-002/131
4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	ИНҮТ ЧХОУНБ Шатахуун хангамжийн алба 2021 оны 06 сарын 30, Дугаар 2021018	- Зорчигч үйлчилгээний барилга – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006849, Хүчинтэй хугацаа 2 жил - Газрын үйлчилгээний байгууламж – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006847, Хүчинтэй хугацаа 2 жил - Гал унтраах, авран хамгаалах албаны байгууламж – 2022 оны 08 сарын 16, дугаар 0006848, Хүчинтэй хугацаа 2 жил - Цахилгаан түгээх дэд өртөө – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006852, Хүчинтэй хугацаа 2 жил - Захиргааны барилга 2022 оны 08 сарын 16, дугаар 0006850, Хүчинтэй хугацаа 2 жил - Дулаан граж – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006851, Хүчинтэй хугацаа 2 жил - Аэродромын байгууламж – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006846, Хүчинтэй хугацаа 2 жил - Дулааны станц – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006845, Хүчинтэй хугацаа 2 жил - Цэвэр усны байгууламж – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006843, Хүчинтэй хугацаа 2 жил - Бохир ус цэвэршүүлэх байгууламж – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006844, Хүчинтэй хугацаа 2 жил

		- Ачаа, шуудан, тээврийн үйлчилгээ – 2022 оны 08 сарын 16, Дугаар 0006853 , Хүчинтэй хугацаа 2 жил
5. Ус ашиглуулах дүгнэлт, огноо	Ус ашиглуулах дүгнэлт	Ус ашиглуулах дүгнэлт, 2022 оны 03 сарын 10, Дугаар 26

Хүснэгт 3. Тусгай зөвшөөрлүүд

1.1.9 Байгаль орчны үнэлгээ

"Чингис хаан" олон улсын нисэх буудал орчмын Байгаль орчны үнэлгээг 2020 онд "Эхмонголын байгаль" ХХК-иар нэг удаа хийлгэсэн. Уг тайланг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан (eic.mn) холбоосоор орж харах боломжтой.

№	Тайлангийн нэр	Батлагдсан он
1.	Төв аймгийн Сэргэлэн сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй ""ОЛОН УЛСЫН ШИНЭ НИСЭХ БУУДАЛ, ШАТАХУУНЫ АГУУЛАХ" төслийн БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН	2020

Хүснэгт 4. Одоо мөрдөгдөж байгаа БОНҺҮ-ний тайлан

1.2 НИСЭХ БУУДАЛД "НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ" ХХК-ИЙН ХАРИУЦСАН БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД

1.2.1 Аэродром

Аэродромын лавлагаа код ба ашиглалтын ангилал: ИКАО-ийн Хавсралт 14-Аэродромын дагуу аэродромын лавлагаа код нь 4E буюу A330/B777 ангилалд тохирно. Энэ нь олон улсын нисэх буудлын хамгийн бага шаардлага, нисэх буудлын ашиглалтын аюулгүй байдлыг дээшлүүлэх I ангиллын нарийвчлалд нийцэх юм. Агаарын хөлгүүд хоёр чиглэлд хөөрдөг, буудаг байх салхины болон геологийн тооцоололтойгоор байгуулагдсан.




Зураг 4. Хөөрч, буух зурвас

Хөөрч буух зурвасын тоо ба чиглэл: Аэродромын хүрээн дэх хөөрч буух зурвасын тоо ба чиглэлийг тухайн аэродромын зүгээс үйлчилгээ үзүүлдэг агаарын хөлгүүдийн хувьд аэродромын ашиглагдах боломжийн хүчин зүйл /usability factor/ нь 95%-иас багагүй байхаар тооцоолдог. Хуучин нисэх буудлын үйлчилгээнд тулгарч байсан хүндрэлийг арилгаж, зурвас ашиглалтыг 73 хувиас 98 хувьд хүргэх, цаг агаарын тааламжгүй нөхцөлөөс шалтгаалсан саатлыг 2.3 хувиас 0.5 хувь болгож бууруулах боломжтойгоор төлөвлөгдсөн. Цаг уурын мэдээллийн дүн шинжилгээний үндсэн дээр, 115/295-ын хөөрч буух зурвасын чиглэл бүхий "Чингис хаан" олон улсын нисэх буудлын салхин нөмрөг дараах байдалтай байна.

Хөндлөн салхи	20 зангилаа	13 зангилаа	10 зангилаа

Салхин нөмрөг	99.31%	95.22%	90.55%

Хүснэгт 5. Салхин нөмрөг (Эхсурвалж: САПРОФ-ын Судалгааны баг)

Хамгийн их хүрэлцэхүйц /зөвшөөрөгдөх/ хэмжээний хөндлөн салхины бүрэлдэхүүн хэсгүүдийн сонголт нь тодорхойлогч талбайн урт нь 1500 м ба түүнээс дээш байх агаарын хөлгүүдийн хувьд 20 зангилаа, тодорхойлогч талбайн урт нь 1200 м ба түүнээс дээш боловч 1500 м-ээс бага байх агаарын хөлгүүдийн хувьд 13 зангилаа, тодорхойлогч талбайн урт нь 1200 м-ээс доош байх агаарын хөлгүүдийн хувьд 10 зангилаа байна. Нисэх буудлаар үйлчлүүлэх ихэнх агаарын хөлгүүдийн тодорхойлогч талбайн урт 1200 м-ээс дээш байх учраас нэг хөөрч буух зурвас нь ICAO-ийн заавар зөвлөмжид дурдсан шаардлагыг хангана. Хөөрч буух зурвасын багтаамж буюу хүчин чадлын хувьд, шаардлага хангасан явгалах замын систем болон агаарын хөдөлгөөний хяналтын байгууламжаар хангагдсан байх нөхцөлд нэг хөөрч буух зурвас нь ерөнхийдөө цагт 35-40 агаарын хөлгийн хөдөлгөөнийг /жилд 195,000-240,000/ зохицуулах боломжтой байдаг. Оргил цагийн агаарын хөлгийн хөдөлгөөн нь төлөвлөж буй хугацааны туршид (2024 он хүртэл) 14 ба түүнээс бага байх учраас нэг хөөрч буух зурвас хангалттай байх болно.

Хөөрч буух зурвасын өргөн: Аэродромын тодорхойлолтын 4E кодод зориулан гаргасан ICAO-ийн заавар зөвлөмжийн дагуу хөөрч буух зурвасын хамгийн бага өргөн нь хоёр талд нь байрлах 7.5 м-ийн өргөнтэй мөрнөөс гадна 45 м байх ёстой байдаг.

Хөөрөх буух зурвас. ХБЗ-ны зурвасын урт 3600 м. Нислэгийн зурвас дээр агаарын хөлөгт аюул учруулж болзошгүй аливаа зүйл, объектыг саад тотгор гэж үзэх бөгөөд агаарын хөлгийн зориулалтын багаж хэрэгслээс бусад суурин зүйлийг ХБЗ-ын төв шугамаас 60 м-ээс цааш зайд байрлуулна.

Хөөрч буух зурвасын төгсгөлийн аюулгүйн бүс. ХБЗ-ын төгсгөлийн аюулгүйн талбай нь ХБЗ-ын зурвасын төгсгөлөөс аль болох хол буюу хамгийн багадаа 90 метр байна. ХБЗ-ын төгсгөлийн аюулгүйн хязгаарын зурвас 2 x 45m = 90m байна. Агаарын хөлөгт аюул учруулж болзошгүй ХБЗ-ын төгсгөлийн аюулгүйн бүсэд байрлах аливаа объектыг саад гэж үзнэ.

Аэродромын үзүүлэлт. Хөөрч буух зурвасын урт 3600 м, автомашины зогсоол 825, зорчигч терминалын талбай 37000 м^2, цамхгийн өндөр 41 м.

1.2.2 Ачаа, шуудангийн үйлчилгээний барилга

Ачаа, шуудангийн үйлчилгээний барилга нь агаарын тээврээр тээвэрлэгдэж ирэх болон явах ачаа, шууданг газрын тээвэртэй холбох нэгдсэн цогц үйлчилгээг хүргэдэг. Олон улсын болон орон нутгийн нислэгээр тээвэрлэгдэж ирсэн, тээвэрлэгдэж явах бүх төрлийн ачаа, шууданг нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангаж ачиж буулгах, тээвэрлэлтэд бэлтгэх, хүлээн авах болон хадгалах үйлчилгээг Олон Улсын Иргэний нисэхийн байгууллага/ICAO/, Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооноос /IATA/ гаргасан стандарт, заавар, дүрмийн дагуу чанарын өндөр түвшинд үзүүлж байна.

Ачаа, шуудангийн үйлчилгээний барилгын хүчин чадал:

- Байгууламжийн ашигтай талбай 3750 м2;
- Жилд 18000 тонн карго ачаа, шуудан нэвтрүүлэх;
- Аюултай ачааны агуулах эскпорт импорт тус бүрт 28 м^2 талбайтай;
- Үнэт ачааны агуулах эскпорт импорт тус бүрт 28 м^2 талбайтай;


- Хөргөлттэй агуулах 12 м^2;
- Хөлдөөгчтэй агуулах 44 м^2;
- Өндөр хүчин чадалтай 3 сэрээт өргөгчтэй.



Зураг 5. Ачаа, шуудангийн үйлчилгээний барилга

1.2.3 Зорчигч үйлчилгээний барилга

Барилгажилтийн нийт талбай 53726м^2 ба үүний 37000м^2 нь үйлчилгээний зориулалттай.



Зураг 6. Зорчигч үйлчилгээний барилга

Жилд олон улсын 2,3 сая, орон нутгийн 0,3 сая зорчигчдод үйлчлэх хүчин чадалтай. Олон улсын зорчигчдын агаарын хөлөгт суух гүүрэн хүзүүвч 5, орон нутгийн зорчигчдын агаарын хөлөгт суух 1 гүүрэн хүзүүвч хоолойтой, олон улсын бүртгэлийн 16, орон нутгийн бүртгэлийн 8 цэгтэй бөгөөд цаашид өргөтгөх боломжтой.

Нисэх буудалд мэдээллийн цэг, олсон гээсэн эд зүйлс хадгалах цэг, эх хүүхдийн тусламжийн үйлчилгээ, автомашины түрээс, эмнэлэгийн тусламж үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй зорчигч, үйлчлүүлэгдийг угтах, чиглүүлэх үйлчилгээг тус тус үзүүлж байна. Мөн "Линк" бизнес лоунж, Төв аймгийн аялал жуулчлалын мэдээллийн төв, татваргүй

барааны дэлгүүрүүд, банкны салбарууд болон тэдгээрийн АТМ, Монгол шуудан, Эмийн сан, Кофе шоп, Хүнсний дэлгүүр, нийтийн хоолны газрууд ажиллаж байна.

1.2.4 Аврах, гал унтраах албаны барилга, машин техник

Гал түймэртэй тэмцэх, авран хамгаалах машин техник: ICAO-гийн 14-р хавсралт, Нисэх буудлын үйлчилгээний удирдамжийн 1-р хэсэгт заасны дагуу, 9 дүгээр зэрэглэлийн нисэх буудлын хувьд гал түймрийн үед шаардагдах усны хамгийн бага хэмжээ нь 24300 литр байх бол хөөсөн уусмалын хувьд шүршилтийн хамгийн бага зэрэг нь (тухайн уусмалын үйлчлэлийн төвшин B байх нөхцөлд) 9000 литр/мин байна. Иймээс доод тал нь 8500 литр усны багтаамжтай, эсвэл минутанд 3000 литр уусмал шүрших шүршилтийн зэрэг бүхий 3ш аврах буюу гал түймэртэй тэмцэх машин техникийг нисэх буудлын хувьд төлөвлөсөн



Зураг 7. Аврах, гал унтраах автомашин

Гал унтраах: "Гал унтраах багийнхан нь дохиолол хүлээн авснаас хойш харагдах орчны хүрээнд орших, замын нөхцөл сайтай зурвасын дурын хэсэгт 2 минутын дотор, агаарын хөлгүүдийн хөдөлгөөний талбай дахь бусад дурын цэгт 3 минутаас бага хугацаанд амжиж хүрэх ёстой" гэсэн ICAO-гийн удирдамжийн шаардлагын дагуу гал унтраах анги нь зурвасын дунд хэсэгт ойрхон, агаарын хөлөг зурвас руу гарах зориулалт бүхий явгалах замаар дамжин зурваст хамгийн богино хугацаанд хүрэх боломжтой газар байрлаж байна. Гал унтраах анги нь галын 3, удирдлагын 1, түргэний 1 машины багтаамжтай гаражтай. Машин техникийн сэлбэг хэрэгсэл, аврах багаж хэрэгсэл хадгалах байр, албан өрөө, уулзалтын өрөө, хяналтын тавцан болон шаардлагатай бусад зүйлсээр хангагдсан. Галын станцын ердийн талбай нь ойролцоогоор 800м.кв байна.



Зураг 7. Аврах, гал унтраах

1.2.5 Цэвэр ус хангамжийн байгууламж


Цэвэр ус хангамжийн байгууламж нь эрүүл ахуйн шаардлагад нийцсэн MNS900:2018 стандартын дагуу цэвэр усаар нисэх буудлын бүс дэх барилга байгууламжуудыг 24 цагийн турш тасралтгүй хангадаг. Хөшигийн хөндийд байрлах усны эх үүсвэрийн гүний 3 худгаас



усыг олборлон цэвэр ус хангамжийн байгууламжид байрлах түүхий ус хүлээн авах санд хүлээн авч 800м^3 хүчин чадалтай фильтрэн системээр усыг цэвэршүүлж, ус хадгалах 2х400м^3 санд нөөцлөн 4 өргөлтийн насосоор дамжуулан хэрэглэгчдийг ундны усаар хангадаг.

Зураг 8. Цэвэр усны байгууламж

1.2.6 Дулааны станц



Зураг 9. Дулааны станцын технологийн схем

Дулааны станц нь нисэх буудлын барилгаас 4 километрийн зайд байрлана. Нийт 38 автомашины зогсоолтой. 2016 оноос дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Тус бүр нь 14МВт-ын хүчин чадал бүхий гурван зуухтай, нийт 42МВт суурилагдсан хүчин чадалтай. Үүнээс хоёр зуух нь халаалтын улиралд байнгын ажиллагаанд, нэг зуух нь бэлтгэл байдалд буюу нөөцөд байхаар төлөвлөгдсөн.

Халаалтын зуух. Нисэх буудлын барилга, байгууламжуудын халаалт, агаар сэлгэлтийн системийн халаалтын хэрэгцээг хангах зорилгоор тус бүр нь 14 мегаватт дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай хатуу түлшээр ажилладаг 150-170 градус параметртэй халуун ус гаргах гурван халаалтын зуухтай. Халаалтын зуух нь жилийн 210 хоногт ажиллаж, нисэх буудлын барилга байгууламжуудыг дулаан, хэрэглээний халуун усаар хангана.

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Зуухны хүчин чадал	МВт	28
2	Жилд үйлдвэрлэх дулаан	МВт	80640
3	Хэрэглэгчид өгөх дулаан	МВт	77760
4	Жилийн түлшний зарцуулалт	Тн	25481
5	Цахилгаан хөдөлгүүрийн суурилагдсан хүчин чадал	кВт	955.9
6	Цахилгааны жилийн хэрэглээ	Мян.кВт	955.9
7	Жилийн усны зарцуулалт	Мян.м^3	99.8
8	Зуухны ашигт үйлийн коэффициент	Хувь	0.81
9	Түлшний хувийн зарцуулалт (нэгж дулаан, 1МВт)	Кг/МВт	316

Хүснэгт 6. Дулааны станцын халаалтын зуухны техникийн үзүүлэлтүүд

Станцын дулаан үйлдвэрлэл ба түлш.

Дулаан хангамжийн станцад шингэн түлш (керосин) ашиглахаар төлөвлөж байсан боловч эдийн засгийн үр өгөөжөөс шалтгаалан хатуу түлш буюу Баганууурын хүрэн нүүрсээр ажиллуулахаар болсон. Жилд ойролцоогоор 25,000 орчим тн нүүрсээр галлан, 99.8 мян.м^3 ус зарцуулж, 80 мянга орчим МВт дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай.



Зураг 10. Дулааны станцын байгууламж



Зураг 11. Цахилгааны үндсэн дэд өртөө

1.2.7 Цахилгаан хангамж

Шинэ нисэх буудал нь 110/10кВ-ын "Хөшигт" дэд станцаас цахилгаан эрчим хүчээр хангагддаг. 110/35/10кВ-ын Налайх дэд станцаас 119-р, 220/110/35кВ-ын Сонгино дэд станцаас 121, 122-р, 110/10кВ-ын Бөхөг дэд станцаас 139, 140-р агаарын шугам гэсэн 3 талын тэжээлтэй. Үндсэн, салбар дэд өртөөнүүд эрчим хүчний системээс хүчдэлгүй болсон тохиолдолд 50-2250кВ чадал бүхий дизель генераторуудаар барилгуудыг эрчим хүчээр хангана.


1.2.8 Цэвэрлэх байгууламж

Цэвэрлэх байгууламж нь ахуйн бохир ус цэвэрлэх зориулалтай, хоногт 800м3 ус цэвэрлэх хүчин чадалтай бүрэн автомат удирдлагын системтэй. Бохир ус өргөлтийн 2 ширхэг насос станц, 5 км шугам ба 71 худагаар дамжуулан татан зайлуулдаг. Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй барилга байгууламжийн бохир усыг цуглуулах 4 цооногтой үйл ажиллагааг явуулж байна. Шинэ нисэх буудлын төслийн хүрээнд баригдсан уг цэвэрлэх байгууламжид хүлээн авах бохирдолын зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь төслийн хүчин чадлаар байдаг (Хүснэгт 7.) ба Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгддөг бусад дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж ажиллаж байна.



Зураг 12. Цэвэрлэх байгууламжийн барилга

Монгол Улсын аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийг үндэслэн Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс олгосон "Нийтийн аж ахуйн ажил үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд нийт 10 чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.



Зураг 13. Цэвэрлэх байгууламжийн технологийн схем

№	Нэгж	Үзүүлэлт	Хэмжээ
1	мг/л	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, BOD	300
2	мг/л	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, COD (Mn)	200
3	мг/л	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, COD (Cr)	300
4	мг/л	Умбуур бодис, (SS)	300
5	мг/л	Нийт азот, (TN)	50
6	мг/л	Нийт фосфор, (TP)	5

Хүснэгт 7. Хүлээн авах бохир усны бохирдлын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

1.2.9 Авто зогсоол




Зураг 14. *832 автомашины* зогсоол

НИСЭХ БУУДАЛД ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРИУЦСАН БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД

1.2.10 Шатахуун хангалтын алба

Шатахуун хангалтын алба дараах барилга байгууламж, тоног төхөөрөмжүүдтэй үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд:
Шатахуун хадгалах босоо цилиндр 2000м^3-ийн 4 ширхэг ган сав, насосны станц, трансформатор, дизель цахилгаан үүсгүүрийн байр, 25м^3 савтай галын усан сан, тунадас хадгалах хэвтээ 10м^3 -ын далд байрлалтай сав 2 ширхэг, түлш суллах хэвтээ цилиндр 50м^3-ийн 1 ширхэг сав, агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах хэвтээ цилиндр 20м^3-1 савтай, харуулын байр, галын усан сан, хэвтээ сав парк, цэнэглэх талбай, шатахуун буулгах, ачих төхөөрөмж, ууршуулах талбай, цэвэрлэх байгууламж, галын гидрант, автомашины болон явган хүний зам талбай, сав парк өргөтгөлийн талбайтай.

Шатахуун хадгалах сав: Шатахууны агуулах нь 2 га талбайтай, ТС хадгалах Т-201, Т-202, Т-203, Т-204 маркийн 2000м^3-ийн 4 ширхэг савтай. Түлш суллах хэвтээ цилиндр D-503 маркийн 50м^3-ийн 1 ширхэг сав, агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах D-603 маркийн хэвтээ цилиндр 20м^3-ийн багтаамжтай 1 савтайгаар 2017 онд ашиглалтад орсон.




Зураг 15. Шатахууны агуулахын байгууламж. Агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах 20м3-ийн хэвтээ цилиндр ган сав

Т-201, Т-202, Т-203, Т-204 тус бүр 2000м^3-ын босоо цилиндр ган савыг 2016 онд листийн аргаар угсарч, савыг суллаж ёроолын бохирдлыг цэвэрлэж савны туршилт, сорилтыг хийсэн. Савыг усаар дүүргэж даралт өгч битүүмжлэл болон ачааллыг шалгасан бөгөөд савны тоног төхөөрөмжийн гагнуурын хэсгийг тусгай хөөсрүүлэгч уусмал ашиглан шалгаж сорилт туршилтыг хийсэн. Савны тойргийн дагуу 6м тутамд хазайлт, суултыг тодорхойлсон ба шалгалтаар сайн дүнтэй гарч, ашиглах боломжтой гэсэн дүгнэлт өгсөн.



Зураг 16. ТС-1 хадгалах 2000м3–ын босоо цилиндр ган сав

2000 м^3 босоо цилиндр ган савны үндсэн тоног төхөөрөмжүүдэд нягт, температур хэмжигч төхөөрөмж, цахилгаан автомат хаалт, амьсгалах хавхлага, хамгаалах хавхлага, шатахууны төвшин хэмжигч, температур хэмжигч, хэмжилтийн люк, дээж авах 3 хавхлага, хөөс, усаар бүтээгдэхүүний гадаргууг шүршин цацах шугам хоолой, орлого, зарлагын хоолой, автомат болон механик хаалтууд, цэвэрлэгээний люк, гэрлийн люк зэрэг орно. Орчин үеийн автомат хэмжилтийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон ба савны дүүргэлт, шатахууны температур, нягтыг автоматаар хэмжих хөвүүрт камертай. Савны төвшинг гурван төвшингээс хэмжих тоноглол, галын ус, хөөсний камер, дээж авах битүүмжлэлтэй тоног төхөөрөмжтэй.

Түлш суллах хэвтээ цилиндр D-503 маркийн 50м^3 багтаамжтай сав: Уг савны гэмтэл, аваар ослын үед сав суллах хэвтээ цилиндр түлш суллах D-503 маркийн 50м^3-ийн 1 сав байна. Түлш суллах хэвтээ сав нь аюулгүй үйл ажиллагааг хангасан хаалт, оч баригч, үл буцаах хавхлага, хэмжилтийн люк, амьсгалах клапан, автомат төвшин хэмжигч, орлого, зарлагын шугам хоолой, оч баригч, автомат хаалт зэрэг тоног төхөөрөмжүүдээс бүрдэнэ.

Агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах D-603 маркийн хэвтээ цилиндр 20м^3-ийн багтаамжтай 1 сав байна. Дизель түлш хадгалах сав нь ил байрлалтай ба бүтээгдэхүүний шүүрэлт гоожилтоос хамгаалж газар талбайг бетондсон. Гал гарсан тохиолдолд галын хөдөлгөөнт хэрэгсэлтэй, ус болон хөөсөөр унтраахаар тоног төхөөрөмж, шүүрэлт гоожилтыг шингээж авах эсгий, элс агуулсан тоног төхөөрөмжийг ойролцоо байрлуулсан



Зураг 17. Түлш суллах хэвтээ цилиндр Т-503 маркийн 50м3-ийн сав

Насосны станц: Түлшний агуулах нь газрын тос, газрын тосны бүтээдэгдэхүүний агуулахын барилга, байгууламжийн гал тэсвэржилтийн зэргээр III зэрэглэлд хамаарна. III зэрэглэлийн агуулахын хувьд БНбД 21-03-04 насос станцын барилга дотор дизель цахилгаан үүсгүүрийг байрлуулахыг зөвшөөрдөг. Энэ тохиолдолд нэг төрлийн

хэрэгцээнээс илүүгүй багтаамж бүхий түлшний савыг барилгын цул ханын гадна талд, эсхүл шатдаггүй материалаар хийсэн байгууламжид суурилуулна.

Түлшний агуулах нь 2017 онд ашиглалтад орсон гидрант насос P-301, P-302, P-303, P-304 маркийн 227м^3/цаг хүчин чадалтай 4 ширхэг, сав хоорондын D-503 маркийн 50м^3/цаг 1 ширхэг насостай. БНбД 21-03-04 агуулахын галын аюулгүйн байршлын стандартын 7.4 дүгээр заалтын дагуу тус агуулахын насосны станцын барилгын насосны тэсрэлтээс хамгаалагдсан цахилгаан хөдөлгүүр болон дотоод шаталтат хөдөлгүүрийн өрөө нь насосны өрөөнөөс 1 төрлийн галаас хамгаалах цул ханаар тусгаарлагдан хийгдсэн байна.



Зураг 18. Шатахууны агуулахын насосны станц

Галын усан сан: ТС түлш хадгалах 2000м^3-ийн багтаамжтай савнууд нь сав хөргөх суурин төхөөрөмжөөр тоноглогдсон. Савны дээд бүсэд байрлах, тодорхой хэсгүүдэд хуваагдсан, ус шүрших (усыг тойруулан шүрших хэрэгслээр тоноглогдсон хоолой) цагираг, цагиргийг галын ус дамжуулах хоолойтой холбогдсон босоо болон хэвтээ хуурай хоолойнууд, гар ажиллагаатай хаалтуудаас бүрддэг. Систем нь гал түймэр гарсан тохиолдолд савны байрлалаас хамааруулан савны гадаргууг бүтнээр, хагасыг болон дөрөвний нэгийг хөргөх





Зураг 19. Галын усан сан, Сав хөргөх, усан хөшиг үүсгэх тоног төхөөрөмжийг байрлуулсан байдал

боломжтой байна. Галын усан сан нь 500м^3/цаг далд байрласан галын усан сантай, гүний усаар хангагддаг. БНбД21-03-04 агуулахын галын аюулгүйн норм дүрмийн 8.6 дугаар заалтын дагуу 1000-3000м^3-ын багтаамжтай шатахуун хадгалах савнуудад хөөсний генератор суурилуулж галын техник хэрэгсэл холбох зориулалтын хэрэгсэл бүхий төгсгөлийг нь далангийн гадна гаргасан хоолойд холбосон.

Шатахуун ачих буулгах байгууламж: БНбД21-03-04 ын 5.7, 5.8 зэрэг заалтын дагуу ачиж буулгах хэсгийн талбай нь ус үл нэвтрэх хатуу гадаргуутай, 0.2м-ээс багагүй өндөр хашлагаар битүү хүрээлэгдсэн, шингэнийг бохирын суваг, цуглуулга урсгах зориулалтаар 2 хувиас багагүй налуутайгаар хийгдсэн.

Ачих буулгах байгууламжийн тавцангийн шатнуудыг тавцангийн 2 төгсгөл, шулуун хэсэгт хоорондоо 100м-ээс илүүгүй зайд байрлуулна. Шатны өргөн нь нь 0.7м-ээс багагүй, 1:1-ээс илүүгүй өгсүүр зэрэг заалтыг шаардлага хангасан байна. Тус агуулах нь Z-106 маркийн 2300 л/мин, Z-101 маркийн 1900 л/мин, Z-102 маркийн 1900 л/мин, Z-103 маркийн 2300л/мин ачих, буулгах хүчин чадалтай 4ш төхөөрөмжөөс бүрдэнэ.

Агаарын хөлгийг сумлах ажиллагаа нь зорчигч үйлчилгээний барилгын агаарын хөлгийн зургаан зогсоол дээр байрлах арван дөрвөн ширхэг гидрантын хавхлагаас түлш түгээх зориулалтын диспенсэр авто машинаар хийгдэнэ.


Нэг худаг нь нэг минутад 1,000 галлон буюу 3,780 литр хүртэл шахах техникийн хүчин чадалтай. Гурван агаарын хөлөгт нэгэн зэрэг сумлагаа хийх боломжтой.




**Зураг 20. Шатахуун ачих буулгах байгууламж,
Агаарын хөлгийн судалгаа**

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт дүн (төг)	Биелэлт
1. Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК						
1.	Дулааны станцын үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл	Бохирдуулагч хийн ялгаралтад хяналт тавьж шаардлагатай тохиолдолд бууруулах арга хэмжээ авах	Дулааны цахилгаан станцын яндангаас 400 м дотор	Тогтмол хэрэгжиж буй (халаалтын улиралд)	-	"Күзмен тайж" ХХК-тай хийгдсэн "Худалдах, худалдан авах" гэрээгээр дулааны станцын нүүрсийг нийлүүлж байна. Нүүрсний шаталтаас шалтгаалсан бохирдуулагч үүсэхээс урьдчилан сэргийлж, дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нийлүүлэгдэж байгаа нүүрсний чанарыг 2022 оны 09 дүгээр сараас эхлэн сар бүр хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж, дүгнэлт гаргуулж байна. (Нүүрсний шинжилгээний хариуг хавсаргав "НУБИЭ" ХХК Хавсралт 1/1-4 дүгээр хуудас)
		Утааны яндангийн уутат шүүлтүүрийн хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангаж ажиллах, тогтоосон хугацаанд солих		Тогтмол хэрэгжиж буй (халаалтын улиралд)	-	Дулааны станцын зуухны бэлэн байдал, утааны яндангийн уутат шүүлтүүрийн хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд халаалтын улирлын хугацаанд 3 зуухыг ажиллахуулахын өмнө уутат шүүлтүүрийг 2-3 удаа шалгаж, шаардлагатай тохиолдолд солих арга хэмжээ авч ажиллаж байна.
2.	Дулааны цахилгаан станцын үнсний тархалтаар орчин бохирдох	Дулааны станцын нүүрс хадгалах талбайг битүүмжлэлтэй болгох		Төлөвлөж буй	-	Нүүрс хадгалах талбайг битүүмжлэх зураг төсөл боловсруулсан. 2023 оны 07 дугаар сард хийж дуусахаар төлөвлөж байна. .

			Барилгажих талбай болон эвдрэл доройтолд өртсөн, бохирдол үүсэх эх үүсвэрүүдэд			 Нүүрсний талбай битүүмжлэх план зураг
3.	Хөрс, ургамалан бүрхэвчийн элэгдэл, эвдрэл бохирдол	Төлөвлөлтийн дагуу цаашид барилга байгууламж баригдахгүй болон үйл ажиллагаанд өртөөгүй талбайг доройтуулахгүйгээр хамгаалж, хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдолт үүсэхээс урьдчилан сэргийлэх		Тогтмол хэрэгжиж буй		2022 оны 12 дугаар сард Улсын комисст хүлээлгэн өгөх 2 барилгын ажил Концессын талбайд (Нисэх буудлын орчимд) явагдаж байна. 1) Захиалагч: Гаалийн ерөнхий газар, Гүйцэтгэгч: Хилийн цэргийн 0119 дүгээр анги, "Хил, гаалийн нэг цэгийн үйлчилгээний барилга", 2) Захиалагч: Монгол шуудан ХК, Гүйцэтгэгч: Томо бьюлдинг ХХК, "Шуудан илгээмжийн үйлчилгээний барилга". Хуулсан хөрсийг Дулааны станцын орчинд үерийн хамгаалалтын далан барьж ашигласан. Тухайн барилгажилтын ажил хийгдсэн газруудын орчинг нөхөн сэргээж, Барилгын ажил дууссаны дараа цэвэрлэгээ, зүлэгжүүлэлт, асфальт зам талбайн ажил хийгдэнэ.
4.	Хөрс, ургамалан бүрхэвчийн элэгдэл, эвдрэл бохирдол	ОХШХ-ийн дагуу дээж авах, хэмжилт хийлгэх, шаардлагатай тохиолдолд үр дүнд үндэслэн арга хэмжээ авах				Хөрсний нянгийн шинжилгээг орчны хяналт шинжилгээний хэсгээс харна уу.

5.	Төслийн усны хэрэглээнээс газар доорх усны нөөцийн хомсдол үүсэх	Усыг зүй зохистой хэрэглэх санамж, анхааруулга, мэдээллийг түгээх, хэрэгжүүлэх	Усан хангамжийн эх үүсвэр бүрт	Бүрэн хэрэгжсэн	-	Усны зохистой хэрэглээний санамж анхааруулга, мэдээллийг НУБИЭ ХХК-ийн ажилтнуудад болон олон нийтэд хүргэсэн. Үүнд: - "Цэвэр бохир усны үйлчилгээ хэрэглэгч танд хэрхэн хүрдэг вэ?", "Бохир ус түүнийг хэрхэн цэвэрлэдэг вэ?" видео бичлэгүүд, "Гүний ус түүний үнэ цэнэ, үнэлэмж"-ийн талаар уриалга бүхий постерыг НУБИЭ ХХК-ийн фейсбүүк, kaizala, болон компанийн вэб сайтаар ажилтнууд болон олон нийтэд сурталчлах ажил хийгдсэн.  - 2022 оны 03 дугаар сарын 25-аас 4 дүгээр сарын 05-ны хооронд НУБИЭ ХХК-ийн ажилтнуудын хүүхдүүдийн дунд "Газрын доорх ус түүний үнэ цэнэ" сэдэвт гар зургийн уралдаан зохион байгуулсан.  - 2022 оны 06 дугаар сарын 04-ний өдөр "Газрын доорх ус, түүний үнэ цэнэ" сэдвийн дор "Нисэх

						буудлын үйл ажиллагаа"-г танилцуулах ажлыг зохион байгуулсан. Гар зургийн уралдаанд бүтээлээ ирүүлсэн 3-16 насны 50 хүүхэд оролцсон (3-6 насны хүүхдүүд асран хамгаалагчдын хамт). (Ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг хавсаргав, "НУБИЭ" ХХК Хавсралт 1/5-7 дугаар хуудас)
		Харьяалагдах сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр хийж байх		Тогтмол хэрэгжиж буй	-	"Туул голын сав газар"-тай "Ус ашиглах гэрээ" байгуулсан. Ус ашигласны төлбөрийг Төв аймгийн Байгаль орчны газарт төлдөг ба 2022 оны төлбөрийг жилийн эцсийн усны хэрэглээний тайлан гарсны дагуу Төв аймгийн Байгаль орчны газрын мэргэжилтэнтэй хамт акт үйлдэн төлбөрийг төлөх учир 2021 оны актыг хавсаргав. (2021, 2022 оны гэрээ, 2021 оны актыг хавсаргав, "НУБИЭ" ХХК Хавсралт 1/8-13 дугаар хуудас)
		Усны тоолуурын баталгаажуулалтыг тогтоосон хугацаанд хийх		Тогтмол хэрэгжиж буй	109 000₮	Усны тоолуурын баталгаажуулалт хийгдсэн. 2023.08.11-нд хугацаа дуусна. (Тоолуурын баталгаажуулалтын хуудсыг хавсаргав, "НУБИЭ" ХХК Хавсралт 1/14-16 дугаар хуудас)
		Усны чанар, нөөцийн мониторинг: Горимын үзүүлэлт хэмжих багажтай болох ОХШХ-ын дагуу хяналт хийх Техникийн шаардлагыг тодорхойлох, судалгаа хийх		Төлөвлөж буй	-	Газрын доорх усны хяналт шинжилгээний төхөөрөмжийг барилга байгууламжийн хамт 2024 оны 12 дугаар сараас өмнө суурилуулахаар төлөвлөж, дараах судалгаа хийгдэж байна. - Гүний ус ашиглалтын одоогийн байдлыг хянах, - Ус ашиглалтын зөв зохистой горимд шилжих, - Газрын доорх усыг зохиомлоор бохирдож буй эсэхийг хянах, - Ашиглалтад бэлтгэгдсэн газрын доорх усны байгалийн горимын суурь мэдээллийг авах, -
6.	Ус бохирдож улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Усны эх үүсвэрийг хамгаалсан хашаа, тэмдэгжүүлэлтийг эвдэрсэн тохиолдолд засаж	Ус хангамжийн	Тогтмол хэрэгжиж буй	-	Усны эх үүсвэрийн (гүний худгийн) эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн дэглэмийн ойр орчимд хог хаягдал, шатах тослох материал үүсэх, асгарч


		сайжруулах, хянах	эх үүсвэр бүрт			алдагдсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээ авах, хамгаалалтын хашаа, тэмдэгжүүлэлтийн бүрэн бүтэн байдлыг ус хангамжийн ээлжийн ажилчид өдөрт 1 удаа үзлэг шалгалт хийж, 24 цагийн турш камерын хяналт тавьж байна. Хяналтаар: - Гэмтэл, доголдол илрээгүй, - Гүний усны чанарт нөлөөлөлх бохирдуулагч эх үүсвэргүй, - Хүчдэл хэвийн, - Халаагч тений ажиллагаа хэвийн, - Хашаа, хамгаалалт бүрэн бүтэн (Цэвэр ус хангамжийн байгууламжийн ажилтнуудын 1 өдрийн ажлын тайлан, "НУБИЭ" ХХК Хавсралт 1/ 17-19 дүгээр хуудас)
7.	Хур бороо, үерийн усаар төслийн талбай дахь хог хаягдал, шатах тослох материалын үлдэгдэл угаагдан хөрсөнд нэвчиж газрын доорх усны чанар, найрлагад өөрчлөлт оруулж бохирдуулах	Шатах тослох материал алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд болон машин техникийн бүрэн бүтэн байдал, хог хаягдлын хадгалалтад тогтмол хяналт тавих, асгарч алдагдсан тохиолдолд ашиглах шаардагдах хэрэгсэл, материалыг бэлтгэх, бэлэн байлгах	Ус хангамжийн эх үүсвэр бүрт	Тогтмол хэрэгжиж буй	-	Усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд ус хангамжийн ээлжийн ажилчид өдөр бүр үзлэг шалгалт хийж, хяналт тавьж ажиллаж байна. Ундны усны эх үүсвэрийн ойр орчимд хог хаягдал үүсэх, шатах тослох материал алдагдах, болзошгүй тохиолдолд ашиглах шаардлагатай багаж хэрэгслийг бэлэн байдалд байлгаж байна. Өдөр бүрийн үзлэгийн үр дүнгээр ямар нэгэн зөрчил илрээгүй, үйл ажиллагаа хэвийн байна.
8.	Бохир ус асгарч гадаргын уст цэгүүдийг бохирдуулах, хөрсөнд нэвчиж газрын доорх усны чанар, найрлагад өөрчлөлт оруулж бохирдуулах	Цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж, шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж, аюулгүй ажиллагааг сайтар сахин ажиллах	Цэвэрлэх байгууламж, бохирын худгууд	Тогтмол хэрэгжиж буй	1 200 000₮	"Бохир усны 1,9 км гадна шугам сүлжээг КО-829А машинаар угаах хуваарь"-ийн дагуу цэвэрлэгээг хийж, шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг хангаж, бохир ус асгарч хөрсөнд нэвчихээс урьдчилан сэргийлж ажилласан. (Хуваарийг хавсаргав, "НУБИЭ" ХХК-ийн Хавсралт 1/ 20-21 дүгээр хуудас)
9.	Хүрээлэн буй орчинд агаар болон хөрсний бохирдол үүсгэх	-Цэвэрлэх байгууламжаас гарах лагийг бордоо болгон ургамал, зүлэг тарьж турших -Цэвэрлэх байгууламжаас	Нисэх буудлын цэвэрлэх байгууламж	Туршилтын ажил хийгдэж байна, ирээдүйд	-	Монгол Улсын Их Сургуулийн Хүрээлэн буй орчны инженерчлэл, цэвэр технологийн лабораторитой хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, судалгааны ажлын төсөл боловсруулах,

		гарах лагаар түлш хийж турших		тогтмол хийгдэнэ		хэрэгжүүлэх, дадлага сургуулилт зохион байгуулах, байгаль орчны зөвлөх, туслах үйлчилгээ үзүүлэх чиглэлүүдээр хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд цэвэрлэх байгууламжийн лагийг бордоо болгох туршилтын ажлыг 2022.09.20-2022.10.18-ны өдрүүдэд хийсэн. Гадна агаарын температур буурснаас шалтгаалан тодорхой үр дүн гараагүй. МУИС-ийн лабораторид турших бэлтгэл ажил үргэлжлэн хийгдэж байна.   (Санамж бичгийн хуулбарыг хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 1/ 22-25 дугаар хуудас)
10.	Хүрээлэн буй орчны бохирдол, хүн мал амьтанд сөрөг нөлөө үзүүлэх	Хаягдал усны зөвшөөрөл дүгнэлт гаргуулах	Нисэх буудлын орчимд, Бөхөгийн гол, Зуунмод голд нийлэх цэг	Улирал тутамд тогтмол хэрэгжиж буй	301 676₮	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу Усны газраар Хаягдал усны дүгнэлт гаргуулсан. Туул голын сав газрын захиргаанаас ус хаях зөвшөөрөл авсан. 2022 оны 1, 2, 3 дугаар улирлын ус бохирдуулсны төлбөрийг төлсөн. Одоогийн байдлаар нисэх буудлын хэмжээнд цэвэрлэх байгууламжаас гарсан цэвэрлэгдсэн бохир усыг дараах байдлаар дахин ашиглаж байна. Үүнд: 1) аэродромын зам талбайн цэвэрлэгээ, 2) онгоцны бохир тээвэрлэгч машины ёмкостын цэвэрлэгээ, 3) цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, 4) цэвэрлэх байгууламжийн ариун цэврийн өрөөний суултуурын усанд. 2022 оны 09-12 сард нийт 390.1 м3 цэвэрлэгдсэн бохир усыг дахин ашигласан (Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ, тооцоог хавсаргав, “НУБИЭ” ХХК Хавсралт 1/26-33 дугаар хуудас)

11.	Хүрээлэн буй орчны бохирдол, нисэх буудлын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх	Цэвэрлэгдсэн усны гаргалгааны сувгийн уклон тохируулах	Цэвэрлэгдсэн усны гаргалгааны хэсгээс Зуунмод гол хүртэл хэсэгт	Төлөвлөж буй	-	 Гаргалгааны сувгийн уклон тохируулах ажил 2022 оны 10 дугаар сард хийгдэж эхэлсэн. Нисэх буудлын баруун урд хэсгийн гаргалгааны шугамаас бетон далан хүртэл 600 метрт газар шорооны ажил эхэлсэн ба гадна агаарын температуртай уялдуулан уг ажлыг 2023 оны хавар дуусгахаар түр зогсоосон.
	НУБИЭ ХХК Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний Биелэлтийн нийт дүн (төг)				**1 610 676₮**	


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй	Нийт дүн (төг)	Биелэлт
2. ИНЕГ, ИНҮТ-ИЙН "ЧХОУНБ" ДАХЬ ШАТАХУУН ХАНГАЛТЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА						
1.	Шатахууны агуулахаас үүсэх агаарын бохирдол	Техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны хяналт	Шатахууны агуулахын орчим	Тогтмол хэрэгжиж буй	-	Шатахууны агуулахын сав түүний тоноглолын битүүмжлэл өндөр түвшинд хангагдсан, шатахууны ууршилтгүй. Сар бүр JIG-2 стандартын дагуу үзлэг шалгалтыг гүйцэтгэж, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна. (Агуулахын нийт 69 тоног төхөөрөмжид сар тутам хийсэн үзлэгийн хуудсыг хавсаргав) Шатахууны агуулахын сав түүний тоноглолын битүүмжлэл өндөр түвшинд хангагдсан учир шатахууны ууршилтгүй. Улирал бүр JIG-2 стандартын дагуу үзлэг шалгалтыг гүйцэтгэж, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна. (Агуулахын нийт 47 тоног төхөөрөмжид улирал тутам хийсэн үзлэгийн хуудсыг хавсаргав) ("ИНЕГ, ИНҮТ-ийн ЧХОУНБ дахь Шатахуун хангалтын алба" Хавсралтууд 1-3 дугаар хуудас)

2.	Цэнэглэх үеийн агаарын бохирдол	Зураг авалтаар гарсан дүнд үндэслэн шатахууны агуулахыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглох	Шатахууны агуулахын орчим	Тогтмол хэрэгжиж буй		 Агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх тоног төхөөрөмж нь битүүмжлэл сайтай сүүлийн үеийн технологитой. Шатахууны ууршилтгүй сумлагааг гүйцэтгэж, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.  Агаарын хөлөг шатахуунаар цэнэглэх сумлагч автомашинд шатахуун ачих тоног төхөөрөмж нь доогуур ачилтийн хоолойтой, торхны дээд люкний битүүмжлэл сайтай. Шатахууны ууршилтгүй ачилтыг гүйцэтгэж, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.

3.	Түлшний шаталтаас үүсэх хийгээр агаар бохирдох	Тээврийн хэрэгслүүдийн ашиглалтын үеийн засвар үйлчилгээг тогтмол хийх, шатах тослох материалын чанарын үзлэгийг хийж, холбогдох арга хэмжээг авах	Шатахууны агуулахын орчим	Тогтмол хэрэгжиж буй	-	Тээврийн хэрэгслүүдийн ашиглалтын үеийн засвар үйлчилгээг тогтмол хийж, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна Үйл ажиллагаанд ашиглагдаж буй нийт тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээг бүртгэлжүүлэн, баталгаажуулан ажиллаж байна. (Жишээ болгон 43-71УАВ сумлагч автомашины үзлэг, үйлчилгээний тэмдэглэлийн дэвтэр, 1184УН сумлагч автомашины техник ашиглалтын паспортыг хавсаргав.) ("ИНЕГ, ИНҮТ-ийн ЧХОУНБ дахь Шатахуун хангалтын алба" Хавсралтууд 4-7 дугаар хуудас)
4.	Газрын тосны бүтээгдэхүүний агуулахаар хөрс бохирдох	Шатахууны агуулахад хийсэн зураг авалтын үр дүн, зөвлөмжийг дагаж ажиллах	Шатахууны агуулахын орчим	Тогтмол хэрэгжиж буй	-	 Газрын тосны бүтээгдэхүүнээр бохирдсон ус цуглуулах системийн байгууламжтай. Шатахуун асгарсан тохиолдолд хөрс, гүний усанд нэвчихгүйгээр зориулалтын худгууд, хоолойгоор дамжин тос ялгах сеператорт газрын тосны бүтээгдэхүүн ялгаран үлдэж, ууршуулах талбай руу шүүгдсэн ус орж ууршдаг. Шатахуун асгарсан тохиолдол гараагүй, технологийн үйл ажиллагааг чанд мөрдөн ажиллаж байна.

ХУУДАСНЫ ТОО: 2

САНАМЖ: *Шинжилгээний үр дүн нь лабораторид ирүүлсэн тухайн сорьцод хамаарна. Лабораторийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлахыг хориглоно.*

БАТАЛСАН:

Н.Ганзориг
Химийн лабораторийн Менежер: /Гарын үсэг/ И-майл: Ganzorig@truetrc.mn

ХЯНАСАН:

Г.Уганцэцэг
Аргачлал хяналтын Инженер: /Гарын үсэг/ И-майл: Uugantsetseg.g@truetrc.mn

ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: *Л.Даваацэцэг*

Манай байгууллагаар үйлчлүүлсэнд баярлалаа

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Дээжний тодорхойлолт	Лаб №	Техникийн шинжилгээний дүн								
			Чийглэг,%		Үнслэг,%		Дэгдэмхий бодисын гарц,%		Нийт хүхэр,%	Илчлэг, ккал/кг	
			M^t	M^{ad}	A^{ad}	A^{ar}	V^{ad}	V^{daf}	S^{ad}	Q^{ar}	Q^{ar}
			MNS ISO 589:2003		MNS ISO 1171:2009		MNS ISO 562:2001		MNS ISO 351:2001	MNS ISO 1928:2009	
1	Нүүрс	Ch-79	28.19	1.34	22.64	18.48	34.22	45.01	0.63	5160	3750

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ TL 40-63

Хуудас 2

1. **Усыг зүй зохистой хэрэглэх санамж, анхааруулга, мэдээллийг түгээх, хэрэгжүүлэх ажлын хүрээнд доорх төлөвлөгөөний дагуу ажлууд хийгдсэн болно.**

"ДЭЛХИЙН УСНЫ ӨДӨР 2022"-ЫГ ТОХИОЛДУУЛАН НУБИЭ ХХК-ААС ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах хэсэг
1	**"Цэвэр бохир усны үйлчилгээ хэрэглэгч таньд хэрхэн хүрдэг вэ?", "Бохир ус түүнийг хэрхэн цэвэрлэдэг вэ?"** видео бичлэгүүдийг НУБИЭ ХХК-ийн фэйсбүүк хуудас болон Компанийн вэб сайтад Усны зохицуулах зөвлөлийн веб сайтаас татан авч байршуулах	3-р сарын 22	Төлөвлөлт зохицуулалтын газрын Нисэх буудлын төлөвлөлтийн хэлтэс, Инженер, техникийн газрын Дулаан, ус хангамжийн хэлтэс
2	"Гүний ус түүний үнэ цэнэ, үнэлэмж"-ийн талаар уриалга бүхий постерыг фэйсбүүк хуудас болон kaizala, all-имэйл хаягаар нийтэд сурталчилах, түгээх	3-р сарын 22	
3	НУБИЭ ХХК-ийн ажилтнуудын хүүхэд багачуудын дунд "Газрын доорх ус түүний үнэ цэнэ" сэдэвт гар зургийн уралдааныг зохион байгуулах	3-р сарын 25 4-р сарын 05	
4	GoGo.mn мэдээллийн сайттай хамтран тус вебсайт болон НУБИЭ ХХК-ийн вебсайтаар дамжуулан олон нийтэд мэдээ, мэдээллийг түгээх /14 хоног тутам/	3-р сарын 25- 6-р сарын 22	



Дээрх төлөвлөгөөний дагуу Газрын доорх усны үнэ цэнийн сэдэвт зургийн уралдаан зарлаж уралдаанд ирсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гарган байгаа үеийн зураг

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал

“Газрын доорхи ус, түүний үнэ цэнэ”сэдвийн дор “Нисэх буудлын үйл ажиллагааг” танилцуулах ажлын удирдамж, хөтөлбөр

2022.04.18 **Төв аймаг**

Зорилго

НУБИЭ ХХК-ны ажилтнуудын хүүхдүүдийн дунд Нисэх буудлын үйл ажиллагааг сурталчилах, нисэх буудлын бүтээн байгуулалт, цэвэр усны байгууламж, бохир усыг цэвэрлэх үйл ажиллагааг танилцуулах.

Оролцогчид

- “НУБИЭ”ХХК-ийн Инженер техникийн газрын инженер, техникийн ажилчид
- Гар зургийн уралдаанд бүтээлийг ирүүлсэн 3-16 насны 50 хүүхэд (3-6 насны хүүхдүүд асран хамгаалагчдын хамт)

Хугацаа

2022 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн /бямба гариг/ 09:00-13:00 цаг

“Нисэх буудлын үйл ажиллагааг танилцуулах” хөтөлбөр

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Байрлал	Хариуцах ажилтан
1	Зочдыг хүлээн авах, бүртгэх	09:00	Захиргааны барилгын 1 давхарт төв хаалган дээр	Инженер, техникийн газар, Дулаан ус хангамжийн хэлтэс
2	Нисэх буудлын үйл ажиллагааны танилцуулга хийх	09:10-09:25	Захиргааны барилгы 2 давхар 204 тоот	Инженер, техникийн газар
3	Ус цэвэршүүлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцуулах	09:30 09:50	Ус цэвэршүүлэх байгууламж	Инженер, техникийн газар, Дулаан ус хангамжийн хэлтэс
4	Гал унтраах албаны машин, техник хэрэгсэлтэй танилцуулах	09:35 10:00	Гал унтраах алба	Инженер, техникийн газар, Дулаан ус хангамжийн хэлтэс, Гал унтраах ангийн ээлжийн ахлах
5	Газрын үйлчилгээний газрын машин, техник хэрэгслийг танилцуулах	10:05 10:35	Газрын үйлчилгээний газар	Инженер, техникийн газар, Дулаан ус хангамжийн хэлтэс

				Газрын үйлчилгээний албаны ээлжийн инженер
6	Бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцуулах	10:35-10:55	Бохир ус цэвэрлэх байгууламж	Инженер, техникийн газар, Дулаан ус хангамжийн хэлтэс
7	Үдийн цай	10:55-11:05		
8	Аэродромын машин, техник хэрэгслийг танилцуулах	11:05-11:35	Аэродромын барилга	Инженер, техникийн газар, Дулаан ус хангамжийн хэлтэс Аэродромын ээлжийн инженер
9	МИАТ ХК Ангарын байгууламж, онгоцтой танилцах	11:35-12:05	Ангарын барилга	Инженер, техникийн газар, Дулаан ус хангамжийн хэлтэс
10	Зорчигч үйлчилгээний барилгын танилцуулга, дурсгалын зураг татуулах	12:10-12:30	Зорчигч үйлчилгээний барилга	Инженер, техникийн газар, Дулаан ус хангамжийн хэлтэс
11	Зочдыг үдэж өгөх	12:30	РТВ 2 давхарын төв хаалган дээр	Инженер, техникийн газар, Дулаан ус хангамжийн хэлтэс

Зохион байгуулагчид:

Ерөнхий зохион байгуулагч: Инженер, техникийн газрын

Хамтран зохион байгуулагч: Газрын үйлчилгээний газар, Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын

газар, МИАТ ТӨХК"

БАТЛАВ
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ОЮУНБОЛД

2021 оны 05 дугаар сарын ...

БАТЛАВ
"НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ
ЭЙРПОРТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

ТАКЕО КАТО

2021 оны 05 дугаар сарын ....

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар УНТ 21/20

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу "Усны газар"-ын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 05/304 дугаартай албан бичгээр ирүүлсэн Дугаар 56 "Ус ашиглуулах дүгнэлт, Туул голын сав газрын захиргааны даргын 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/22 дугаар тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны дарга Ю.Сувдчимэг, Ус ашиглагчийг төлөөлж Төв аймаг, Сэргэлэн сум, Эрдэнэ-Уул 4-р баг, Тахилт толгой, улсын бүртгэлийн 1411011101 тоот гэрчилгээ, 3874095 тоот регистрийн дугаартай "Нью Улаанбаатар интернэшнл эйрпорт" ХХК-ийн Дулаан, ус хангамжийн менежер Б.Баттөр нар ус ашиглах талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 2021 оныг дуустал байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. *Ус ашиглах зориулалт:* Олон улсын шинэ нисэх буудлын дулаан үйлдвэрлэл болон унд, ахуйн хэрэгцээнд газрын доорх усны нөөцийг ашиглана.

2.2. *Нийт ашиглах усны хэмжээ:* 255'589.7 м³/жил
2.2.1. Унд-ахуйд: 17'903.3 м³/жил;
2.2.2. Дулаан үйлдвэрлэхэд: 237'686.4 м³/жил.

2.3. *Усны чанар, найрлага:* Гүний худгийн болон цэвэрлэх байгууламжаас гарч буй хаягдал бохир усны дээж авч байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнг ус ашиглалтын тайланд хавсарган Туул голын сав газрын захиргаанд ирүүлнэ.

2.4. *Усны эх үүсвэр:*
2.4.1. *Байршил:* Унд-ахуйн усны хэрэгцээний усыг Өөрийн эзэмшлийн худгаас авч хэрэглэнэ.

Зориулалт	*Солбицол*	*Гүн, метр*	*Үндаргэ, л/сек*	*Гаргасан он*	*Тоолуур марк*	*Насос марк*
Худаг №1	*47°37'38.8",106°51'29.7"*	*70.0*	*10.0*	*2017*	*M16-80*	*EBARA HBE6*
Худаг №2	*47°37'38.8",106°51'29.7"*	*70.0*	*12.0*	*2017*	*M16-80*	*EBARA HBE6*
Худаг №3	*47°37'39.6",106°51'25.1"*	*70.0*	*11.4*	*2017*	*M16-80*	*EBARA HBE6*

2.4.2. *Барилга байгууламж:* Ундны усыг шүүж, халдваргүйжүүлэх 800 м³/хон. хүчин чадалтай цэвэр ус хангамжийн байгууламжтай. Нийт 1'110 м³ багтаамжтай 3 ширхэг ус нөөцлөх сантай.

2.4.3.Тоног төхөөрөмжийн нэр, марк, *насосны хүчин чадал:* Цэвэр ус дамжуулах шугамын урт 4 451м урт. 125 мм голч бүхий хуванцар шугам сүлжээтэй. *EBARA-HBE6 маркийн насос суурилуулсан.*

2.5. *Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага:* Хаягдал усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартын шаардлагыг мөрдлөг болгоно. Стандартаас давсан агууламжтай хаягдал усыг байгальд нийлүүлж буй тохиолдолд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ын дагуу төлбөр тооцно.

2.6. *Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:*

2.6.1 Бохир ус цэвэрлэх байгууламж нь хоногт 800 м³ усыг 96%-98% хүртэл цэвэрлэх хүчин чадалтай. Хэрэглээнээс гарсан ахуйн бохир усыг 2 сувагт хүлээн авч механик, биологийн цэвэрлэгээг хийж, "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартын шаардлагад нийцүүлэн байгальд нийлүүлдэг.

2.7. *Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:* Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2.8. *Усны тоолуур:* Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ыг хэрэгжүүлж ажиллана. Тоолуурын заалтын тэмдэглэлийг тогтмол хөтөлж, баталгаажуулна.

2.9. *Ус ашигласны төлбөрийн хэмжээ:*

2.9.1. Дулаан үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах 237'686.4 м³ газрын доорх усны нөөц ашигласны төлбөрт 16'828'197 /Арван зургаан сая найман зуун хорин найман мянга нэг зуун ерөн долоон/ төгрөгийг Тев аймгийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ. Төлбөрийн 40 хувийг хоёрдугаар, 40 хувийг гуравдугаар, 20 хувийг дөрөвдүгээр улиралд төлнө.

2.9.2. Гэрээнд зааснаас хэтрүүлэн ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 391 дүгээр тогтоолоор батлагдсан "Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам"-д заасны дагуу төлбөр тооцно.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүгээр зүйлийн 29.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын захиргааны шийдвэрээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд жил бүрийн ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээг тухайн оны эхний улиралд багтаан байгуулна.

4.3. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ.

9

4.4. Талуудын хооронд үүссэн маргааныг зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд гэрээ болон түүний аль нэг заалттай холбоотой асуудлаар зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд асуудлыг холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.5. Тайлант оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлдэг ус ашиглалтын тайланг үндэслэн гэрээ дүгнэсэн тэмдэглэлийг 2 хувь үйлдэн баталгаажуулах бөгөөд гэрээнд заасан төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд дараа оны гэрээ хийгдэхгүй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААГ ТӨЛӨӨЛЖ:	"НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:
Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны дарга	Инженер техникийн газрын дарга
Ю.СУВДЧИМЭГ	МОРИТО КАЗУНОРИ
Мэдээлэл, хяналт шалгалтыг зохицуулах албаны ахлах мэргэжилтэн	Цэвэр ус хангамжийн инженер
Б.БАТ-ЭРДЭНЭ	Ч.МӨНХЖАРГАЛ
Хаяг: Улаанбаатар хот-16050, БГД, 2-р хороо, Чингүнжавын гудамж, Туул голын сав газрын захиргааны байр, 203 тоот өрөө. Харилцах утас: 7000-3716, 7000-3714	Хаяг: Төв аймаг Сэргэлэн сум, 4-р баг, Эрдэнэ уул, Тахилт толгой Харилцах утас: 7728-7376,7728-6300 Цахим хаяг: munkhjargal.ch@nubia-llc.mn

БАТЛАВ
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ОЮУНБОЛД
2022 оны 03 дугаар сарын 05

БАТЛАВ
"НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ
ЭЙРПОРТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
ТАКЕО КАТО
2022 оны 03 дугаар сарын 29

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар УНТ 22/12

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, "Усны газар"-ын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 05/234 дугаартай албан бичгээр ирүүлсэн Дугаар 25 "Ус ашиглуулах дүгнэлт", Туул голын сав газрын захиргааны даргын 2022 оны 03 дугаар сарын 05 -ны өдрийн А/ 10 дугаар тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн П.Энхбаяр, Ус ашиглагчийг төлөөлж Төв аймаг, Сэргэлэн сум, Эрдэнэ-Уул 4-р баг, Тахилт толгой, улсын бүртгэлийн 1411011101 тоот гэрчилгээ, 3874095 тоот регистрийн дугаартай "Нью Улаанбаатар интернэшнл эйрпорт" ХХК-ийн Усны нөөцийн ахлах инженер Б.Мягмарсүрэн нар ус ашиглах талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. *Ус ашиглах зориулалт:* Олон улсын шинэ нисэх буудлын дулаан үйлдвэрлэл болон унд, ахуйн хэрэгцээнд газрын доорх усны нөөцийг ашиглана.

2.2. *Нийт ашиглах усны хэмжээ:* 491'486.4 м³/жил
- 2.2.1. Унд-ахуйд: 109'500.0 м³/жил
- 2.2.2. Дулаан үйлдвэрлэхэд: 237'686.4 м³/жил;
- 2.2.3. Ногоон байгууламжийн усалгаанд 120'000.0 м³;
- 2.2.4. Галын аюулгүй байдлыг хангахад 24'300.0 м³.

2.3. *Усны чанар, найрлага:* Гүний худгийн болон цэвэрлэх байгууламжаас гарч буй хаягдал бохир усны дээж авч байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнг ус ашиглалтын тайланд хавсарган Туул голын сав газрын захиргаанд ирүүлнэ.

2.4. *Усны эх үүсвэр:*

2.4.1. *Байршил:* Унд-ахуйн усны хэрэгцээний усыг Өөрийн эзэмшлийн худгаас авч хэрэглэнэ.

Зориулалт	Солбицол	Гүн, метр	Ундарга, л/сек	Гаргасан он	Тоолуур марк	Насос марк
Худаг №1	47°37'38.8",106°51'29.7"	70.0	10.0	2017	M16-80	EBARA-HBE6
Худаг №2	47°37'38.8",106°51'29.7"	70.0	12.0	2017	M16-80	EBARA-HBE6
Худаг №3	47°37'39.6",106°51'25.1"	70.0	11.4	2017	M16-80	EBARA-HBE6

2.4.2. *Барилга байгууламж:* Ундны усыг шүүж, халдваргүйжүүлэх 800.0 м³/хон хүчин чадалтай цэвэр ус хангамжийн байгууламжтай. Нийт 1'110.0 м³ багтаамжтай 3 ширхэг ус нөөцлөх сантай.

2.4.3.Тоног төхөөрөмжийн нэр, марк, *насосны хүчин чадал:* Цэвэр ус дамжуулах шугамын урт 4'451.0 м урт, 125 мм голч бүхий хуванцар шугам сүлжээтэй. *EBARA-HBE6 маркийн насос суурилуулсан.*

2.5. *Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага:* Хаягдал усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартын шаардлагыг мердлөг болгоно. Стандартаас давсан агууламжтай хаягдал усыг байгальд нийлүүлж буй тохиолдолд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ын дагуу төлбөр тооцно.

2.6. *Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлээсний түвшин:*

2.6.1 Бохир ус цэвэрлэх байгууламж нь хоногт 800.0 м³ усыг 96%-98% хүртэл цэвэрлэх хүчин чадалтай. Хэрэглээнээс гарсан ахуйн бохир усыг 2 сувагт хүлээн авч механик, биологийн цэвэрлэгээг хийж, "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартын шаардлагад нийцүүлэн байгальд нийлүүлдэг.

2.7. *Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:*

2.7.1. Цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдэж гарсан усыг галын аюулгүй байдлыг хангах болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах, гүний усны ашиглалт хэрэглээг бууруулах тал дээр санаачлага гаргаж ажиллах.

2.8. *Усны тоолуур:* Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ыг хэрэгжүүлж ажиллана. Тоолуурын заалтын тэмдэглэлийг тогтмол хөтөлж, баталгаажуулна.

2.9. *Ус ашигласны төлбөрийн хэмжээ:*

2.9.1. Дулаан үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах 237'686.4 м³ газрын доорх усны нөөц ашигласны төлбөрт 16'828'197.0 /Арван зургаан сая найман зуун хорин найман мянга нэг зуун ерөн долоон/ төгрөг, ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах 67'392.0 м³ газрын доорх усны нөөц ашигласны төлбөрт 6'679'895.0 /Зургаан сая зургаан зуун далан есөн мянга найман зуун ерэн таван/ төгрөг, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах 120'000.0 м³ газрын доорх усны нөөц ашигласны төлбөрт 9'062'400.0 /Есөн сая жаран хоёр мянга дөрвөн зуун/ төгрөг, нийт 32'570'492.0 /Гучин хоёр сая таван зуун далан мянга дөрвөн зуун/ төгрөгийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасны дагуу усны нөөцийн төлбөрийн орлогыг ус ашиглах дүгнэлтээр тогтоосон хувь хэмжээгээр усны тоолуурын заалтаар тооцож төлнө. Төлбөрийг Төв аймгийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ. Төлбөрийн 40 хувийг хөөрдугаар, 40 хувийг гуравдугаар, 20 хувийг дөрөвдүгээр улиралд төлнө.

2.9.2. Гэрээнд зааснаас хэтрүүлэн ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 391 дүгээр тогтоолоор батлагдсан "Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам"-д заасны дагуу төлбөр тооцно.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүгээр зүйлийн 29.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын

САВ ГАЗРЫН ЗАХИРГАА

захиргааны шийдвэрээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ.

3.3. Ус ашиглуулах дүгнэлтээр тавьсан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийн хангаж ажиллана.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд жил бүрийн ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээг тухайн оны эхний улиралд багтаан байгуулна.

4.3. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ.

4.4. Талуудын хооронд үүссэн маргааныг зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд гэрээ болон түүний аль нэг заалттай холбоотой асуудлаар зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд асуудлыг холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.5. Тайлант оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлдэг ус ашиглалтын тайланг үндэслэн гэрээ дүгнэсэн тэмдэглэлийг 2 хувь үйлдэн баталгаажуулах бөгөөд гэрээнд заасан төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд дараа оны гэрээ хийгдэхгүй.

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААГ ТӨЛӨӨЛЖ:	"НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:
Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны дарга П.МАГСАРЖАВ	Захиргаа удирдлагын газрын дарга НОРИКО КИШИЗАВА
Мэдээлэл, хяналт шалгалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.БАТ-ЭРДЭНЭ	Инженер техникийн газрын дарга ЯМАМОТО ЮТАКА
Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн П.ЭНХБАЯР	Усны нөөцийн ахлах инженер Б.МЯГМАРСҮРЭН
Хаяг: Улаанбаатар хот-16050, БГД, 2-р хороо, Чингүнжавын гудамж, Туул голын сав газрын захиргааны байр, 2 дугаар давхар, 203 тоот өрөө Харилцах утас: 70003716, 70003714, 70002592	Хаяг: Төв аймаг Сэргэлэн сум, 4-р баг, Эрдэнэ уул, Тахилт толгой Харилцах утас: 7728-7376, 8810-1910.

"НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭШНЛ ХХК"
УЛААНБААТАР ХОТЫН ОЛОН УЛСЫН ШИНЭ НИСЭХ БУУДЛЫН
УС ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ГҮНИЙ ХУДГИЙН ТООЛУУРЫН ЗААЛТ
БАТАЛГААЖУУЛСАН ХУУДАС

2022.01.18

Д/д	Тоолуурын нэр марк	Байрлал	Тоолуурын заалт 2020.12.30	Тоолуурын заалт 2021.12.30	Тайлбар м3
1	(MADDALENA үйлдвэрийн TT-WMAP DN80 PN16 загварын урсгал хэмжигч) Дугаар: **1645000867**	1-р худаг Нисэх буудлын барилга байгууламжуудыг усаар хангах /байнгын ашиглалт/	44876	52455	7579
2	(MADDALENA үйлдвэрийн TT-WMAP DN80 PN16 загварын урсгал хэмжигч) Дугаар: **1645000891**	2-р худаг Нисэх буудлын буудлын барилга байгууламжуудыг усаар хангах /байнгын ашиглалт/	46562	54515	7953
3	(MADDALENA үйлдвэрийн TT-WMAP DN80 PN16 загварын урсгал хэмжигч) Дугаар: **1645000879**	3-р худаг Нисэх буудлын барилга байгууламжуудыг усаар хангах /байнгын ашиглалт/	48292	56243	7951
4	**Нийт олборлосон усны хэмжээ**				**23483**
5	LXLC-100 загварын урсгал хэмжигч Дугаар:202001067	Нисэх буудлын барилга байгууламжуудыг дулаанаар хангадаг **дулааны станцын технологид хэрэглэсэн усны хэмжээ**	223	2024	**1801**

Тайлбар: Усны тухай хуулийн 31 дүгээр зүйл, байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6, 10, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2 дах, заалт, "МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗРЫН-ын 2021 оны 04 дугаар сарын 20-ны өдрийн №56 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийн дагуу ус ашиглалтыг төлбөрийг Төв аймгийн байгаль орчны газарт тушаахаар энэхүү баталгаажуулалтын баримтыг үйлдэв.

Баримт үйлдсэн:
Төв аймгийн усны нөөцийн мэргэжилтэн Ж.ОЮУННАРАН

БАРИМТ ҮЙЛДСЭН:
Усан хангамжийн инженер Ч.МӨНХЖАРГАЛ

ТАНИЛЦСАН:
Дулаан, Ус хангамжийн хэлтсийн менежер Б.БАТТӨР

WPH - № 1

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ 00226383

Шинэ нисэх буудал ..... -д
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа М-80 загварын 40м3/ч

хэмжих хязгаартай, 80 мм-ийн голчтой № 1645000867 –ын

халуун, хүйтэн усны тоолуурыг №..... 014 ..... лацаар битүүмжилж
(доогуур зурах)

2023 оны 08 -р сарын 11 –ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 0048115

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2021 оны 08–р сарын 11-ны өдөр

WPH - № 2

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ 00226382

Шинэ нисэх буудал ..... -д
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа М-80 загварын 40м3/ч

хэмжих хязгаартай, 80 мм-ийн голчтой № 1645000891 –ын

халуун, хүйтэн усны тоолуурыг №..... 014 ..... лацаар битүүмжилж
(доогуур зурах)

2023 оны 08 -р сарын 11 –ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 0049823

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2021 оны 08–р сарын 11-ны өдөр

WPH-№3

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ 00226381

Шинэ нисэх буудал ..... -д
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа М-80 загварын 40м3Ч

хэмжих хязгаартай, 80 мм-ийн голчтой № 1645000879 -ын

халуун, хүйтэн усны тоолуурыг №..... 014 ..... лацаар битүүмжилж
(доогуур зурах)

2021 оны 08 -р сарын 11 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 0051602

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2021 оны 08 -р сарын 11 -ны өдөр

Ус цэвэршүүлэх байгууламжийн өдөр тутмын тайлан

Огноо:2022.11	Барилга байгууламжийн нэр:
2022.11.16-ны 08:00 цагаас 2022.11.17-ны 08:30 цаг	Ус цэвэршүүлэх байгууламж, Гүний худаг, Ус цуглуулах шугам сүлжээ, Ус түгээх шугам сүлжээ

WTP - Машинч : И.Ганхүү	Утас : 88187252

Усан сангийн түвшин	2022.11.16-ны 08:00 цаг	2022.11.16-ны 22:00 цаг	2022.11.17-ны 08:00 цаг	Тайлбар
Ус хүлээн авах сангийн түвшин / RW /	312	335	335	Дүүргэлт хийгдэв.
Цэвэршүүлсэн ус нөөцлөх сангийн түвшин / F-1/	312	313	309	Горимийн дагуу ус нөөцлөв.
Цэвэршүүлсэн ус нөөцлөх сангийн түвшин / F-2/	312	314	310	
Дулааны станцын ус нөөцлөх сангийн түвшин	130	124	124	Түүхий ус нэмж татуулав.
Шугамын даралт				
Ус түгээх шугамын даралт	5,0 ~ 5,0 bar	5,0 – 6,2 bar	5,0 – 5,0 bar	Хэвийн
Галын усны шугамын даралт	8,0	8,0	8,0	Хэвийн
Ус түгээх шугамын тоолуурын заалт				
Ус түгээх шугамын тоолуурын заалт	51843 м3	51901 м3	51945 м3	Хоногийн зарцуулалт 102 м3

№	Тоног төхөөрөмжийн нэрс	Ажиллаж эхлэсэн цаг	Зогссон цаг	Нийт ажилласан цаг	Ус татахаас өмнөх усны түвшин		Ус татасны дараах усны түвшин		Тайлбар
					HP-RW	WTP-RW	HP-RW	WTP-RW	
1	Гүний худаг №1	18:00	21:30	3:30	-	312	-	335	WTP- хүлээн авах санд дүүргэлт хийлээ.
2	Гүний худаг №2	-	-	-	-		-	-	Автомат горимд нөөцөнд.
3	Гүний худаг №3	-	-	-	-	-	-	-	Автомат горимд нөөцөнд.

№	Тоног төхөөрөмжийн нэрс	Ажиллаж эхлэсэн цаг	Зогссон цаг	Нийт цаг	Зарцуулалт м3	Ус татахаас өмнөх усны түвшин		Ус татасны дараах усны түвшин		Тайлбар
						F-1	F-2	F-1	F-2	
1	Фильтрэшн систем А-шугам	18:00	21:00	3:00	105,6	286	287	322	323	Горимийн дагуу боловсруулалт дүүргэлт хийгдэв.
2	Фильтрэшн систем В-шугам									
3	Ус түгээлтийн насос	08:00	08:00	18	102	1A	1B	1C	1D	Ээлжийн хугацаанд жигд хэвийн сэлгэж ажиллалаа.

№	Барилга байгууламжийн нэрс	Хүйтэн усны тоолуурын заалт	Цахилгаан халаагуурын өгөгдөл	Тасалгааны хэм
1	Гүний худаг №1	64841	Унтраасан	18 °C
2	Гүний худаг №2	66846	Унтраасан	17 °C
3	Гүний худаг №3	69293	Унтраасан	14 °C
4	Халаагч кабел		Асаалттай	30 °C
5	Дулааны станц, түүхий усны тоолуур	18250		
6	Дулааны станц, технологийн усны	3051		
	Цахилгааны тоолуурын заалт квт/ц			
1	Гүний худагууд	40521.09		
2	Ус цэвэршүүлэх байгууламж - 1	2054,70		
3	Ус цэвэршүүлэх байгууламж - 2	1180,22		

08:00 цагт: Ээлж хүлээж авахад эд хогшил, холбооны хэрэгслэл эвдрэлгүй, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн байна. Ус нөөцлөх усан сангуудын лацыг шалган хүлээн авсан.
Түүхий усны өрчин: 10,03
08:10 цагт: Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн. Ус түгээх A, B, C, D насос хэвийн сэлгэн ажиллаж байна.
08:45 цагт: ШУХТ-ын Ерөнхий зохицуулагч Батцэнгэлд ээлж хүлээн авсан үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгааг мэдээлэв.
АБХТ-н мэргэжилтэн мэдээ авав.
10:35 цагт Оператор Энхбаярын хамт нэвтрэх суваг буюу түннелээр үзлэг шалгалт хийв.
13:05 цагт: Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн. Ус түгээх A, B, C, D насос хэвийн сэлгэн ажиллаж байна.
16:30 цагт: Гүний худгуудад үзлэг шалгалт хийхэд гарсан гэмтэл доголдолгүй удирдлагын самбарт алдаа байхгүй хүчдэл хэвийн халаагч тенний тохируулга +20^0 С дээр байна. Тоолуурын заалт авч тэмдэглэв.
Хамгаалалтын хашаа, хаалга, цоож бүрэн бүтэн, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн ойролцоо гүний усны чанарт нөлөөлөх бохирдуулагч эх үүсвэр байхгүй. Дулааны станцын узельд байрлах түвшин тохируулах хаалт WTP-(auto) HP-(тойруу буюу 2 гар хаалт хаалттай) байна. Халаагч кабелийн тохируулага 15 дээр термометрээр шалгахад +30^0 С градус хяналтын гэрэл ногоон байна.

18:00 цагт: Фильтришн системийг **"А"** шугамаар ажиллуулж цэвэршүүлэн **/F1, F2/** усан санд дүүргэлт хийж эхлүүллээ. WTP- Түвшин тохируулах цахилгаан хаалтыг удирдлагын системээс нээн гүний худгийг ажиллуулав. Гүний **1-р** худаг ажиллаж хүлээн авах санд дүүргэлт хийгдэж байна. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн. Ус түгээх A, B, C, D насос хэвийн сэлгэн ажиллаж **21:00 цагт:** Цэвэршүүлсэн усан сангийн түвшин **/F_1-322, F_2-323/** болж фильтришн системийг **R1** самбар дээрээс зогсоов. **21:30 цагт:** Хүлээн авах сангийн түвшин **RW-310** болж гүний **1-р** худгийг зогсоон түвшин тохируулах хаалтыг хаасан. **03:15 цагт:** Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн. Ус түгээх A, B, C, D насос хэвийн сэлгэн ажиллаж байна. **06:30 цагт:** Ээлжинд гарсан зөрчилгүй үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн тоног төхөөрөмж, хянах хэмжих хэрэгслийн ажиллагааг бүрэн хянаж тэмдэглэл хөтөлж ажиллалаа. **07:50 цагт:** Дараагийн ээлжинд түлхүүр багаж бүрэн, эд хогшил эвдрэлгүй, тоног төхөөрөмж хэвийн ажиллагаатай хүлээлгэж өгөв.
Анхаарах асуудал	

Ээлж хүлээлгэж өгсөн: Машинч И.Ганхүү

Ээлж хүлээн авсан: Машинч Л.Батсайхан

Хянасан:

Ус цэвэршүүлэх байгууламжийн ахлах инженер Ч.Мөнхжаргал

Танилцсан: Дулаан, Ус хангамжийн хэлтсийн менежер Ч.Батбаяр

БАТЛАВ
НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ ХХК
ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН ГАЗРЫН ДАРГА
ЯМАМОТО ЮТАКА

"НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ" ХХК-НЫ ЭЗЭМШЛИЙН ГАДНА БОХИР УСНЫ
1.9 КМ ШУГАМ СҮЛЖЭЭГ КО-829A МАШИНААР УГААХ ХУВААРЬ

7/18/2022

Огноо	Худгийн дугаар	Шугамын урт, м	Шугамын диаметр, мм	Худгийн байршил	Худгийн тоо, ш
2022.07.20 09:00-16:00 цаг	SWM 1H - 1-р өргөх насос станц хүртэл	418.01	Ф150-Ф125	Цахилгааны дэд станцын гаргалгааны худагнаас 1-р өргөх насос станц хүртэл	15
	1 дүгээр өргөх насос станцын хүлээн авах сан лайдах, цэвэрлэх			1 дүгээр өргөх насос станц	17м3
2022.07.21 09:00-20:00 цаг	SMW 10 - SWM 2-өргөх насос станц хүртэл	664.42	Ф125-Ф250	Хамгаалагдсан бүс дотор Зорчигч үйлчилгээний барилгын зүүн талаас А32 дугаар пост хүртэл	18
	2 дугаар өргөх насос станцын хүлээн авах сан лайдах, цэвэрлэх			2 дугаар өргөх насос станц	33м3
2022.07.22 09:00-20:00 цаг	SMW 28 - SWM 46 хүртэл	868.65	Ф125-Ф300	2-р өргөх насос станцаас Бохир ус цэвэрлэх байгууламж хүртэл	28
	Бохир ус цэвэрлэх байгууламжийн хүлээн авах сан лайдах, цэвэрлэх			Бохир ус цэвэрлэх байгууламж	172м3
Нийт шугамын урт		**1951.08**			**61**
Нийт резервуарын хэмжээ					**222**

Тайлбар:
Бохир усны шугамыг ус түгээгүүрийн даралттай усаар угаах үед ХАБЭА-н хувцас, хэрэгслийг бүрэн өмсөж аюулгүй байдлыг хангаж ажиллах. Шугам угаалгыг 09:00- 20:00 цагийн хооронд хийж гүйцэтгэх.

Шугам угаалга, сан лайдаж цэвэрлэх үед:
1. Нисэх буудлын хамгаалалтын бүс дотор ажиллахын өмнө ШУХТ-д урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авсан байх.
2. Шугам хооронд дараллтай усаар угаах үед худаг хооронд урсгал сөрүүлж угаахгүй байх. Ажлын талбайг баллтгэх.
3. 1-р өргөх насос станцын бохир усны сорох 1A, 1B насосыг зэлжлэн гар горимд ажиллуулж резервуарыг хоосолсоны дараа дараагийн шугамыг угаана. /Шугам угаалгын үед резервуарын түвшинд тогтмол хяналт тавих, томоохон хог хаягдал шугаманд орж насосны ажлын дугуйг гэмтээх, бөглөхөөс сэргийлэх/
4. 2-р өргөх насос станцын бохир усны сорох 2A, 2B, 2C насосыг зэлжлэн гар горимд ажиллуулж резервуарыг хоосолсоны дараа дараагийн шугамыг угаана. /Шугам угаалгын үед резервуарын түвшинд тогтмол хяналт тавих, томоохон хог хаягдал шугаманд орж насосны ажлын

дугуйг гэмтээх, бөглөхөөс сэргийлэх/

5. Цэвэрлэх байгууламжийн хүлээн авах сангийн түвшин 120см-ээс дээш гарсан үед шугамын угаалгыг түр зогсоож хүлээн авах сангийн усны түвшинг буулгасны дараа ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх.

6. Нислэг үйлдвэрлэлтэй холбогдуулан ажлын хугацаа өөрчлөгдөж болохыг анхаарах

ХЯНАСАН: ДУЛААН УС ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.БАТТӨР

УСНЫ НӨӨЦИЙН АХЛАХ ИНЖЕНЕР Б.МЯГМАРСҮРЭН

ХУВААРЬ ГАРГАСАН: БОХИР УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ИНЖЕНЕР Э.ЭНХДУЛАМ

21

MEMORANDUM OF COOPERATION BETWEEN NEW ULAANBAATAR INTERNATIONAL AIRPORT LLC AND ENVIRONMENTAL ENGINEERING AND CLEAN TECHNOLOGY LABORATORY OF NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ ХХК БОЛОН МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ИНЖЕНЕРЧЛЭЛ, ЦЭВЭР ТЕХНОЛОГИЙН ЛАБОРАТОРИИН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

Date: №..... Tuv province

Огноо: 2022.12.01 №2022/12/01 Төв аймаг

On the one hand, New Ulaanbaatar International Airport LLC (hereinafter referred to as NUBIE LLC), and on the other hand, the Environmental Engineering and Clean Technology Laboratory of national university of Mongolia (hereinafter referred to as "EEACTLMU", collectively referred to as "the parties") mutually agree to cooperate under the conditions mentioned below, and this memorandum created the letter.

Нэг талаас Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК (цаашид НУБИЭ ХХК гэх), нөгөө талаас МУИС-ийн Хүрээлэн буй орчны инженерчлэл, цэвэр технологийн лаборатори (цаашид "ХБОИЦТЛ", хамтад нь "талууд" гэх) дор дурьдсан нөхцлөөр хамтран ажиллахаар харилцан тохиролцож, энэхүү санамж бичгийг байгуулав.

ARTICLE ONE. COMMON GROUND
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 The purpose of this memorandum is the Heat and Water Supply Department of Engineering and Technical Department of NUBIE LLC and material base of the parties, the experiment and research work of the researchers of the EEACTLMU will be directed to the joint implementation of research, the organization of training, scientific meetings and the production of joint works.

Энэхүү санамж бичгийн зорилго нь НУБИЭ ХХК-ийн Инженер техникийн газрын Дулаан, ус хангамжийн хэлтэс ба ХБОИЦТЛ-ийн судлаачдын туршилт, судалгааны ажлыг талуудын материаллаг баазад түшиглэн судалгааг хамтран хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах, эрдэм шинжилгээний хурал болон хамтын бүтээл гаргахад чиглэгдэнэ.

1.2 The cooperation between the parties shall be based on the principles of transparency, rule of law, respect for the interests of both parties, and effective cooperation.

Талуудын хамтын ажиллагаанд ил тод нээлттэй байх, хууль дээдлэх, хоёр талын эрх ашгийг хүндэтгэн аливаа асуудлыг зөвшилцлийн үндсэн дээр шийдэх, үр бүтээлтэй хамтран ажиллах зарчим баримтална.

1.3 The cooperation of the parties shall be governed by the Constitution of Mongolia, Law on Science and Technology, Law on Education of Mongolia, Law on Environment and other related legal acts.
Талуудын хамтын ажиллагаа нь Монгол улсын Үндсэн хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Монгол улсын Боловсролын тухай хууль, Байгаль орчны тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актыг удирдлага болгоно.

1.4 The parties shall not be liable to any other party for materials, techniques, equipment, or money required for the implementation of this memorandum. In case of necessity, it will be resolved by concluding a separate contract or agreement on the basis of mutual understanding.
Талууд энэхүү санамж бичгийг хэрэгжүүлэхэд шаардагдах эд материал, техник, тоног төхөөрөмж, мөнгөн хөрөнгийн хариуцлагыг аль нэг талынхаа өмнө хүлээхгүй. Шаардлагатай тохиолдолд харилцан ойлголцсоны үндсэн дээр тусд нь гэрээ, хэлцэл байгуулах замаар шийдвэрлэнэ.

1.5 This memorandum is based on mutual trust and does not confer any legal rights or obligations.
Энэхүү санамж бичиг нь харилцан итгэлцэл дээр суурилсан бөгөөд хууль зүйн хувьд эрх, үүрэг хүлээлгэхгүй.

ARTICLE TWO. MAIN AREAS OF COOPERATION
ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

2.1 The parties will develop and implement a joint experiment and research project
Талууд хамтарсан туршилт, судалгааны ажлын төсөл боловсруулж, хэрэгжүүлэх;

2.2 Organizing training for employees of the parties within the framework of cooperation;
Хамтын ажиллагааны хүрээнд талуудын ажилтнуудад дадлага сургуулилт зохион байгуулах;

2.3 Co-organization of international and national academic conferences and other seminars;
Олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хурал, бусад семинар хэлэлцүүлэг хамтран зохион байгуулах;

2.4 Providing environmental consulting and support services to NUBIA LLC from EEACTLMU
ХБОИЦТЛ -ээс НУБИЭ ХХК-д байгаль орчны зөвлөх, туслах үйлчилгээ үзүүлэх;

ARTICLE THREE. OBLIGATIONS OF THE PARTIES
ГУРАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

3.1 EEACTLMU researchers of the within the framework of the approved plan of NUBIA LLC for the that year, to provide opportunities and conditions for working in the industrial environment of the facilities of the Heat and Water Supply Division

НУБИЭ ХХК-ийн тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөний хүрээнд Инженер, техникийн газрын Дулаан, ус хангамжийн хэлтсийн байгууламжуудын үйлдвэрлэлийн орчинд ХБОИЦТЛ-ийн судлаачдыг ажиллах боломж, нөхцөөр хангах,

3.2 Support the parties in obtaining and using necessary documents from other units of the company for the work to be done within the framework of the memorandum

Талууд санамж бичгийн хүрээнд хийгдэх ажилд компанийн бусад нэгжүүдээс шаардлагатай баримт материалыг авч ашиглахад дэмжлэг үзүүлэх,

3.3 EEACTLMU provides theoretical and practical methodology for the joint implementation of research work related to the quality of sludge, mechanical waste, ash, clean and dirty water

from the production activities of the facilities of the Heat and Water Supply Division of the Engineering Department of NUBIA LLC,

ХБОИЦТЛ нь НУБИЭ ХХК-ийн Инженер, техникийн газрын Дулаан, ус хангамжийн хэлтсийн байгууламжуудын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарч буй лаг, механик хог хаягдал, унс, цэвэр, бохир усны чанартай холбоотой судалгааны ажлыг хамтран хэрэгжүүлэхэд онолын болон дадлагын арга зүйгээр хангах,

3.4 Within the framework of the approved plan of that year, provide opportunities and conditions for the work of engineers and technical staff of NUBIA LLC in the EEACTLMU.

Тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөний хүрээнд ХБОИЦТЛ-д НУБИЭ ХХК -ийн инженер, техникийн ажилтнууд ажиллах боломж, нөхцлөөр хангах

3.5 The parties will develop a work plan for joint implementation within the framework of the memorandum, and it will be approved by the authorized officials of the parties and implemented.

Талууд санамж бичгийн хүрээнд хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, талуудын эрх бүхий албан тушаалтнуудаар батлуулан, мөрдөж ажиллана.

3.6 The parties shall use all types of confidential information obtained in the course of cooperation only on the grounds prescribed by law and shall not disclose it to others.

Талууд хамтын ажиллагааны явцдаа олж авсан бүх төрлийн нууц мэдээллийг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэлээр ашиглах, бусдад задруулахгүй байх,

3.7 The parties shall inform the other party in advance and participate in any event related to the implementation of cooperation

Талууд хамтын ажиллагаатай холбоотой аливаа арга хэмжээ зохион байгуулахдаа нөгөө талдаа урьдчилан мэдээлэл өгч, хамтран оролцох

3.8 Collaborate on publicizing targeted results of joint experiments and research

Хамтарсан туршилт, судалгааны ажлын зорилтот үр дүнг олон нийтэд мэдээлэх талаар хамтран ажиллах

ARTICLE FOUR. OTHER
ДӨРӨВ. БУСАД

4.1 The Memorandum shall enter into force upon signature by the authorized representatives of the Parties.
Санамж бичгэт Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

4.2 The memorandum is concluded for a period of 3 years, and the term of the memorandum can be extended by mutual agreement.
Санамж бичгийг Монгол, Англи хэлээр 2 (хоёр) эх хувь үйлдэж, талууд тус бүр 1 (нэг) хувийг хадгалах бөгөөд тус бүр хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байна.

4.3 In the event of a discrepancy between the Mongolian and English versions of the Memorandum, the English version shall be used for the relevant conflicting clauses.

Санамж бичгийн Монгол, Англи хувилбарын хооронд зөрүү гарсан тохиолдолд холбогдох зөрүүтэй заалтын хувьд Англи хэл дээрх хувилбарыг баримтална.

4.4 The Parties may make amendments to the Memorandum by mutual agreement in writing, and shall notify the other Party in writing of their proposals.
Санамж бичигт Талууд бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд саналаа нөгөө Талдаа бичгээр мэдэгдэнэ.

4.5 Once a year, the parties will jointly evaluate the implementation of the memorandum and resolve the issue of extension by providing evaluations and conclusions.
Санамж бичгийн хэрэгжилтийг жилд нэг удаа талууд хамтран дүгнэж, үнэлэлт, дүгнэлт өгөх замаар сунгах асуудлыг шийдвэрлэнэ.

THE MEMORANDUM HAS BEEN ESTABLISHED:
САНАМЖ БИЧГИЙГ БАЙГУУЛСАН:

REPRESENTING NUBIA LLC
НУБИЗ ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

CEO of New Ulaanbaatar International Airport LLC
..... Takefumi Kitanaka

Шинэ Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК-ийн Гүйцэтгэх захирал Китанака Такэфуми

Phone: (976) 71287443
Утас: (976) 71287443

Address: Address: Tuv aimag, Sergelen soum 4th bag Erdene-Uul /41090/ Takhilt tolgoi

Хаяг: Төв аймаг, Сэргэлэн сум, 4-р баг, /41090/ тахилт толгой

REPRESENTING EEACTLMU:
ХБОИЦТЛ-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Head of Environmental Engineering and Clean Technology Laboratory, Mongolian national university
.....Enkhdhul.T

Монгол Улсын их сургууль, Хүрээлэн буй орчны инженерчлэл, цэвэр технологийн лабораторийн эрхлэгч Т.Энхдэл

Phone: (976) 90084453
Утас: (976) 90084453

Address: Ulaanbaatar city, University Street-1, small roundabout, Sukhbaatar district

Хаяг: Улаанбаатар хот, Их сургуулийн гудамж-1, бага тойруу, Сүхбаатар дүүрэг

БАТЛАВ
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.НЯМДОРЖ

2022 оны 04 дүгээр сарын

БАТЛАВ
"НЬЮ УЛААНБААТАР
ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ" ХХК
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
КИТАНАКА ТАКЭФУМИ

2022 оны 04 дүгээр сарын 29

ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ

Дугаар ХУТ 22/02 Улаанбаатар хот

Нэг: Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу "Усны газар"-ын гаргасан 2022 оны 03-р сарын 24-ний өдрийн 49 дугаартай хаягдал усны дүгнэлт, Туул голын сав газрын захиргаанаас олгосон 2022 оны 04-р сарын 26-ний өдрийн 22/03 дугаартай ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Усны чанар, экологийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Цэнгэлмаа, нөгөө талаас ус бохирдуулагчийг төлөөлж Тев аймаг, Сэргэлэн сум, Эрдэнэ-Уул 4-р баг, Тахилт толгой, улсын бүртгэлийн 1411011101 тоот гэрчилгээ, 3874095 регистрийн дугаартай "Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК-ийн гүйцэтгэх захирал Китанака Такэфуми нар ус бохирдуулсаны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 1 /Нэг/ жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг "Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх халбэрээр тооцож төлнө.

2.2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усны дүгнэлтээр тогтоосон ус бохирдуулсны төлбөр болох нийт **168'909.0** /Нэг зуун жаран найман мянга есөн зуун есөн/ төгрөгийг Тев аймгийн Татварын хэлтсийн дансанд гэрээний 2.3-т заасан хугацаанд төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор үндсэн бүртгэлтэй харьяалах Татварын албанд төлнө.

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутам Сав газрын захиргаа, харьяалах Татварын албанд хүргүүлнэ.Үүнд:

2.4.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;

2.4.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинаар байгальд хаясан хаягдал усны хэмжээ;

2.4.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.4.4. Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн;

2.4.5. Бохирдуулах бодисын ялгарал, шилжилтийн системд усны бохирдлын мэдээллийг бүртгүүлнэ;

2.4.6. Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан.

2.4.7. 2.4.1-ээс 2.4.4-т заасан мэдээллийг Tuul.info20@gmail.com цахим хаягаар ирүүлнэ.

Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дэхь хэсэгт заасны дагуу Сав газрын газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно.

3.3. Сав газрын захиргаа болон сум, дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4. Сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоолгох, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны эзлэхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл (тоолуур)-ийг "Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам"-д заасны дагуу хаягдал усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тооолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрсдэлээс хамгаалагдсан ад ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

Тав. Бусад

5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйл

6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл (газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт) –ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Мэдээлэл, хяналт шалгалтыг зохицуулах албаны дарга Б.ОЮУНБОЛД

Мэдээлэл, хяналт шалгалтыг зохицуулах албаны ахлах мэргэжилтэн Б.ДУЛМАА

Мэдээлэл, хяналт шалгалтыг зохицуулах албаны мэргэжилтэн Б.ЦЭНГЭЛМАА

Хаяг: Улаанбаатар хот-16050, БГД, 2-р хороо, Чингүнжавын гудамж, Туул голын сав газрын захиргааны байр, 203 тоот өрөө.
Харилцах утас: (976) 7000-3716, (976) 7000-3714

УС БОХИРДУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК-ийн гүйцэтгэх захирал КИТАНАКА ТАКЭФУМИ

Хаяг: Төв аймаг, Сэргэлэн сум 4-р баг Эрдэнэ-Уул /41090/ Тэхилт толгой

Харилцах утас: (976) 71287360, (976)-99033599.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn

2022.06.07 № 01/662

танай 2022.05.24-ны № EG-HW/517-т

"НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ" ХХК-Д

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1. дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 316 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлсан "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ", БОАЖ-ын Сайд, Сангийн Сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар батлсан "Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлал", БОАЖ-ын Сайдын 2019 оны А/635 тоот тушаалаар батлсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам", танай компанийн 2022 оны EG-HW/517 тоот Ус бохирдуулсны төлбөр тооцуулах хүсэлт, лабораторийн шинжилгээний дүнг тус тус үндэслэн 2022 оны I улирлын төлбөрийн тооцоог хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА Ш.МЯГМАР

16322151

28

Усны газрын 2022 оны 06 дугаар сарын 07-ны
өдрийн 04/552 тоот албан бичгийн хавсралт

"Нью Улаанбаатар Интернэйшнл эйрпорт" ХХК-ийн 2022 оны 01 дүгээр улирлын ус бохирдуулсны төлбөрийн тооцоо

№	Бохирдуулах бодисын төрөл	Шинжил гээний давтамж	MNS 4943:2015 стандартын ЗДХ	Хаягдал усны сорьц дахь бохирдуулах бодисын дундаж агууламж		ЗДХ-ээс хэтэрсэн агууламж	Нөхөн төлбөр тооцох шатлан өсөх хэлбэр	Хаягдал усны хэмжээ, м³	Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, кг	Бодис тус бүрийн төлбөрийн хэмжээ		Ус бохирдуулсны төлбөр, төгрөгөөр	Нөхөн төлбөр, төгрөгөөр	Нийт төлбөр, төгрөгөөр
				мг/л	кг/м³					хэмжих нэгж	тариф			
1	Жинлэгдэх бодис	3	30	4.66667	0.00467	0.16	0	7932	37.02	төг/кг	50	1,850.80	-	1,850.80
2	Органик бодис /ХХХ/	3	50	39.3333	0.03933	0.79	0	7932	311.99	төг/кг	50	15,599.60		15,599.60
3	Органик бодис /БХХ/	3	20	12.6633	0.01266	0.63	0	7932	100.45	төг/кг	50	5,022.28	-	5,022.28
4	Органик бодис /нийт азот/	3	15	12.5251	0.01253	0.84	0	7932	99.35	төг/кг	50	4,967.47		4,967.47
5	Эрдэс бодис /фосфор/	3	1.5	9.81333	0.01	6.54	5	7932	77.84	төг/кг	20	1,556.79	6,227.15	7,783.94
2022 оны 1-р улирлын ус бохирдуулсны төлбөр, төгрөгөөр												28,996.94	6,227.15	35,224.08

Ус бохирдуулсны төлбөрийн тооцоог хийсэн:
Хаягдал усны төлбөр, зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн Л.Хишигдулам

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР
Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn

2022. 07. 29 № 06/912

танай 2022. 07. 27 -ны № EG-HW/786 -т

НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ
ЭЙРПОРТ ХХК-Д

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1. дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 316 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ", БОАЖ-ын Сайд, Сангийн Сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлал", БОАЖ-ын Сайдын 2019 оны А/635 тоот тушаалаар батлагдсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам", танай компанийн 2022 оны EG-HW/786 тоот "Ус бохирдуулсны төлбөр тооцуулах хүсэлт", лабораторийн шинжилгээний дүнг тус тус үндэслэн 2022 оны II улирлын төлбөрийн тооцоог хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ У.БАТЗАЯА

16322064

Усны газрын 2022 оны 07 дугаар сарын 29-ны
өдрийн 06/402 дугаар албан бичгийн хавсралт

"Нью Улаанбаатар Интернэйшнл эйрпорт" ХХК-ийн 2022 оны II улирлын ус бохирдуулсны төлбөрийн тооцоо

№	Бохирдуулах бодисын төрөл	Шинжил гээний давтамж	MNS 4943:2015 стандартын ЗДХ	Хаягдал усны сорьц дахь бохирдуулах бодисын дундаж агууламж		ЗДХ-аас хэтэрсэн агууламж	Нөхөн төлбөр тооцох шатлан өсөх хэлбэр	Хаягдал усны хэмжээ, м^3	Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, кг	Бодис тус бүрийн төлбөрийн хэмжээ		Ус бохирдуулсны төлбөр, төгрөгөөр	Нөхөн төлбөр, төгрөгөөр	Нийт төлбөр, төгрөгөөр
				мг/л	кг/м^3					хэмжих нэгж	тариф			
1	Жинлэгдэх бодис	1	30	5.8	0.006	0.19	0	8276	48.00	төг/кг	50	2,400.04		2,400.04
2	Органик бодис /ХХТ/	1	50	50.46	0.050	1.01	2	8276	417.61	төг/кг	50	20,880.35	20,880.35	41,760.70
3	Органик бодис /БХТ/	1	20	18.322	0.018	0.92	0	8276	151.63	төг/кг	50	7,581.64		7,581.64
4	Органик бодис /нийт азот/	1	15	10.2981	0.010	0.69	0	8276	85.23	төг/кг	50	4,261.35		4,261.35
5	Эрдэс бодис /фосфор/	1	1.5	11.264	0.011	7.52	5	8276	93.39	төг/кг	20	1,867.73	7,470.91	9,338.64
2022 оны II улирлын ус бохирдуулсны төлбөр, төгрөгөөр												36,991.11	28,351.26	65,342.37

Ус бохирдуулсны төлбөрийн тооцоог хийсэн:
Хаягдал усны төлбөр, зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн Л. Хишигдулам Л.Хишигдулам

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР
Чингүнжавын өргөмж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.mn

2022.10.26 № 06/1202
танай 2022.10.21 -ны № EG-HW/1175-т

"НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ" ХХК-Д

Ус бохирдуулсны төлбөрийн мэдээлэл хүргүүлэх тухай

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1. дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 316 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ", БОАЖ-ын Сайд, Сангийн Сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлал", БОАЖ-ын Сайдын 2019 оны А/635 тоот тушаалаар батлагдсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам", танай компанийн 2022 оны EG-HW/1175 тоот "Ус бохирдуулсны төлбөр тооцуулах хүсэлт", лабораторийн шинжилгээний дүнг тус тус үндэслэн 2022 оны III улирлын төлбөрийн мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ У.БАТЗАЯА

32

16?220990

Усны газрын 2022 оны 10 дугаар сарын
28-ны өдрийн 04/1109 тоот албан
бичгийн хавсралт

"НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ" ХХК-ийн 2022 оны III улирлын ус бохирдуулсны төлбөрийн тооцоо

№	Бохирдуулах бодисын төрөл	Шинжилгээний давтамж	MNS 4943:2015 стандартын ЗДХ	Хаягдал усны сорьц дахь бохирдуулах бодисын дундаж агууламж		ЗДХ-ээс хэтэрсэн агууламж	Нөхөн төлбөр тооцох шаталан есөх хэлбэр	Хаягдал усны хэмжээ, м³	Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, кг	Бодис тус бүрийн төлбөрийн хэмжээ		Ус бохирдуулсны төлбөр, төгрөгөөр	Нөхөн төлбөр, төгрөгөөр	Нийт төлбөр, төгрөгөөр
				мг/л	кг/м³					хэмжих нэгж	тариф			
1	Жинлэгдэх бодис	1	30	10.35	0.010	0.00	0	10347	107.09	төг/кг	50	5,354.57	-	5,354.57
2	Органик бодис /ХХТ/	1	50	61	0.061	1.22	2	10347	631.17	төг/кг	50	31,558.35	31,558.35	63,116.70
3	Органик бодис /БХТ/	1	20	24.12	0.024	1.21	2	10347	249.57	төг/кг	50	12,478.48	12,478.48	24,956.96
4	Органик бодис /нийт азот/	1	15	61.9	0.062	4.13	3	10347	640.48	төг/кг	50	32,023.97	64,047.93	96,071.90
5	Эрдэс бодис /фосфор/	1	1.5	11.22	0.011	7.48	5	10347	116.09	төг/кг	20	2,321.87	9,287.47	11,609.33
2022 оны III улирлын ус бохирдуулсны төлбөр, төгрөгөөр												83,737.24	117,372.23	201,109.47

Ус бохирдуулсны төлбөрийн тооцоог хийсэн:
Хаягдал усны төлбөр, зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн Л.Хишигдулам



НУБИЭ ХХК

Хавсралт 2

Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2/34 - 39

Гэрээ, ажлын тайлан

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022 оны 09-р сарын 27 өдөр № 22/89 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг № 316/22

Нэг талаас Монгол улсын хуулийн этгээд болох 000168199 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ 3874095 тоот регистрийн дугаартай Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК "/цаашид "Захиалагч" гэх /,түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Китанака Такэфуми

Нөгөө талаас /9011497042/ тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, /5866553/ тоот регистрийн дугаартай "МҮҮН ГАРДЕН" ХХК /цаашид "Гүйцэтгэгч тал" гэх/ түүнийг төлөөлж захирал Б.Сарантуяа нар Монгол улсын иргэний хуулийн холбогдох заалтыг үндэслэн дараахи зүйлсийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 **Гэрээний зорилго:**Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь хаусын гадна талбайд нийт ( ) м хэмжээтэй гадна талбайд нийт 85 модны үнэ (5,305,000 ₮) + хуучин хөрс шилжүүлэх төлбөр 280,000₮ нийт 5,585,000₮ үсгээр / таван сая таван зуун наян таван мянган төгрөг/ мод **нийлүүлэх, тарих** ажлыг захиалагч талын батлагдсан загвар хийцийн дагуу хийж гүйцэтгэх, захиалагч тал нь гэрээнд заасан төлбөрийг төлөх болон эдгээртэй холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2 **Гэрээний зүйл**

- Нийт (85) ширхэг голт бор (2-3 настай 0,70см) мод нийлүүлэх, тарих ажлыг хэмжээ, нормын дагуу хийж гүйцэтгэх
- Гумин бордоо 50кг /л

1.3. **Гэрээний бүрдэл:** Дараахь баримт бичгүүд нь гэрээний салшгүй хэсэг болно. Үүнд: Энэхүү гэрээний хавсралт №1 Үнийн санал №2 нэхэмжлэх

1.4. Энэхүү гэрээ нь Талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дууссанд тооцно.

ХОЁР. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

2.1. **Ажил гүйцэтгэх хугацаа:** Гүйцэтгэгч тал нь гэрээт ажлыг үндсэн гэрээ батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор гүйцэтгэж захиалагч талд хүлээлгэн өгнө.

2.2. **Ажлын хамрах хүрээ:** Гүйцэтгэгч нь.Гэрээний хавсралтад заасан холбогдох зураг төсөв, ажлын хамрах хүрээ, ажил гүйцэтгэх хувиарын дагуу ажлыг гүйцэтгэнэ. Захиалагч өөрийн шаардлагаар гүйцэтгэх ажлын хамрах хүрээ, бусад баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулахаар бол Гүйцэтгэгч талд урьдчилан мэдэгдэж, харилцан зөвшилцсөний үндсэн дээр оруулах боломжтой бөгөөд зөвшилцөөгүй тохиолдолд гүйцэтгэгч тал татгалзах эрхтэй.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

3.1. Гэрээт ажлын нийт хөлс нь / 5,585,000 /₮таван сая таван зуун наян таван мянган төгрөг/ байна.

3.2. **Төлбөрийн нөхцөл:** Ажлын хөлсийг Захиалагч тал Гүйцэтгэгч талын нэхэмжлэхийг үндэслэн Мүүн Гарден ххк төрийн банкны (3412 0119 2873) дугаарын дансанд шилжүүлнэ.

3.3. -Гэрээний үнийн дүнгийн урьдчилгаа (40) хувь болох (2,234,000)₮ / хоёр сая хоёр зуун гучин дөрвөн мянган / төгрөгийг талууд гэрээнд гарын үсэг зуран, тамга даран баталгаажуулсан өдрөөс хойш ажлын 1 хоногийн дотор Захиалагч тал Гүйцэтгэгч талын дансанд шилжүүлнэ.

3.4 -Гэрээт ажлын тарилт 40%-д хүрсэн тохиолдолд Захиалагч тал нь гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл (30) хувь буюу (1,675,500 ₮) / нэг сая зургаан зуун далан таван мянга таван зуун /төгрөгийг/ гүйцэтгэгч талын дансанд ажлын 4 цагийн дотор шилжүүлнэ.

3.5 -Гэрээт ажлын тарилт 100%-д хүрсэн тохиолдолд Захиалагч тал нь гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл (30) хувь буюу (1,675,500 ₮) / нэг сая зургаан зуун далан таван мянга таван зуун /төгрөгийг/ гүйцэтгэгч талын дансанд ажлын 5 өдрийн дотор шилжүүлнэ.

Захиалагч тал: Гүйцэтгэгч тал:

3.6 – **Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай** Тус компани нь "Ойжуулалт цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажил нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй" гэсэн заалтын дагуу НӨАТ төлөгч компани биш болно.

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Гүйцэтгэгч дараахь үүргийг хүлээнэ:

4.1.1. Ажлыг гэрээнд заасан хугацаа, нөхцлөөр, өөрийн материал, хэрэгслийг ашиглан алдаа дутагдалгүй хийж гүйцэтгэж, гэрээнд заасан хугацаанд Захиалагчид хүлээлгэх өгөх.

4.1.2. Захиалагчаас ажлын гүйцэтгэлтэй холбогдуулан үндэслэлтэй бодитой санал, заавар, дүгнэлт өгвөл хүлээн авах, тусгах

4.1.3. Ажлыг хүлээн авах үед эсвэл Гомдлын шаардлага гаргах хугацаанд гүйцэтгэсэн ажил нь эрхийн болон биет байдлын дутагдалтай модны нахиа задраагүй, Гэрээнд заасан зорилгоор ашиглах боломжгүй байна гэж үзвэл Гүйцэтгэгч тал түүнийг үндэслэлтэй хэмээн хүлээн зөвшөөрвөл тэр даруй засварлан арилгах

4.1.4. Ажил гүйцэтгэхтэй холбогдуулан олж авсан, мэдсэн Гүйцэтгэгчид холбогдолтой аливаа мэдээлэл, баримт, материал, зураглал, тооцоолол үнийн саналыг нууцлаг чанд хадгалах, өөрийн болон бусдын ашиг сонирхолд ашиглуулахгүй, задруулахгүй, нийтэд ил болгохгүй байх;

4.1.5. Ажлыг гүйцэтгэхдээ Захиалагч байгууллагын удирдлагын тавьсан үндэслэлтэй шаардлагыг биелүүлэх;

4.1.6. Гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, давхар гэрээ байгуулахгүй байх;

4.1.7. Ажлыг гүйцэтгэхдээ Захиалагч, түүний удирдлага харилцагчид, гуравдагч этгээдийн эд хөрөнгөд эвдрэл, гэмтэл, хохирол учруулахаас сэргийлэх;

4.1.8. Ажил гүйцэтгэхээр Захиалагчаас авсан баримт, материал, тоног төхөөрөмж, (Хэрэв байгаа бол)-ийг Ажлыг хүлээлцэх үед Захиалагчид бүрэн бүтэн буцаан өгөх

4.1.9. Ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай стратеги төлөвлөгөө болон гүйцэтгэлийг хэрэгжүүлэхээс өмнө Захиалагч талын зөвшөөрөл, дэмжлэгийг бичгээр болон амаар авна.

4.1.10. Гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэх

4.1.11. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх явцдаа тухайн байгууллагын ажуулгүй ажиллагааны дүрэм журмыг чанд сахиж, шаардлагатай, цацруулагчтай хантааз, бээлий зэргээр хангагдсан байна.

4.2. Гүйцэтгэгч дараахь эрхийг эдлэнэ:

4.2.1. Гэрээний 3 дугаар зүйлд заасан журмаар Захиалагчаас төлбөрөө шаардаж авах

4.2.2. Гэрээний хугацаанд Захиалагч талаас шаардлагатай мэдээ, мэдээллийг авах

4.2.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Захиалагчаас шаардах

4.2.4. Гүйцэтгэгч тал ажил гүйцэтгэх хугацаанд ажилчны ар гэрт хүнд нөхцөл шалтгаан үүсэх үүнээс үүдэн ажлын чөлөө олгосон тохиолдолд тухайн ажилтныг орлуулан ажлуулах эрхтэй.

4.2.5. Ажил гүйцэтгэх явцад авто замын түгжрэл, аваар осол гарсан, тасралтгүй ширүүн бороо , цаг агаар огцом сэрүүцэх , улсын хэмжээний томоохон арга хэмжээ баяр наадам гэх зэрэг томоохон үйл ажиллагаатай холбогдуулан гэрээний хугацаа хойшлогдсон тохиолдолд гүйцэтгэгч тал хариуцахгүй.

4.2.6. Хүлээлгэж өгснөөс хойш цаашдын усалгаа арчилгааг тогтмол хийгээгүй , услагаа арчилгааны тайлан гүйцэтгэгч талын email хаяг руу илгээгээгүйн улмаас гарсан хохирлыг гүйцэтгэгч тал хариуцахгүй.

ТАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Захиалагч дараахь үүргийг хүлээнэ:

5.1.1. Гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох мэдээ, мэдээлэл, цаашдын арчилгаа усалгаа , усалгааны шланк ,усалгааны зориулалттай хошуу захиалагч тал хариуцна/ хангана.

5.1.2. Гэрээт ажлыг гүйцэтгэж дууссанаас хойш усалгааны давтамж, усалгааны нөхцөл байдлын тайлан, мэдээллийг гүйцэтгэгч талд сар бүр нэгээс доошгүй удаа илгээсэн байна.

5.1.3. Гэрээнд заагдсан ажлуудаас гүйцэтгэгч хийх шаардлагагүй болсон тохиолдолд урьдчилан мод үржүүлэгийн талбайгаас мод, бут, сөөг хөрснөөс хөдлөхөөс ажлын 2 өдрийн дотор мэдэгдэнэ. Ажил

Захиалагч тал: _____ Гүйцэтгэгч тал: _____

гүйцэтгэлийн явцад тухайн ажлыг зогсоох тухай албан бичгээр мэдэгдсэн тохиолдолд гэрээнд заасан дүнгээр ноогдох мод, бутны төлбөрийг тооцон олгоно.

5.1.4. Гэрээгээр тохиролцсон ажлыг чанартай гүйцэтгэхэд Гүйцэтгэгч талд бүх талын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

5.1.5. Гэрээгээр тохиролцсон ажлыг үндэслэлгүй, өөрийн санаачлагаар өөрчлөх, бодитой бус шаардлага, санал тавьж, биелүүлэхийг шаардах зэрэг Гүйцэтгэгч талыг гэрээт ажлаа хэвийн явуулахад саад болох аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулахгүй байх үүрэгтэй.

5.2. Захиалагч дараахь эрхийг эдлэнэ:

5.2.1. Ажлыг гүйцэтгэх явцад хяналт тавих, ажлын явц, чанарыг шалгаж, санал, заавар, дүгнэлт зэргийг бичгээр гаргах

5.2.2. Ажлыг чанартай түвшинд бүрэн хугацаанд нь гүйцэтгэхийг шаардах

5.2.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол Захиалагч нь Гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэж, сануулга өгөх ба цаашид 14 дээш хоног оройтуулсан тохиолдолд Гэрээг нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.

5.2.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах

ЗУРГАА. АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ

6.1. Гүйцэтгэгч тал нь Захиалагч талын төлөөлөгчид ажлын үр дүнг шалгуулан хоёр тал ажил хүлээлгэн өгсөн тухай акт үйлдэнэ.

6.2. Ажил хүлээлгэн өгсөн актанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, хугацаа, ажлыг шалгасан үр дүнг тусгана.

ДОЛОО. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

7.1. **Алданги:** Гүйцэтгэгч нь холбогдох чанарын шаардлага, гэрээний нөхцлийг бүрэн хангасан Ажлыг Гэрээний 2.1-д заасан хугацаанд Захиалагчид актаар хүлээлгэн өгөөгүй, Гэрээгээр тусгайлан хугацаа тогтоож өгсөн үүргээ тухайн цаг хугацаанд нь биелүүлээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол нийт үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1 хувийн алданги төлнө.

7.2. Захиалагч нь төлбөрийг Гэрээний 3.2 дахь хэсэгт заасан хугацаанд төлөөгүй бөгөөд Гэрээний 3.2-т заасан төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн бол, тийнхүү хэтрүүлсэн өдрөөс эхлэн төлөөгүй ажлын хөлсний дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1 хувийн алданги төлнө.

НАЙМ. ТАЛУУД ХАРИЛЦАХ

8.1. Гэрээтэй холбоотойгоор Талууд хоорондоо харилцахдаа дараахь мэдээллийг үндэслэнэ.

8.1.1. Захиалагчийн хувьд:
Нэр: П.Даваадулам
Албан тушаал:
Хаяг:Төв аймаг Сэргэлэн сум 4-рбаг Эрдэнэ -Уул тахилт баг
Утас:+(976)-99062086
И- мэйл: davaadulam.p@nubia-llc.mn

8.1.2. Гүйцэтгэгчийн хувьд:
Нэр: Б. Жамбалсүрэн
Албан тушаал: Ойн аж ахуйн инженер
Хаяг: УБ хот Сүхбаатар дүүрэг Метро бизнес төв
Утас:+(976)-88079188, 7788-8811
И мэйл: Moongarden.m@gmail.com

8.2. Хэрэв талуудын аль нэг нь гэрээний 8.1 дэх хэсэгт заасан мэдээллэлдээ өөрчлөлт оруулах бол нөгөө талдаа ажлын 1-2 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдээгүйгээс үүссэн аливаа хохирол, зардлыг мэдэгдээгүй тал нь бүрэн хариуцна.

ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

9.1. **Зөвшилцөх:** Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал, зөрөлдөөн, маргааныг талууд харилцан зөвшилцөх эрмэлзлээр шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

9.2. **Шүүх:** Хэрэв гэрээний 9.1 дэх хэсэгт заасаны дагуу маргаан, зөрөлдөөнийг шийдвэрлэж чадахгүй бол Гүйцэтгэгч талын оршин буй дүүргийн буюу Монгол улсын шүүх болон бусад холбогдох хуулийн байгууллага, арбитраар шийдвэрлүүлнэ.

АРАВ. БУСАД ЗҮЙЛ

Захиалагч тал: _____ Гүйцэтгэгч тал: _____

10.1. **Нууцлал:** Талууд гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон харилцан солилцсон мэдээлэл, баримтын нууцлалыг Гэрээ байгуулагдсанаас хойш хугацаагүйгээр чанд хадгалах бөгөөд негөө Тал зөвшөөрөл олгосон эсвэл хууль тогтоомжоор шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх, Гэрээнд заагдаагүй зорилгоор ашиглахгүй байхаар тохиролцов.

10.2. **Гэрээ хүчин төгөлдөр болох:**

Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж, Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалснаар бүюу Гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно. Талууд гэрээ дуусгавар болгохтой холбоотойгоор гэрээг дүгнэсэн акт үйлдэж болно.

10.3. **Гэрээг цуцлах:** Гэрээний аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд хоёр тал харилцан зөвшилцсөний үндсэн дээр гэрээг цуцална.

10.4. **Нэмэлт, өөрчлөлт:** Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож, нэмэлт гэрээ байгуулсаны үндсэн дээр шийдвэрлэнэ. Аль нэг тал гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа негөө талд бичгээр хүргүүлэх бөгөөд саналыг хүлээн авсан тал ажлын 2 хоногийн дотор хариу мэдэгдэх үүрэг хүлээнэ.

10.5. **Санал, хүсэлт:** Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, Гэрээг дуусгавар болгох, хугацаанаас Moongarden.m@gmail.com хаягаар баталгаат шуудангаар эсвэл биечлэн хүргүүлснийг хүчинтэйд тооцно.

10.6. **Гэрээний эх хувь:**

Гэрээг хоёр хувь үйлдэж, гүйцэтгэгч тал нэг хувийг, захиалагч тал нэг хувийг хадгалах бөгөөд эдгээр нь хууль зүйн хувьд адил хүчинтэй.

10.7. **Гэрээний хэл:**

Гэрээг Монгол хэлээр байгуулна. Захиалагч шаардсан бол Гэрээний дагуу хийгдэх баримт бичиг, захидал харилцаа болон гэрээний дагуу бэлтгэгдэж буй бусад баримт бичгийг мэргэжлийн Англи, Япон, Монгол хэл дээр бэлдэнэ.

АРВАН НЭГ. БАЙГАЛИЙН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

11.1. Аадар бороо, аянга цахилгаан, мөндөр, хүчтэй салхи шуурга, гэнэтийн цочир хүйтрэл, хэт халалт, хөрс усны онцлог, хүчтэй цасан шуурга, үер усны гамшгаас үүдэн гарах хохирлыг гүйцэтгэгч тал харнуцахгүй болно.

11.2. **Хүний хүчин зүйл:** Барилга болон ажилчидын хөл хөдөлгөөн дунд модны мөчир , иш хугарах, усны шуудуугаар ус хүчтэй урсаж мод бутыг гэмтээх, хүн амьтнаас үүдэлтэй аливаа хохирлыг гүйцэтгэгч тал хариуцахгүй болно.

11.3. Гүйцэтгэгч талын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдээр дамжуулан тус ажилбарыг нэмж хийлгүүлсэн тохиолдолд бүхий л хохирлыг захиалагч тал бүрэн хариуцна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

" НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ ХХК "	" МҮҮН ГАРДЕН ХХК"
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ	ЗАХИРАЛ
Китанка Такэфуми	Б.Сарантуяа
2022.09.29.	

Захиалагч тал: _____ Гүйцэтгэгч тал: _____

Хот цэцэрлэгжилт. Ногоон байгууламж

Хаяг: Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг 6-р хороо Метро бизнес төв
Холбоо барих: (+976-88079188)- (75158008)
И мэйл: info@moongarden.mn

АЖЛЫН ТАЙЛАН

2022.10.12

Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК нь захиргааны байрны гадна талдаа голт бор тарих үнийн санал авах тухай П.Даваадулам менежер 09-р сарын 15 өдөр email ирүүлж нэг өдрийн дараа үнийн санал бэлтгээд илгээв.09-р сарын 23 өдөр энэхүү үнийн санал нь хийгдэх хариу нь баталгаажсан тухай мүүн гарден ХХК руу мэдэгдэж дараах бичиг баримтыг бэлтгэж өгсөн.

1. *Гэрээний драфт*
2. *Компанийн гэрчилгээ*
3. *Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ*
4. *Үнийн санал эцсийн хувилбар*

Гэрээний драфт дээр хоёр тал харилцан хянаж санал зөвлөгөөгөө тусгаж 2-3 удаагийн засвар оруулж, 09-р сарын 28 өдөр гэрээ батлагдах эцсийн хувилбар бэлэн болсон.Ингээд 09-р сарын 30 өдөр гэрээнд тамга гарын үсэг зурж, төлбөрийн 40% нэхэмжлэх, төлбөрийн 30% нэхэмжлэх эх хувиар хургүүлсэн.

Үндсэн ажлын төйм мэдээ

№	*огноо*	*Утга*	*To do& done*
1	*10/1/2022*	*Талбайн хэмжилт хийж модны тогооны төлөвлөгөө хийгдэв.Захиалагч тал руу урьдчилсан email илгээв.*	*done*
2	*10/3/2022*	*Мүүн гарден ххк -ий ажилчид 11цагт ажлын талбай дээр ирсэн.Ойн аж ахуйн инженер Б.Жамбалсүрэн модны тогоо бэлтгэх талбайн зураглалыг Цэцэрлэгчдэд гаргаж өгч үндсэн модны тогоо 83 бэлтгэснээс талбайн байршилд өөрчлөлт гарч хэрэггүй болсон 12 тогоог буцааж талбайг хэвийн байдалд оруулав.Модны тогооноос гарсан хуучин хөрсийг машин авч явахад хялбар болгож талбайн цэвэрлэгээ хийж өнөөдрийн ажил дуусав.*	*done*
3	*10/4/2022*	*Өглөө 07:00 цагийн үед Хар шороо, элсний карьераас мод тарих шинэ хөрс талбайд бууж, хуучин хөрсийг ачиж явав.Үндсэн модны 69 тогооны хэмжээг нягталж дахин засаж сайжруулав.Дутуу модны тогоогоо бэлтгэж мод тарих хөрсөө найруулж тогоондоо хийж бэлтгэв. Тарих 85 голт бор мод 16:40 минутын үед мод үржүүлгийн талбайгаас ирсэн. (Мод үржүүлгийн талбай дээр модыг бэлтгэхэд 2 цаг , мод тээвэрлэх хугацаа нь замын хөөр талдаа 1:30 минут) Мод тарих ажлыг Ойн аж ахуйн инженер Б.Жамбалсүрэн, Цэцэрлэгчин Н.Төгөлдөр, Д.Гантогтох нар хийж бусад ажилчид хөрс нэмэх, модны хэлбэр байршлыг засах ажлыг гүйцэтгэв.Бүх*	*done*

		модны усалгааг хийхэд 50метр урттай шланк хэрэглэж хоёр захын хүрэхгүй байгаа хэсэг рүү 30л усны саваар зөөж усалгааг дуусгав.	
4	*10/5/2022*	*Ойн аж ахуйн инженер Б.Жамбалсүрэн цэцэрлэгчин Д.Гантогтох нар улдсэн хуучин хөрсийг шилжүүлэх ажил хийсэн. Модны тогоо нь усалгаа хийхэд хөрс нь доошоо суудаг учир дахин хөрс нэмээд өнөөдрийн усалгааг дахин хийсэн.Тарьсан 85 модондоо бл гумин бордоог шингэлж стандартын дагуу ашиглаж, бордох үйлчилгээ хийгдэв.Машин зам руу гарсан хөрс шоороог цэвэрлэж ажил дуусгавар болов.Байгаль орчин хариуцсан ажилтан Л.Амина -д 44л гумин бордоог хүлээлгэж өгөв.Мөн захиргааны байрын гадна улиас модыг тайрч зөгийн балаар будав.*	*done*
5	*10/11/2022*	*Талбайд усалгаа хийж, хоёр талаас талбай хүлээлцэж акт зурж, үлдэгдэл төлбөрийн нэхэмжлэх цаасаар хүргүүлэв.*	*done*
6	*10/12/2022*	*Мүүн гарден ХХК -ийн зүгээс "Усалгаа арчилгааны зөвлөгөөг" мөн 1 удаагийн усалгаа арчилгаа хийх үнийн санал хавсралтаар email -р хүргүүлсэн.*	*done*

Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК -ий зүгээс Төлөвлөлтийн хэлтсийн менежер Б.Энхсайхан , Байгаль орчин хариуцсан менежер Л.Амина,П.Даваадулам нар санал зөвлөгөө өгч, нээлттэй найрсаг, хурдан шуурхай хамтран ажилллаа.

МҮҮН ГАРДЕН ХХК

Нягтлан бодогч : С.Мөнхтуяа



НУБИЭ ХХК

Хавсралт 3

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

3/40 - 126

Гэрээ, журам, удирдамж, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, хурлын шийдвэр, дүрэм, дүгнэлт

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2021 оны 11 сарын 11-ний өдөр Дугаар: 961/21 Улаанбаатар хот

Энэхүү **ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ** (цаашид "Гэрээ" гэх)-г

Нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, Төв аймаг, Сэргэлэн сум, Эрдэнэ-Уул /41090/, Тахилт толгой албан ёсны хаягт байрлах, 3874095 тоот регистрийн дугаартай **"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт"** ХХК /цаашид **"Хэрэглэгч"** гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Като Такэо;

Нөгөө талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу-3 албан ёсны хаягт байрлах, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох **"Цаг уур, орчны шинжилгээний газар"** /цаашид **"Үйлчилгээ үзүүлэгч"** гэх/-ыг төлөөлж Дарга С.Энхтүвшин;

(цаашид тус бүрд нь **"Тал"**, хамтад нь **"Талууд"** гэх) нар Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон байгуулсан бегөөд Гэрээнд заасан үйлчилгээг үзүүлж ахлэх өдрийг **"Үйл ажиллагаа эхлэх өдөр"** байхаар харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гэрээний зорилго

1.1.1. Үйлчилгээ үзүүлэгч нь Монгол Улсын Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, "Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам", түүний тухай бүрд батлагдсан нэмэлт, өөрчлөлтүүд болон Иргэний нисэхийн багц дүрмийн хавсралтаар батлагдсан "Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах байгууллагыг гэрчилгээжүүлэх дүрэм" болон бусад холбогдох дүрэм, журам, заавар, стандартыг удирдлага болгон Хэрэглэгчид нислэгийн цаг уурын мэдээг зохих журмын дагуу хангаж үйлчлэх (цаашид Үйлчилгээ гэх), Гэрээнд тусгагдсан нөхцөлийн дагуу үйлчилгээний төлбөрийг төлөх, Талуудын хамтын ажиллагааг зохицуулахад Гэрээний зорилго оршино.

1.1.2. Гэрээнд ашиглагдаж байгаа нэр томьёо нь Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Иргэний нисэхийн баг дүрмийн хавсралтаар батлагдсан "Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах байгууллагыг гэрчилгээжүүлэх дүрэм", Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга болон Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 06-ны өдөр хамтран батлсан "Нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх, мэдээг хамтран ажиллах ерөнхий гэрээ"-нд тусгагдсан нэр томьёотой ижил утгатай бөгөөд дараах утгаар ойлгоно. Үүнд:

ЧХОУНБ	"Чингис хаан" Олон улсын нисэх буудал
ОУИНБ	Олон улсын иргэний нисэхийн байгууллага
METAR	Цаг уурын бодит ажиглалтын мэдээний нэр (Meteorological Aerodrome Report)

НЦУТ	Нислэгийн цаг уурын төв
НЦУӨ	Нислэгийн цаг уурын өртөө
ШУХТ	Шуурхай удирдлага, хяналтын төв
Үйл ажиллагаа эхлэх өдөр	Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагаар Нисэхийн мэдээллийн эмхтгэлээр зарлуулсан ЧХОУНБ-ын үйл ажиллагаа эхлэх өдөр.

1.2. Гэрээний дагуу үзүүлэх Үйлчилгээний үнэ, төлбөр тооцооны нөхцөл.

1.2.1. Хэрэглэгч нь Үйлчилгээ үзүүлэгчид ЧХОУНБ-ын цаг агаарын мэдээний хангалтын үйлчилгээний нэг сарын төлбөрт 2 715 000 (Хоёр сая долоон зуун арван таван мянга) (цаашид "Үйлчилгээний төлбөр" гэх) тогтоогийг Үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу төлөх ба энэхүү төлбөрт холбогдох татвар, хураамж, Үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны бусад нэмэлт зардлууд багтсан эцсийн үнэ байна.

1.2.2. Хэрэглэгч нь дээрх 1.2.1-р зүйлд заасан Үйлчилгээний төлбөрийг Гэрээний Үйл ажиллагаа эхлэх өдрөөс эхлэн буюу Үйлчилгээ үзүүлэгчээс Гэрээнд заасан үйлчилгээг авч эхэлснээс хойш улирал бүр багцалж төлөх буюу 1, 2 болон 3 дугаар улирлын үйлчилгээний төлбөрийг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор, 4 дүгээр улирлын үйлчилгээний төлбөрийг 10 сарын 30-ны дотор доорх дансанд Үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу ажлын 3 хоногт багтаан төлнө:

Банкны нэр: Төрийн сан;
Дансны дугаар: 100900013044

1.2.3. Үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанаас 14 хоногоос 1 сараар хэтрүүлбэл хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх алданги ногдуулна.

1.3. Зохицуулалтын баримт бичиг

1.3.1. Гэрээг боловсруулахдаа дараах баримт бичгийг удирдлага болгосон болно. Үүнд:

- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 187 дугаар тушаалаар батлагдсан Иргэний нисэхийн багц дүрмийн Хавсралт 9 дэх "Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах байгууллагыг гэрчилгээжүүлэх" дүрэм;
- Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга болон Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 06-ны өдөр хамтран батлагдсан "Нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх, мэдээг хамтран ажиллах ерөнхий гэрээ";
- Нисэх буудлын ерөнхий заавар;
- ОУИНБ-ын Хавсралт 3 /Annex 3/

1.3.2. Гэрээг хэрэгжүүлэх явцад шаардлагатай холбоо барих жагсаалт:

а) НЦУТ-ийн мэдээлэл дамжуулах хаяг, утас, факс:
Синоптик инженер: 7128-3092, 7128-7279

Нислэгийн цаг уурын ертөөний инженер: 7128-7260
Факс: 70049869, 70045622
Веб сайт: www.amc.namem.gov.mn

- b) Хэрэглэгчийн Шуурхай удирдлага, хяналтын төвд:
  7128-7340, 7128-7310

- Хэрэглэгчийн Аэродромын хэлтэст:
  7128-7337, 85050542

- Хэрэглэгчийн Аврах, гал унтраах хэлтэст:
  7128-7311

Хоёр. Талуудын хүлээх үүрэг

2.1. Нислэгийн цаг уурын төвийн хүлээх үүрэг

2.1.1. ЧХОУНБ-ын цаг агаарын өдөр тутмын урьдчилсан мэдээг "Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам"-д заасны дагуу аэродром орчмын урьдчилсан болон нарийвчилсан мэдээг өдөрт 2 удаа 09:00 ба 21:00 цагуудад /амралтын өдрүүдэд 10:00 болон 21:00 цагт/ Шуурхай удирдлага хяналтын төвд 7128-7340 болон 7128-7310, Аэродромын хэлтэст 7128-7337, 85050542, Аврах, гал унтраах хэлтэст 7128-7311 дугаарын утаснуудад тус тус өгнө.

2.1.2. ЧХОУНБ-ын цаг агаарын 7 хоногийн урьдчилсан мэдээг 7 хоног бүрийн 1 дэх өдөр Шуурхай удирдлага хяналтын төвийн airportops@nubia-llc.mn болон Аэродромын хэлтсийн aerodrome@nubia-llc.mn хаягуудаар тус тус илгээнэ.

2.1.3. Цаг агаарын онцгой нөхцөл байдал үүссэн үед "Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам"-ын I дэвтрийн 6-р бүлэгт заасны дагуу Шуурхай удирдлага, хяналтын төвд, Аэродромын хэлтэст нисэх буудал орчмын мэдээг 3 (гурван) цаг тутамд, цаг агаарын бодит мэдээг 30 (гучин) минут тутамд НЦУТ-ийн www.amc.namem.gov.mn цахим хаягаар тогтмол шинэчилж өгнө. Үүнд:

- Аадар бороо;
- Дуу цахилгаан;
- Мөндөр;
- Цас;
- Зайрмагтсан хур тунадас;
- Цан хяруу;
- Мөстөлт;
- Элсэн ба шороон шуурга;
- Газрын салхины хурд нь хязгаарлалтаас давж ерөвхийлөлт ажиглагдах;
- Нөөлөг салхи.

2.1.4. "Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам" I дэвтрийн 7-р бүлэгт заасны дагуу нарийвчилсан урьдчилсан мэдээг боловсруулж 1 (нэг) цагаас багагүй хугацааны өмнө дамжуулна. Нөхцөл бүрдсэн үед "Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам" I дэвтрийн Нэмэлт 5-ын 4-т заасны дагуу шуурхай нарийвчилсан мэдээгээр

шуурхай хангана.

2.1.5. Цаг агаарын нехцөл хүндэрсэн үед урьдчилан сэргийлэх болон нарийвчилсан урьдчилсан мэдээг Хэрэглэгчийн Шуурхай удирдлага, хяналтын төвд, Аэродромын хэлтэст болон Аврах, гал унтраах хэлтэст бичлэгтэй утсаар егөх ба урьдчилсан мэдээг дэвтэрт тэмдэглэн гарын үсэг зурж, баталгаажуулна.

2.1.6. Нислэгийн цаг уурын төвөөс дамжуулсан цаг уурын мэдээнүүд нь Олон улсын иргэний нисэхийн байгууллага, Дэлхийн цаг уурын байгууллагын шаардлагын дагуу 80-аас доошгүй хувийн мэдээний таарцтай байна.

2.1.7. Нислэгийн цаг уурын төв нь ЧХОУНБ-ын аэродром орчмын алсын барааны харагдац 800м-ээс бага болох, хөөрөлт буултын зурвасны дагуух алсын барааны харагдац 550м-ээс бага болох үед алсын барааны харагдацын мэдээллийг Шуурхай удирдлага, хяналтын төвд урьдчилан болон тухай бүрд мэдээлнэ.

2.1.8. НЦУТ-ийн инженерүүд нь хөөрч буух зурвасны дэргэдэх цаг уурын станц, тоног төхөөремж зэргийг шалгах зайлшгүй ажлын шаардлагаар хөөрч буух зурвасыг хөндлөн нэвтрэхдээ Шуурхай удирдлага, хяналтын төвийн Аэродромын үзлэг, хяналтын инженерээр дамжуулан НХҮА-ны цамхгийн нислэгийн удирдагчтай богино долгионы станцаар зөвшөөрөл авч ажиллана.

2.1.9. Хэрэглэгчийн холбогдох ажилтнуудад цаг уурын мэдлэгийг бататгах сургалтыг хүсэлтийн дагуу явуулах, дадлагын хичээл хийх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

2.2. Хэрэглэгчийн хүлээх үүрэг

2.2.1. Цаг агаарын онцгой нехцөлийн тухай мэдээлэл авсан даруйд Гэрээний 1.3-т заасан дүрэм журамд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

2.2.2. Аэродромын алба нь цаг уурын эзлжийн синоптик инженерүүдтэй байнгын холбоотой байж, нэмэлт мэдээ, зөвлөгөөг авахаас гадна, цаг агаарын аюултай үзэгдэл эхлэхээс 1 цагийн өмнө уг үзэгдэлтэй тэмцэх /арилгах/ технологийн үйл ажиллагаанд шаардагдах техник хэрэгсэл, хүн хүчийг бэлэн болгоно.

2.2.3. Цаг агаар хүндэрсэн үед ажлын ачааллаас шалтгаалж Нислэгийн цаг уурын төвөөс цаг агаарын мэдээг 2.1.1-д заасан хугацаанд авч чадаагүй тохиолдолд Шуурхай, удирдлага, хяналтын төвийн эзлжийн менежер болон Аэродромын үзлэг, хяналтын инженер 7128-7279 утсаар залгаж авна.

2.2.4. НЦУТ-ийн ажилтнуудыг эрүүл ахуй, хеделмер хамгааллын нехцөлд тохирсон ажлын байр, дулаан, цахилгаан, холбооны сувгаар хангаж, зохих төлберийг нэхэмжлэхийн дагуу авна.

2.2.5. НЦУТ-ийн сүлжээний тоног төхөөремж байрлах ерөөнд НЦУТ-ийн инженер, техникийн ажилтнуудыг саадгүй нэвтрэх бололцоогоор хангана.

2.3. Талуудын хүлээх хариуцлага

2.3.1. Гэрээнд заагдсан үүргээ аль нэг тал биелүүлээгүйгээс болон харилцан явуулсан мэдээллүүдийн таарц, боловсруулалтын шаардлага хангахгүйгээс нислэгийн аюулгүй байдал, тогтмолжилтыг хангах асуудал зөрчигдвөл аль буруутай тал Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээж, Гэрээний негее талд

учирсан хохирлыг нөхөн төлнө.

2.3.2. Шуурхай удирдлага, хяналтын төвийн Аэродромын үзлэг, хяналтын инженер нь Нислэгийн цаг уурын төвөөс дамжуулсан цаг уурын мэдээний таарцын бүртгэлийг хөтлөх бөгөөд бүртгэлийн дагуу гэрээний биелэлтийг дүгнэнэ.

2.3.3. Хэрэв гэрээний 2.1.1-т заасан нислэгийн цаг уурын мэдээг Нислэгийн цаг уурын төв нь Шуурхай удирдлага, хяналтын төвд мэдээлээгүйгээс нислэгийн саатал, зөрчил, осол гарвал Шуурхай удирдлага, хяналтын төв хариуцлага хүлээхгүй.

2.3.4. Талууд Гэрээний хугацаанд үүссэн аливаа маргааныг хэлцлийн замаар шийдвэрлэхийг хичээх ба 30 хоногийн дотор шийдвэрлэж чадаагүй тохиолдолд маргааныг Монголын Олон Улсын Арбитраар шийдвэрлүүлнэ.

Гурав. Бусад

3.1. Давагдашгүй хүчин зүйл

3.1.1. Талууд байгалийн гамшиг, цаг уурын хүчтэй өөрчлөлт, дайн байлдаан, иргэний бослого үймээн, гал түймэр, үер, тахал, газар хөдлөлт, хөл хорио, төвөрийн хориг гэх мэт давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр Гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь болон хэсэгчлэн биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд тэрхүү давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлд үл хамаарах үүргээ үргэлжлүүлэн биелүүлэх ба давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл арилмагц үүргээ бүхэлд нь үргэлжлүүлэн биелүүлэх үүрэгтэй.

3.1.2. Аль нэг тал нь давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр түүний үргэлжлэх хугацаанд Гэрээгээр хүлээсэн үүргээ Гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу биелүүлэх боломжгүй болсон нь Гэрээгээр хүлээсэн үүргийн зөрчилд тооцогдохгүй.

3.1.3. Талууд 3.1.1-д заасан нөхцөл байдал эхлэх, дуусах талаар нэн даруй мэдэгдэнэ.

3.2. Бусад

3.2.1. Гэрээ нь Талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээ нь 1.1.2 дагуу Үйл ажиллагаа эхлэх өдөр эхэлж, 1 (нэг) жилийн хугацаанд хэрэгжинэ.

3.2.2. Тал нь гэрээнд өөрчлөлт, нэмэлт оруулах санал тавьсан үед Талууд хамтран хэлэлцэж, протоколоор баталгаажуулах бөгөөд харилцан тохиролцсон аливаа нэмэлт, өөрчлөлт нь Гэрээний салшгүй хэсэг байна.

3.2.3. Гэрээний биелэлтийг жилээр дүгнэх ба өөрчлөх, нэмэлт оруулах санал аль нэг тал гаргаагүй бол хугацааг 1 (нэг) жилээр сунгасанд тооцно.

3.2.4. Гэрээг Монгол, Англи хэл дээр байгуулах ба батлагдсан хоёр Гэрээний утга агуулга зөрчилдвөл Монгол хэл дээр баталсан Гэрээний утга агуулгын дагуу зохицуулна.

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТЛОН, Гэрээний талууд нь Гэрээнд түүний эхэнд бичигдсэн он, сар, өдөр гарын үсэг зурав.

ХЭРЭГЛЭГЧ:

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ:

ГЭРЭЭГ БАТАЛСАН :

ХЭРЭГЛЭГЧИЙГ төлөөлж:

"НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

ТАКЭО КАТО

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА

.....

С.ЭНХТҮВШИН

НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН ДАРГА:

.....

Б.БАНЬДСҮРЭН

"Нислэгийн цаг уурын төв болон "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК хоорондын хамтран ажиллах гэрээ"-ний хэрэгжилт, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан акт

2022-11-01 № 261/21 Улаанбаатар хот

1. Гэрээний хэрэгжилт, өөрчлөлтийн санал

Бүлэг, заалтууд	Бүлэг болон заалтуудын хэрэгжилт хангалттай эсэх, өөрчлөлтийн санал байгаа эсэх	
	"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт"	Нислэгийн цаг уурын төв
Нэг. Ерөнхий зүйл	Хэрэгжилт хангалттай эсэх: ***хангалттай***	Хэрэгжилт хангалттай эсэх: ***хангалттай***
	Бүлэг дэх заалтуудад өөрчлөлт оруулах санал байгаа эсэх ***байхгүй.***	Бүлэг дэх заалтуудад өөрчлөлт оруулах санал байгаа эсэх ***байхгүй.***
Хоёр. Талуудын хүлээх үүрэг. 2.1. Нислэгийн цаг уурын төвийн хүлээх үүрэг	Хэрэгжилт хангалттай эсэх: ***хангалттай***	Хэрэгжилт хангалттай эсэх: ***хангалттай***
	Бүлэг дэх заалтуудад өөрчлөлт оруулах санал байгаа эсэх ***байхгүй.***	Бүлэг дэх заалтуудад өөрчлөлт оруулах санал байгаа эсэх ***байхгүй.***
2.2. "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК буюу хэрэглэгчийн хүлээх үүрэг	Хэрэгжилт хангалттай эсэх: ***хангалттай***	Хэрэгжилт хангалттай эсэх: ***хангалттай***
	Бүлэг дэх заалтуудад өөрчлөлт оруулах санал байгаа эсэх ***байхгүй.***	Бүлэг дэх заалтуудад өөрчлөлт оруулах санал байгаа эсэх ***байхгүй.***
2.3. Талуудын хүлээх хариуцлага	Хэрэгжилт хангалттай эсэх: ***хангалттай***	Хэрэгжилт хангалттай эсэх: ***хангалттай***
	Бүлэг дэх заалтуудад өөрчлөлт оруулах санал байгаа эсэх ***байхгүй.***	Бүлэг дэх заалтуудад өөрчлөлт оруулах санал байгаа эсэх ***байхгүй.***
Гэрээний хэрэгжилт болон өөрчлөлтийн талаар ямар нэг санал байгаа эсэх	***байхгүй.***	***байхгүй.***

46

2. Ерөнхий дүгнэлт

2.1. Гэрээний хэрэгжилтийг **"Хангалттай"** гэж дүгнэв.

2.2. Талууд гэрээний хугацаанд хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн бөгөөд нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тул энэхүү бариимтыг үйлдэв.

2.3. "Үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний 3.2.3 дахь заалтын дагуу 2022 оны 11 сарын 11-ний өдрөөс 2023 оны 11 сарын 11-ний өдөр хүртэл 1 жилээр сунгав.

3. Гэрээний хэрэгжилт

Гэрээний хэрэгжилт дүгнэсэн албан тушаалтан:

Нислэгийн цаг уурын төвийг төлөөлж:

Дарга.....Б.Баньдсүрэн

Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК-ийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал .....Китанака Такэфуми

47



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН ГУРВАН ШАТНЫ ХЯНАЛТЫН ЖУРАМ

B1-2021-04

Төв аймаг

2021

48

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХУУДАС

Энэхүү хуудас нь "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтын журам"-ын хамт хүчин төгөлдөр байна.

Байгууллага: "НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ" ХХК

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ГУРВАН ШАТНЫ ХЯНАЛТЫН ЖУРАМ

Боловсруулсан	Хянасан	Баталсан
Албан тушаал: "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн Аюулгүй ажиллагааны хэлтсийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн	Албан тушаал: "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн Аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга	Албан тушаал: "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн гүйцэтгэх захирал
Нэр: С.Билгүүн	Нэр: Н.Батзориг	Нэр: Като Такэо
Гарын үсэг:.....	Гарын үсэг:.....	Гарын үсэг:.....
Огноо..... 2021.11.18	Огноо..... 2022.01.11	Огноо.....

БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Document control

Баримт бичгийн дэлгэрэнгүй Document Details					
1	Баримт бичгийн нэр Document Name	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтын журам			
2	Баримт бичгийн зорилго Purpose of the Document	"НУБИЭ" ХХК-ийн нийт ажилчдын ХАБЭА-н үүрэг оролцоог бий болгох, аюулгүй ажиллагааны соёл, эерэг хандлагыг төлөвшүүлэх үүднээс холбогдох албан тушаалтнууд нь нэг эх үүсвэрийг ашиглахад оршино.			
3	Баримт бичгийн код Unit Identification	**B1-2021-04**			
4	Хуудасны тоо /Total page/	11			
5	Хэлбэр Document type	A4			
6	Хариуцах албан тушаалтан Document Owner	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн			
7	Батлагдсан огноо Date approved	2022			
8	Баталсан байгууллага, албан тушаалтан Approved by	"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн гүйцэтгэх захирал			
9	Өөрчлөлт, нэмэлт орсон байдал /Amendments/	-			
10	Баримт бичгийн бүтэц Document structure	3 бүлэг			
11	Хавсралт	.....			
12	Тараагдсан байдал Distribution	Хэлтэс, алба Division name	Дугаар Number	Хувь Version	Гарын үсэг Signature
		Гүйцэтгэх захирал			
		ЗУГ			
		ААААБГ			
		АГУХ			
		ШУХТ			
		ИТГ			
		ГҮГ			
		ЗТГ			
		ТЗГ			
		Нийт Total			

"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтын журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах ажилтан доорх хүснэгтийг заавал бөглөсөн байна.

НЭМЭЛТ БОЛОН ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Procedures for amendments record

НЭМЭЛТҮҮД					
Д/д	Нэмэлт өөрчлөлт оруулсан огноо	Нэмэлт өөрчлөлтийн зүйл, заалтын дугаар	Тэмдэглэгээ /-/,/+/	Нэмэлт өөрчлөлт оруулсан ажилтны нэр/гарын үсэг	Хянасан албан тушаалтны нэр/гарын үсэг
1					
2					
3					

АГУУЛГА

БҮЛЭГ	ГАРЧИГ	ХУУДАС
	Баталгаажуулалтын хуудас	1
	Баримт бичгийн хяналтын мэдээлэл	2
	Нэмэлт болон өөрчлөлтийн бүртгэл	3
	Журмын агуулга	4
НЭГ	ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	5
1.1	Зорилго	5
1.2	Хамрах хүрээ	5
1.3	Эрх зүйн үндэслэл	5
ХОЁР	ГУРВАН ШАТНЫ ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	5
2.1	Гурван шатны хяналт, шалгалтын зохион байгуулалт	5
2.2	Нэгдүгээр шатны хяналт	6
2.3	Хоёрдугаар шатны хяналт	7
2.4	Гуравдугаар шатны хяналт	8
ГУРАВ	ХАРИУЦЛАГА	10

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Зорилго

НУБИЭ ХХК-ийн үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаа нь ХАБЭА-н тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, стандарт шаардлага, ХАБЭА-н УТ-ны холбогдох дүрэм, журам, зааварт нийцэж байгаа эсэхэд компанийн бүхий л хэсэг нэгжийн хэмжээнд ажлын байрны болон ажил гүйцэтгэх үеийн эрсдэл, түүнийг үнэлсэн байдал, аюулгүй байдлыг хангаж буйд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, залруулах арга хэмжээнд ажилтан бүрийн үүрэг оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

1.2 Хамрах хүрээ

Энэхүү журам нь хяналт шалгалтын төрөл, зохион байгуулалтын арга хэмжээг тодорхойлох бөгөөд компанийн газар, хэлтсийн бүх нэгжүүдэд хамаарна.

1.3 Эрх зүйн үндэслэл

"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтын журам"-(цаашид ХАБЭА-н ГШХЖ гэх) нь дараах хууль, эрх зүйн баримт бичиг, стандарт шаардлагад үндэслэн боловсруулагдсан болно. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай МУ-ын хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол: /ААНБ-н үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам/;
- ХАБЭА-н УТ MNS ISO 45001:2018 стандартын шаардлага;
- НУБИЭ ХХК-ийн ХАБЭА-н УТ-ны зааврын шаардлага

ХОЁР. ГУРВАН ШАТНЫ ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Гурван шатны хяналт, шалгалтын зохион байгуулалт

2.1.1. Компанийн газар, хэлтсийн ажлын байр бүрд ХАБЭА-н хууль тогтоомж, нийтлэг шаардлага, стандартын хэрэгжилт, ажлын байрны аюул эрсдэл, үл нийцлийг илрүүлэх зорилгоор "Гурван шатны хяналт" шалгалтыг хэрэгжүүлж ажиллана.

2.1.2. ХАБЭА-н Гурван шатны хяналт, шалгалтыг газар, хэлтсийн удирдах албан тушаалтан, ХАБЭА-н зөвлөлийн гишүүд, инженер техникийн удирдах ажилтнууд, ажилчид хэрэгжүүлнэ.

2.1.3. ХАБЭА-н Гурван шатны хяналт, шалгалт нь төлөвлөгдсөн хугацаанд явагддаг шалгалт бөгөөд дараах үндсэн чиглэлийг агуулна. Үүнд:

- Аюулыг тогтоох, эрсдэлийг үнэлэх, хяналтыг тодорхойлох үйл ажиллагааг шалгах;
- Ажилтнуудын ХАБЭА-н талаархи мэдлэг чадвар, ХАБЭА-н сургалт, зааварчилгаанд хамрагдсан байдал;
- Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуйн шаардлага хангасан байдал,

- ХАБЭА-н холбогдох журам, зааврыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллаж буй байдал,
- Техник тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал гэх мэт.....

2.1.4. Гурван шатны хяналт, шалгалтаар илэрсэн үл нийцэл, түүний дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ хариуцах албан тушаалтныг "Гурван шатны хяналтын дэвтэр"-т бичиж тэмдэглэнэ.

2.1.5. "Гурван шатны хяналтын дэвтэр"-т тэмдэглэгээ хийсэн албан тушаалтан, багийн гишүүд нь үл нийцлийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтэд хяналт тавьж ажиллана.

2.1.6. Гурван шатны хяналтыг доор дурдсан албан тушаалтнууд дотоод хяналт шалгалт хийх, зохион байгуулах үүрэг хүлээнэ. Үүнд:

- **Нэгдүгээр шатны хяналт**-ыг ажилтан, шууд удирдлага буюу анхан шатны удирдлага, инженер;
- **Хоёрдугаар шатны хяналт**-ыг харъяа газар, хэсгийн ахлах мэргэжилтэн, ахлах инженер, техникийн ажилчдын баг;
- **Гуравдугаар шатны хяналт**-ыг харъяа газрын дэд дарга, буюу түүнтэй адилтгах албан тушаалтан, /менежер/ ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан буюу ХАБЭА-н зөвлөлийн гишүүн, холбогдох инженер техникийн ажилчдын баг,

2.2. Нэгдүгээр шатны хяналт

2.2.1. Ажил гүйцэтгэж байгаа ажилтан нь ХАБЭА-н сэргийлэх арга хэмжээ болох "Нэгдүгээр шатны хяналт"-ыг ажилтанд наряд, даалгавар, зааварчилгаа өгөгч буюу анхан шатны удирдах ажилтан (тухайлбал: мэргэжилтэн, инженер, механик, бригадын дарга)-ны хамтаар ажлын байран дээр явуулна.

2.2.2. Нэгдүгээр шатны хяналтыг тус тусын хариуцсан ажлын байранд ажил эхлэхийн өмнө (ээлж хүлээлцэх үе) 15 минутаас багагүй хугацаанд хийх ба энэ хяналтыг ажлын явц, ээлжийн хугацааны туршид хэрэгжүүлэн ажиллана.

2.2.3. Хяналт шалгалтаар дараах зүйлсийг шалгана. Үүнд:

- Ажлын байран дахь багаж хэрэгсэл, сэлбэг материалын эмх цэгцтэй байдал,
- Машин техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн хэвийн ажиллагаатай байдал,
- Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөнт хэсгийн хаалт, хамгаалалт, аюултай бүс, орчинд байх анхааруулах, хориглох тэмдэг, тэмдэглэгээний бүрэн бүтэн, харагдах байдал,
- Ажлын шат давцан, зам талбай,
- Галын дохиоллын систем болон галтай тэмцэж багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, ажиллагаатай эсэх,
- Ажлын тусгай хувцас, аврах, хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдал,

- Ажилд хэрэглэгдэж буй химийн бодис материал, түүний хадгалалт хамгаалалт,
- Цахилгааны аюулгүй байдал,
- Урд өмнө хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдал,

2.2.4. Албан тушаалтан /ажилтан/ нь илэрсэн үл нийцлийг газар, хэлтсийн зөрчлийг бүртгэх дэвтэр буюу эргэлт шалгалтын дэвтэрт тэмдэглэж удирдах албан тушаалтандаа энэ тухай мэдэгдэнэ.

2.2.5. Шууд удирдах албан тушаалтан нь илрүүлсэн болох мэдээлэгдсэн аюул эрсдэл нь маш ноцтой гэж гэж үзсэн тохиолдолд " ХАБЭА-н 3 шатны хяналтын дэвтэр"-н 1 дэхь шатны хяналт гэсэн хүснэгтийн дагуу бичилт хийж, зөрчлийг арилгах хугацаа, авах арга хэмжээ, хариуцагчийг тодорхойлж бичих ба хяналт, шалгалт хийсэн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

2.2.6. Шууд удирдах албан тушаалтан үл нийцлийг аргилгах хугацаа, авах арга хэмжээний биелэлтэд хяналт тавьж ажиллана.

2.2.7. Шалгалтаар илэрсэн үл нийцлийг өөрсдийн хүчээр арилгах боломжгүй бол дээд шатны албан тушаалтанд мэдээллэж, сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.

2.2.8. Нэгдүгээр шатны хяналтаар илэрсэн үл нийцлийг илрүүлсэн ажилтан, холбогдох шууд удирдлага нь ажил эхлэхийн өмнө наряд зааварчилгаанд бусад ажилчдад болзошгүй аюул эрсдэлээс сэргийлэх үүднээс мэдээлж, хэрхэн сэргийлэх арга хэмжээ авч ажиллах талаар зааварчилгаа өгсөн байна.

2.2.9. Үл нийцлийг арилгах үүрэг авсан албан тушаалтан заасан хугацаанд үл нийцэлд хэрхэн арга хэмжээ авч ажилласан тухай бичилт хийж гарын үсэг зурсан байна.

2.3. Хоёрдугаар шатны хяналт

2.3.1. ХАБЭА-н сэргийлэх арга хэмжээ болох /Хоёрдугаар шатны хяналт/-ыг газар хэлтсийн ахлах инженер /ахлах мэргэжилтэн/-ийн удирдлаган доор бусад холбогдох мэргэжилтэн, инженер техникийн ажилчдын хамтаар ажлын байран дээр явуулна.

2.3.2. Хоёрдугаар шатны хяналтыг сард 1-с доошгүй удаа харъяа газар, хэлтсийн ажлын байруудад явуулна.

2.3.3. Хяналт шалгалтаар дараах зүйлсийг шалгана. Үүнд:

- Нэгдүгээр шатны хяналтыг хэрэгжүүлж буй байдал, зөрчил дутагдлыг арилгасан, арга хэмжээ авагдсан байдал,
- Барилга байшин, машин механизм, техник тоног төхөөрөмж, даралтад сав, цахилгааны эх үүсгэвэр, өргөх зөөх тээвэрлэх механизм стандарт, дүрмийн шаардлагыг хангаж байгаа, тэдгээрийг гэмтэлгүй хэвийн ажиллаж байгаа эсэх,

- Үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглагдаж байгаа тэсэрч дэлбэрэх бодис, галын аюултай бодис, материалын хадгалалт аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байдал,
- Ажилчдад аюулгүй ажиллагааны наряд, ажлын даалгавар, зааварчилгаа өгөгдсөн байдал,
- Ажилчдын ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүрэгтэй нь холбоотой аюулгүй ажиллагааны дүрэм, журам, үйл ажиллагааны зааврыг сахин мөрдөж байгаа байдал,
- Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, тэдгээрийг зөв өмссөн, ашиглаж байгаа эсэх,
- Ажлын байрны эмх цэгц, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл байдал,
- Галтай тэмцэх багаж хэрэгслийн иж бүрдэл, түүний бүрэн бүтэн хэвийн найдвартай ажиллагаа, баталгаажуулалт хийгдсэн байдал,
- Аврах орц, гарц чөлөөтэй эсэх,
- Аюулгүй ажиллагааны санамж плакат, хаалт хамгаалалтын хэвийн ажиллагаа,
- Ажлын байрны эмх цэгц,
- Цоож пайз ашиглах журам, заавар мөрддөг эсэх, цоож пайз тавьсан байдал,

2.3.4. Хоёрдугаар шатны хяналтаар илэрсэн үл нийцлийг " ХАБЭА-н 3 шатны хяналтын дэвтэр"-н 2 дахь шатны хяналт гэсэн хүснэгтийн дагуу бичилт хийж, үл нийцлийг арилгах хугацаа, авах арга хэмжээ, хариуцагчийг тодорхойлж бичих ба багийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

2.3.5. Хоёрдугаар шатны хяналтыг удирдан явуулсан ахлах инженер /мэргэжилтэн/ нь хэлтсийн ажилчдад үзлэг шалгалтаар илэрсэн үл нийцлийн талаарх мэдээлэл хийж, сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.

2.3.6. Үл нийцлийг арилгах үүрэг авсан албан тушаалтан заасан хугацаанд нь үл нийцэлд хэрхэн арга хэмжээ авч ажилласан тухай бичилт хийж гарын үсэг зурсан байна.

2.3.7. Хоёрдугаар шатны хяналтыг гүйцэтгэсэн албан тушаалтнууд тодорхой хугацааны дараа хяналт шалгалтын авах хариу арга хэмжээний биелэлтийг шалгана.

2.4. Гуравдугаар шатны хяналт

2.4.1. ХАБЭА-н сэргийлэх арга хэмжээ болох /Гуравдугаар шатны хяналт/-ыг газрын дэд дарга, буюу түүнтэй адилтгах албан тушаалтан /менежер/ ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан буюу ХАБЭА-н зөвлөлийн гишүүн, харъяа газар хэлтсийн холбогдох албан тушаалтнуудын хамтаар хяналт шалгалт хийнэ.

2.4.2. Гуравдугаар шатны хяналт шалгалтыг улиралд 1-с доошгүй удаа хийнэ.

2.4.3. Хяналт шалгалтаар дараах зүйлсийг шалгана. Үүнд:

- ХАБЭА-н 1,2-р шатны хяналт шалгалт хийсэн байдал, өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж арга хэмжээ авагдсан байдал,

- ХАБЭА-н чиглэлээр гаргасан дүрэм, журам, зааврын хэрэгжилт,
- Барилга байгууламж, техник, тоног төхөөрөмж, машин механизм, тээврийн хэрэгсэл, даралтад сав, цахилгааны эх үүсгэвэр, өргөх, зөөх, тээвэрлэх механизмын техникийн бүрэн бүтэн найдвартай хэвийн ажиллагаа, арчлалт, засвар үйлчилгээ, техникийн бичиг баримт, карт хөтлөлт, бусад аюулгүй ажиллагааны хяналт,
- ХАБЭА-н сургалт, зааварчилга явуулсан эсэх, ажилтны ур чадвар, мэдлэг,
- Ажилчдын ХАБЭА-н зөв дадал соёлд суралцсан байдал,
- Гар багаж хэрэгсэл, сэлбэг материал, шатах тослох материалын хадгалалт, хамгаалалт, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа,
- Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн хангалт, ашиглалт, чанар, түүний хэрэглээ,
- Холбогдох үйл ажиллагааны болон аюулгүй ажиллагааны зааврыг ажилчдад танилцуулсан байдал, түүний хэрэгжилт,
- Тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, паспорт хөтлөлт, баталгаажуулалт,
- Ажлын байрны эмх цэгц, дэг журам,
- Галын аюулгүй байдал, галтай тэмцэх багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, тэдгээрийн хадгалалт хамгаалалт,
- Цоож пайз ашиглах журам, зааврын дагуу түүнийг хэрэгжүүлж ажилладаг эсэх,
- Тусгай мэргэжил шаардсан ажлын байранд ажилладаг ажилдын үнэмлэх, сертификат байгаа эсэх түүний хүчинтэй хугацаа,
- Наряд, зааварчилгаа өгсөн байдал,
- ХАБ-ын заавар, онцгой нөхцөл байдал, төлөвлөгөөний талаарх мэдлэгийг түүвэрчлэн шалгах,
- Бусад.....

2.4.4. Гуравдугаар шатны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг " ХАБЭА-н 3 шатны хяналтын дэвтэр"-н 3 дахь шатны хяналт гэсэн хүснэгтийн дагуу бичилт хийж, зөрчлийг арилгах хугацаа, авах арга хэмжээ, хариуцагчийг тодорхойлж бичих ба багийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

2.4.5. Зөрчлийг арилгах үүрэг авсан албан тушаалтан заасан хугацаанд нь зөрчлийг арилгах арга хэмжээ авсан тухай бичилт хийж гарын үсэг зурна.

2.4.6. Хяналт шалгалтыг удирдан явуулсан албан тушаалтан нь тухайн хэсгийн ажилчдад үзлэг шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, үл нийцлийн талаарх мэдээллийг хийнэ.

2.4.7. Хяналтыг гүйцэтгэсэн албан тушаалтнууд тодорхой хугацааны дараа үл нийцэлд хариу арга хэмжээ авагдсан эсэхэд хяналт тавьж шалгана.

2.4.8. Газрын даргыг эзгүйд хяналт шалгалтыг удирдан явуулсан холбогдох албан тушаалтан газрын даргад шалгалтын үр дүн, илэрсэн зөрчил, дутагдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон цаашид юуг анхаарч ажиллах талаарх мэдээ мэдээллийг цаг тухай бүрт нь мэдэгдэж ажиллана.

ГУРАВ. ХАРИУЦЛАГА

3.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, үл нийцэлд холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй албан тушаалтанд Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ХООСОН ҮЛДЭЭВ



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГАА ӨГӨХ ЖУРАМ

B1-2021-03

2021

60

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХУУДАС

Энэхүү хуудас нь "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгөх журам"-ын хамт хүчин төгөлдөр байна.

Байгууллага: "НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ" ХХК

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГАА ӨГӨХ ЖУРАМ

Боловсруулсан	Хянасан	Батлсан
Албан тушаал: "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн Аюулгүй ажиллагааны хэлтсийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн Нэр: С.Билгүүн Гарын үсэг:..... Огноо.....2021.11.02	Албан тушаал: "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн Аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга Нэр: Н.Батзориг Гарын үсэг:..... Огноо.....2022.01.11	Албан тушаал: "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн гүйцэтгэх захирал Нэр: Като Такэо Гарын үсэг:..... Огноо.....

БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Document control

Баримт бичгийн дэлгэрэнгүй Document Details					
1	Баримт бичгийн нэр Document Name	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгөх журам			
2	Баримт бичгийн зорилго Purpose of the Document	"НУБИЭ" ХХК-ийн ХАБЭА-н үйл ажиллагааг аюулгүй, тогтмол, үр дүнтэй эрхлэх зорилгоор Монгол Улсын хууль, тогтоомж, норм, дүрэм, журам, стандарт, ХАБЭА-н УТ-ны зааварт нийцүүлэн ажиллахад холбогдох албан тушаалтнууд нь нэг эх үүсвэрийг ашиглахад оршино.			
3	Баримт бичгийн код Unit Identification	**B1-2021-03**			
4	Хуудасны тоо Total page	11			
5	Хэлбэр Document type	A4			
6	Хариуцах албан тушаалтан Document Owner	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн			
7	Батлагдсан огноо Date approved	2021			
8	Баталсан байгууллага, албан тушаалтан Approved by	"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн гүйцэтгэх захирал			
9	Өөрчлөлт, нэмэлт орсон байдал /Amendments/	-			
10	Баримт бичгийн бүтэц Document structure	4 бүлэг			
11	Хавсралт	.....			
12	Тараагдсан байдал Distribution	Хэлтэс, алба Division name	Дугаар Number	Хувь Version	Гарын үсэг Signature
		Гүйцэтгэх захирал			
		ЗУГ			
		ААБГ			
		АГУХ			
		ШУХТ			
		ИТГ			
		ГҮГ			
		ЗТГ			
		Нийт Total			

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгөх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах ажилтан доорх хүснэгтийг заавал бөглөсөн байх шаардлагатай.

НЭМЭЛТ БОЛОН ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Procedures for amendments record

НЭМЭЛТҮҮД					
Д/д	Нэмэлт өөрчлөлт оруулсан огноо	Нэмэлт өөрчлөлтийн зүйл, заалтын дугаар	Тэмдэглэгээ /-/,/+/	Нэмэлт өөрчлөлт оруулсан ажилтны нэр/гарын үсэг	Хянасан албан тушаалтны нэр/гарын үсэг
1					
2					
3					

АГУУЛГА

БҮЛЭГ	ГАРЧИГ	ХУУДАС
	Баталгаажуулалтын хуудас	2
	Баримт бичгийн хяналтын мэдээлэл	3
	Нэмэлт болон өөрчлөлтийн бүртгэл	4
	Журмын агуулга	5
НЭГ	ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	5
1.1	Зорилго	6
1.2	Хамрах хүрээ	6
ХОЁР	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ, ЗААВАРЧИЛГАА	6
2.1	Өдөр тутмын зааварчилгаа	6
2.2	Зааварчилгааны төрөл	7
2.3	Урьдчилсан зааварчилгаа	7
2.4	Ажлын байрны анхан шатны зааварчилгаа	7
2.5	Давтан зааварчилгаа	8
2.6	Тухайлсан зааварчилгаа	8
ГУРАВ	ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗААВАРЧИЛГАА	9
ДӨРӨВ	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	9

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Зорилго

1.1.1 Ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцад гэмтэж бэртэх, болзошгүй осолд орох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагаанд сургах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй /цаашид ХАБЭА гэх/-н зааварчилгааг оновчтой зохион байгуулахад оршино.

1.2 Хамрах хүрээ

1.2.1 Энэхүү хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаанууды "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн газар, хэлтэс, нэгжийн ажилтан бүр дагаж мөрдөнө.

ХОЁР. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ, ЗААВАРЧИЛГАА

2.1 Өдөр тутмын зааварчилгаа

2.1.1 ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгааг шууд удирдлага буюу тухайн ажлыг удирдан гүйцэтгүүлэх албан тушаалтан ажлын өдөр, ээлж ахалж буй ээлжийн ахлах ажил эхлэхийн өмнө удирдлага дах ажилтнуудад ярианы болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглаж 10 минутаас багагүй хугацаанд багтаан өгнө.

2.1.2 Ажлын байрны болон хийж гүйцэтгэх ажлын онцлогийг харгалзан ажилтныг зааварчилгаанд заавал хамруулна.

2.1.3 ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгаа өгөх албан тушаалтан нь зааварчилгааны дэвтрийг шинээр нээхдээ хуудас бүрийг дугаарлан баталгаажилтыг хийх ёстой.

2.1.4 Зааварчилгаа өгсөн тухай баримт бичиг, бүртгэлийн дэвтрийн бичилт гаргацтай, агуулга товч, тодорхой байх бөгөөд зааварчилгаа өгсөн, авсан ажилтны нэр, албан тушаал, гарын үсэг заавал байх ёстой.

2.1.5 Шууд удирдлага, инженер техникийн ажилтан нь ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгааны бүртгэлийн дэвтэрт хэвлэмэл хэлбэрээр тусгагдсан зааварчилгааг өгч болох ба ажил үүргийн хуваарьт холбогдох үйл ажиллагааны зааврыг ажилтанд сургалтаар танилцуулж баталгаажуулсан байна.

2.1.6 Ажилтан нь хэвлэмэл зааварчилгаанд тусгагдаагүй ажил үүргийг хийж гүйцэтгэх тохиолдолд өдөр тутмын зааварчилгаа өгөгч албан тушаалтан нь учирч болох аюул, эрсдэлээс хэрхэн сэргийлэх, ашиглагдах тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийн ашиглалтын зааврыг чандлан мөрдөх, хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн гүйцэт хэрэглэх зэрэг агуулгыг бүртгэлийн дэвтрийн "нэмэлт зааварчилгаа" хэсэгт гараар бичилт хийж танилцуулсан байхаас гадна шаардлагатай тохиолдолд дараах зүйлүүдийг аргачлан зааж өгнө. Үүнд:

- Ажил эхлэхийн өмнө аюул, осолгүй ажиллахад зайлшгүй шаардлагатай, авбал зохих аюулгүйн арга хэмжээнүүд;

- Ажил гүйцэтгэх үед аюул, осол, хордлогод өртөж болох хүчин зүйлүүд ба түүнээс болгоомжлох, анхаарах тухай;
- Ажил гүйцэтгэх үед хориглох зүйлүүд;
- Наряд, шийдвэр олгогч, ажлын даалгавар өгөгч, ажлын удирдагч, ажлын байр бэлтгэгч, ажилд оруулагч, ажлын хариуцлагатай гүйцэтгэгч, ажиглагч /хянагч/, бригадын гишүүдийн харилцан ажиллагаа;
- Ажлын багаж, хэрэгсэл, тэдгээрийг хэрхэн аюулгүй ашиглах тухай;
- Хамгаалах хэрэгслийг хэрхэн зөв ашиглах тухай;
- Радио харилцаа холбоог хэрхэн хангаж ажиллах тухай;
- Галын аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай,
- Цахилгааны аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай г.м;

2.1.7 Шууд удирдах албан тушаалтан өдөр тутмын зааварчилгаа өгөхдөө ажилтан бүрээс зааварчилгааг бүрэн гүйцэт ойлгосон эсэхийг асууж, тодруулах байдлаар нягталж, хэрэв ажлыг аюулгүй гүйцэтгэх арга барилын талаар хангалттай ойлголттой болоогүй байвал зааварчилгааг дахин өгч энэ тухай бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ.

2.1.8 Тухайн ажлын өдөр, ээлжийн хугацаанд шууд удирдлагаас зааварчилгаа аваагүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

2.2 Зааварчилгааны төрөл

2.2.1 Газар, хэлтэс, нэгжийн удирдлага, холбогдох албан тушаалтан MNS 4969:2000 стандарт, ХАБЭА-н УТ-ны 8.3-т тусгагдсаны дагуу ХАБЭА-н сургалтыг зааварчилгаа өгөх хэлбэрээр зохион байгуулна.

2.2.2 Зааварчилгаа нь дараах төрлүүдтэй байна. Үүнд:

- Урьдчилсан зааварчилгаа
- Ажлын байрны анхан шатны зааварчилгаа
- Давтан /ээлжит, ээлжит бус/ зааварчилгаа
- Тухайлсан зааварчилгаа

2.3 Урьдчилсан зааварчилгаа:

2.3.1 Шинээр ажилд орсон ажилтан, сургалт дадлагын оюутан, суралцагчдад ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан 1 цагаас багагүй хугацаагаар ХАБЭА-н УТ-ны хавсралт-8 болон хавсралт-11-т тусгагдсан агуулгын хүрээнд танхимаар өгнө.

2.3.2 ХАБЭА-н УТ-ны зааврын хавсралт-12-н дагуу ажилтныг урьдчилсан зааварчилгаанд хамрагдсан талаар бичилт хийж өөрийн ажлын байранд хадгална.

2.4 Ажлын байрны анхан шатны зааварчилгаа

2.4.1 Ажилтны ажлын байр, албан тушаал, хэлтэс, нэгж өөрчлөгдөх, мөн урьдчилсан зааварчилгаа авсан шинэ ажилтан, сургалт дадлагын оюутан, суралцагчдад тухайн хэлтэс, нэгжийн менежер буюу ахлах мэргэжилтэн, шууд удирдлага нь ХАБЭА-н УТ-ны хавсралт-13-т тусгагдсан хөтөлбөрийн дагуу сургалтын материал боловсруулж өгнө.

2.4.2 Ажлын байран дахь анхан шатны зааварчилгааг өгсөн албан тушаалтан нь ХАБЭА-н УТ-ны хавсралт-14 маягтын дагуу бөглөж ажлын байран дээрээ хадгална.

2.5 Давтан зааварчилгаа

2.5.1 Ажилтанд өмнө олгосон мэдлэгийг батлатгах, баяжуулах зорилгоор ажлын байрны анхан шатны зааварчилгааны агуулгаар тухайн хэлтэс, нэгжийн менежер буюу ахлах мэргэжилтэн, шууд удирдлага өгнө.

2.5.2 ХАБЭА-н дүрэм, зааврыг ноцтой зөрчсөн буюу Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсны дараа, мөн нэг сараас илүү хугацаагаар ажлаас хөндийрч яваад эргэж ажилдаа орсон ажилтанд давтан зааварчилгааг өгнө.

2.5.3 Давтан зааварчилгаа өгөх хугацааг хэлтэс, нэгжийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч ээлжит сургалтын төлөвлөгөөнд тусгасан байна.

2.5.4 Ээлжит бус зааварчилгааг дараах тохиолдолд нэгжийн удирдлага, ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан тус тус өгнө. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх норматив, баримт бичиг өөрчлөгдсөн буюу шинээр нэвтэрсэн;
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд нөлөөлхүйц технологийн процесс өөрчлөгдсөн, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд ашиглагдах болсон;
- Ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагыг ноцтойгоор зөрчсөн;
- Осол болон аюултай тохиолдол гарсан;
- Ажилтан 30-аас илүү хоног үндсэн ажлаас хөндийрсөн;
- Эрх бүхий байгууллагаас шаардсан;

2.5.5 Ээлжит бус зааварчилгааг ганцаарчилсан буюу нэг ижил төрлийн ажлын байранд ажил гүйцэтгэдэг хэсэг бүлэг ажилтанд өгөх бөгөөд зааварчилгааны агуулга, хугацаа нь тухайн нөхцөл байдлаас хамаарна.

2.6 Тухайлсан зааварчилгаа

2.6.1 Тухайлсан зааварчилгааг ажлын даалгавар өгөгч буюу зөвшөөрөл олгогч нь ажлыг удирдан гүйцэтгэгчид, ажлыг удирдан гүйцэтгэгч нь бригадын гишүүдэд тус тус өгнө.

2.6.2 Ажилтанд гүйцэтгэх гэж буй ажлын онцлог, нөхцөлтэй нь уялдуулан тухайлсан зааварчилааг дараах тохиолдолд заавал өгнө. Үүнд:

- Ажилтнаар байнгын эрхэлдэг ажлаас нь өөр, мэргэжлийн мэдлэг, туршлага шаардагдахгүй нэг удаагийн ажил гүйцэтгүүлэх (ачих, буулгах, цэвэрлэх болон компанийн бүсээс гадагш нэг удаагийн ажил г.м);
- Осол, гамшигт үзэгдлийн үр дагаварыг арилгах;
- Наряд, шийдвэрээр ажил гүйцэтгэх;
- Компанийн үйл ажиллагаатай танилцах аялал зохион байгуулах, гэх мэт....

ГУРАВ. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗААВАРЧИЛГАА

3.1 Ажлын байранд галын аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

3.1.1 Шуурхай удирдлага хяналтын төвийн **7128-7300** утсанд яаралтай мэдэгдэх,

3.1.2 Аюулгүй ажиллагаа аюулгүй байдлын газрын Аврах гал унтраах хэлтэст **7128-7311** дугаар утсанд нэн даруй мэдэгдэх, цугларах цэгт очиж бүртгэлд хамрагдах,

3.1.3 Галын аюулыг зөв үнэлж, өөрийн сурч мэдсэн дадлага туршлагын хүрээнд галтай тэмцэх оролдлого хийж чадна гэж үзсэн тохиолдолд галтай тэмцэх оролдлого хийх,

3.1.4 Өөрийн сурч мэдсэн дадлага туршлагын хүрээнд осолдогчийн биеийн байдлыг доройтуулалгүйгээр эмнэлэгийн анхны тусламж үзүүлэх,

3.2 Гал түймрийн үед ажлын байрнаас дүрвэн гарах маршрут, нөөц хаалга, гарцыг мэддэг байх,

3.3 Цахилгаанаас үүдэлтэй гал гарсан тохиолдолд өөрийгөө болон бусдыг аюул эрсдэлд учруулалгүйгээр хүчдэлийг эх үүсвэрээс яаралтай салгах арга хэмжээ авах,

3.4 Өрөө тасалгаанд гал гарвал галын хорыг ашиглаж унтраахаас гадна галын дохиоллын системийг ажиллуулах арга хэмжээ авах,

3.5 Тамхийг зориулалтын цэгт татах, тамхины галыг бүрэн унтрааж байх

3.6 Хэрэв хувцсанд тань гал авалцвал сандарч гүйж болохгүй, ЗОГС-ХЭВТ-ӨНХӨР гэсэн дүрмийг барих.

ДӨРӨВ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

4.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, стандарт, технологийн горим, зааварчилгааг чанд мөрдөх,

4.2 Ажлын бус цагаар сайтар амарч, согтууруулах ундаа болон мансууруулах төрлийн бодис хэрэглэхгүй байх,

4.3 Ажилтан ажил, үүрэгтэйгээ хамааралтай аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байх,

4.4 Автомашин, тоног төхөөрөмжүүдийг ажиллуулахын өмнө техникийн бүрэн бүтэн байдлын үзлэгийг 15 минутаас багагүй хугацаагаар заавал хийх, шалгуулах,

4.5 Техникийн аюулгүй байдлын болон ашиглалтын стандартын шаардлага хангасан автомашин, механизмаар ажил, үүрэг гүйцэтгэх,

4.6 Техник тоног төхөөрөмж, машин механизмыг зөв, аюулгүй ажиллуулах холбогдох заавар, журмын мөрдөж ажиллах

4.7 Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн хэрэглэх,

4.8 Өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх, амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөлд аюулгүй байдлын дүрэм, журмын дагуу шуурхай арга хэмжээ авах,

4.9 Эрүүл мэндийн байдал тавгүйрхсэн, алжааж ядарсан үед ажил үүргийг зогсоож, шууд удирдах ажилтанд мэдэгдэх,

4.10 Ажил, үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, болзошгүй аюул, ослын үед анхны тусламж үзүүлэх мэдлэгтэй байх,

4.11 Аюул, осол, осолд дөхсөн тохиолдлын тухай мэдээллийг холбогдох албан тушаалтанд шуурхай мэдээлэх,

4.12 Ажлын байр, багаж хэрэгслийг эмх цэгцтэй байлгаж, ажлаа илүү аюулгүй гүйцэтгэх арга барилаар ажиллахыг эрмэлзэх,

4.13 Ажлын байранд ноцолдох, хөөцөлдөх гүйх, огцом чангаар гэнэтийн авиа гаргах, цочоох, тоног төхөөрөмж ажиллуулж байгаа үедээ элдэв зүйл ярих зэргээр хөдөлмөрийн сахилга батыг зөрчихгүй байх,

4.14 Машин техник, тоног төхөөрөмж ажиллуулахдаа үнэт эдлэл /бөгж, бугуйвч, зүүлт г.м/ хэрэглэхгүй байх,

4.15 Хөдөлмөрлөж байх үед галын аюул, байгалийн гамшиг тохиолдох зэргээр онцгой байдал үүссэн нөхцөлд ажиллах үүргээ мэддэг байх,

4.16 Хийж гүйцэтгэх ажлаа аюулгүй ажиллагааны дохио, санамж, тэмдэг, тэмдэглэгээний заалтын дагуу аюулгүй гүйцэтгэх арга барил эзэмшсэн байх,

ХООСОН ҮЛДЭЭВ

ЭРСДЭЛ ӨНДӨРТЭЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕД МӨРДӨХ ЖУРАМ

B1-2021-05

Төв аймаг

2021 он

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХУУДАС

Энэхүү хуудас нь "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК-ийн Эрсдэл өндөртэй ажил гүйцэтгэх үед мөрдөх журам"-ын хамт хүчин төгөлдөр байна.

Байгууллага: "НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ" ХХК

ЭРСДЭЛ ӨНДӨРТЭЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕД МӨРДӨХ ЖУРАМ

Боловсруулсан	Хянасан	Батлсан
Албан тушаал: "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн Аюулгүй ажиллагааны хэлтсийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн	Албан тушаал: "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн Аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга	Албан тушаал: "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн гүйцэтгэх захирал
Нэр: С.Билгүүн	Нэр: Н.Батэориг	Нэр: Като Такэо
Гарын үсэг:	Гарын үсэг:	Гарын үсэг:
Огноо: 2021.11.22	Огноо: 2022.01.11	Огноо: 2021.1.11

БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ
Document control

Баримт бичгийн дэлгэрэнгүй Document Details					
1	Баримт бичгийн нэр Document Name		Эрсдэл өндөртэй ажил гүйцэтгэх үед мөрдөх журам		
2	Баримт бичгийн зорилго Purpose of the Document		"НУБИЭ" ХХК-ийн ажилчид өндөр эрсдэл бүхий анхаарал шаардсан ажил үүрэг гүйцэтгэх үед түүнээс үүдэн гарах аюул эрсдэл, хор уршгийг багасгах, ажилчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэхэд холбогдох албан тушаалтнууд нь нэг эх үүсвэрийг ашиглахад оршино.		
3	Баримт бичгийн код Unit Identification		**B1-2021-05**		
4	Хуудасны тоо /Total page/		14		
5	Хэлбэр Document type		A4		
6	Хариуцах албан тушаалтан Document Owner		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн		
7	Батлагдсан огноо Date approved		2022		
8	Баталсан байгууллага, албан тушаалтан Approved by		"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн гүйцэтгэх захирал		
9	Өөрчлөлт, нэмэлт орсон байдал /Amendments/		-		
10	Баримт бичгийн бүтэц Document structure		4 бүлэг		
11	Хавсралт		.....		
12	Тараагдсан байдал Distribution	Хэлтэс, алба Division name	Дугаар Number	Хувь Version	Гарын үсэг Signature
		Гүйцэтгэх захирал			
		ААХ			
		ЗУГ			
		АААБГ			
		АГУХ			
		ШУХТ			
		ИТГ			
		ГҮГ			
		ЗТГ			
		ТЗГ			
		Нийт Total			

“Эрсдэл өндөртэй ажил гүйцэтгэх үед мөрдөх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах ажилтан доорх хүсэлтийг заавал бөглөсөн байна.

НЭМЭЛТ БОЛОН ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Procedures for amendments record

НЭМЭЛТҮҮД					
Д/д	Нэмэлт өөрчлөлт оруулсан огноо	Нэмэлт өөрчлөлтийн зүйл, заалтын дугаар	Тэмдэглэгээ /-/,/+/	Нэмэлт өөрчлөлт оруулсан ажилтны нэр/гарын үсэг	Хянасан албан тушаалтны нэр/гарын үсэг
1					
2					
3					

АГУУЛГА

БҮЛЭГ	ГАРЧИГ	ХУУДАС
	Баталгаажуулалтын хуудас	1
	Баримт бичгийн хяналтын мэдээлэл	2
	Нэмэлт болон өөрчлөлтийн бүртгэл	3
	Журмын агуулга	4
НЭГ	ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	5
1.1	Зорилго	5
1.2	Хамрах хүрээ	5
1.3	Эрх зүйн үндэслэл	5
1.4	Товчилсон үгийн тайлбар	5
ХОЁР	НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	5
ГУРАВ	ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	6
3.1	Ил гал гаргах үйл ажиллагаа гүйцэтгэх үед мөрдөх аюулгүй ажиллагаа	6
3.2	Хязгаарлагдмал орчинд ажиллах үеийн аюулгүй ажиллагаа	7
3.3	Өндөрт ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагаа	8
3.4	Газар хөндөх, ухах ажил хийж гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагаа	9
ДӨРӨВ	ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	10
4.1	Ажлын аюулын дүн шинжилгээ хийх	10
4.2	Ажил гүйцэтгэх зөвшөөрөл хүсэх	11
4.3	Яаралтай үед мэдээлэл дамжуулах	11
Хавсралт-1	Ажил гүйцэтгэх зөвшөөрлийн хуудас	12
Хавсралт-2	Ажлын аюулын дүн шинжилгээ	13

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Зорилго

НУБИЭ ХХК-ийн хамгаалалтын бүсэд аюул эрсдэл, болзошгүй үр дагавар, сөрөг нөлөөлөл бүхий ажил үүрэг гүйцэтгэх үед ажилтны аюулгүй байдлыг хангах, шаардлагатай хамгаалах хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах, хяналтын тогтолцоог бий болгох, зохион байгуулалтын дэг журмыг тогтооход оршино.

1.2 Хамрах хүрээ

Энэхүү журам нь "Хязгаарлагдмал орчинд ажиллах, Өндрийн ажил үүрэг гүйцэтгэх, Ил гал гаргах, Газар ухах /хөндөх/" зэрэг ажил үйлчилгээг гүйцэтгэх гэж буй бүхий л хэлтэс нэгж, гадны компанийн үйл ажиллагаанд хамаарна.

1.3 Эрх зүйн үндэслэл

"Эрсдэл өндөртэй ажил гүйцэтгэх үед мөрдөх журам" нь дараах хууль эрх зүйн баримт бичиг, стандарт шаардлагад үндэслэн боловсруулагдсан болно. Үүнд:

- Нисэх буудлын ерөнхий заавар хэсэг 2, 3 /Үйл ажиллагааны стандарт журмууд/, /онцгой нөхцлийн төлөвлөгөө/;
- ХАБЭА-н УТ MNS ISO 45001:2018 стандартын шаардлага;
- НУБИЭ ХХК-ийн ХАБЭА-н УТ-ны зааврын шаардлага;

1.4 Товчилсон үгийн тайлбар

ААДШ	Ажлын аюулын дүн шинжилгээ
ШУХТ	Шуурхай удирдлага хяналтын төв
ОБГ	Онцгой байдлын газар

ХОЁР. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Ажлын аюулын дүн шинжилгээ	Ажилд шаардагдах багаж техник тоног төхөөрөмж, шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл, үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг богино хугацаанд тодорхойлж хэрэгжүүлэх үйл явц,
Өндрийн ажил	Газрын гадаргуу, шалнаас болон хаалт хашилтгүй өндөрлөг хэсгийн ирмэгээс 2 м-ээс бага зайд ажил гүйцэтгэж байгаа хүний хөлний ул хүртэл 1,5 метрээс дээш өндөрт ажиллахыг;

Хязгаарлагдмал орчин	Хүн байнга ажиллахад зориулагдаагүй хагас эсвэл бүтэн хаалттай орчныг хэлэх бөгөөд Хязгаарлагдмал орчинд, шингэн болон хуурай материал хадгалах нөөцлүүр сав, худаг (траншей), тогоо, хоолой, утаа, агаар дамжуулах яндан хоолой, бункер, хүн ажиллахад зориулагдаагүй бусад бүх төрлийн орчин хамаарна.
Ил гал гаргах ажил	Шар /өнжмөл/ өвс, мод бут, хог хаягдлыг ил задгай шатаах, үйл явц,
Газар ухах,/хөндөх/ ажил	Инженерийн шугам сүлжээ шинээр татах, засварлах, солих зорилгоор техник тоног төхөөрөмж ашиглаж суваг шуудуй ухах, газар шорооны ажил хийх үйл явц, */дулаан, сан, цэвэр бохир ус, цахилгааны утас, кабел татах зэрэг үйл ажиллагаа багтана./*
Шуурхай ажиллагаа	Нэн яаралтай хойшлуулашгүй ажил /дулаан, сан, цэвэр, бохир ус, цахилгааны гэнэтийн доголдол/. Дулаан, эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн үйл ажиллагааг стандартын шаардлага, техникийн найдвартай ажиллагаанд нийцүүлэн хоногийн 24 цагийн турш шуурхай зохицуулж удирдлагаар хангаж ажиллахыг;
Бригад	Хариуцлагатай ажил гүйцэтгэгчийг оролцуулаад хоёр ба түүнээс дээш хүнтэй багийг
Аюулгүй ажиллагааны наряд	Цахилгаан байгууламжид ажил гүйцэтгэх үед ажлын агуулга, байр, эхлэх дуусах хугацаа, аюулгүй нөхцөлийг хангах арга хэмжээ, бригадын бүрэлдэхүүн, ажлын аюулгүй байдлыг хариуцагч нарыг тодорхойлж тусгай зориулалтын маягт дээр бичсэн ажлын даалгаврыг;

ГУРАВ. ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Ил гал гаргах үед мөрдөх аюулгүй ажиллагаа

3.1.1 Нисэх буудлын хамгаалалтын бүсэд ил гал гаргах /шар өвс шатаах/ ажил гүйцэтгэх ажилчид галын аюулгүй байдлын сургалтанд хамрагдсан, хийгдэх ажил үүрэгтэй холбоотой зааварчилгаанд хамрагдсан, ажил гүйцэтгэх явцад учирч болох аюул эрсдэлийн талаар мэдлэгтэй, түүнээс сэргийлэх арга хэмжээ авч ажиллах чадвартай ажилтан байна.

3.1.2 Нисэх буудлын хамгаалалтын бүсэд ил гал гаргах тохиолдолд дараахыг мөрдөж ажиллана. Үүнд:

- Уг ажлыг удирдан хяналт тавьж ажиллах албан тушаалтан нь тухайн ажлыг хийж гүйцэтгэх гэж буй ажилчдын хамтаар ААДШ хийсэн байна.
- Хавар, намрын улиралд салхины хурд 5м/с ихгүй цаг агаарын тааламжтай үеийг тооцоолж ШУХТ-н нисэх буудлын ерөнхий менежерт 7128-7300 дугаарт урьдчилан мэдэгдэж галын аюулгүй байдлыг бүрэн

хангасны үндсэн дээр харъяа газрынхаа дэд дарга /менежер/-с хавсралт 1 буюу ажил гүйцэтгэх зөвшөөрөл авч хамгаалалтын хашаа, суваг шуудуунд хуримтлагдсан шар өвсийг хэсэгчлэн шатаах,

- Аймаг орон нутгийн ОБГ-с гаргасан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, тушаал шийдвэрийг биелүүлж ажиллана. Хэрэв зайлшгүй ажлын шаардлагаар ил задгай гал гаргах /өвс шатаах/ тохиолдолд харъяа орон нутгийн ОБГ-т мэдэгдэж зөвшөөрөл авсны үндсэн дээр уг ажлыг эхлүүлнэ.

3.1.3 Ажлын удирдагч нь нарядад заасан аюулгүй байдлыг хангах бүх арга хэмжээний биелэлт, тэдгээрийн бүрэн хангалттай болсон эсэх, ажлыг аюулгүй гүйцэтгэх зохион байгуулалт болон ажил гүйцэтгэгчид тухайлсан зааварчилгаа өгөх, ажил гүйцэтгэгчээс бригадын гишүүдэд тухайлсан зааварчилгаа өгсөн эсэхийг тус тус хариуцна.

3.2 Хязгаарлагдмал орчинд ажиллах үеийн аюулгүй ажиллагаа

3.2.1 Хязгаарлагдмал орчинд тухайн ажилтан нь эрүүл мэндийн хувьд харшлах зүйлгүй, хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэхэд шаардлагатай туршлага хуримтлуулж, зохих сургалт, зааварчилгаанд хамрагдсан ажил гүйцэтгэх явцад учирч болох аюул эрсдэлийн талаар мэдлэгтэй, түүнээс сэргийлэх арга хэмжээ авч ажиллах чадвартай ажилтан байна.

3.2.2 Хязгаарлагдмал орчинд ажил үүрэг гүйцэтгэх тохиолдолд дараахыг мөрдөж ажиллана. Үүнд:

- Уг ажлыг удирдан хяналт тавьж ажиллах албан тушаалтан нь тухайн ажлыг хийж гүйцэтгэх гэж буй ажилчдын хамтаар ААДШ хийсэн байна.
- Ажил гүйцэтгэх зөвшөөрлийг тухайн ажлыг удирдан явуулах албан тушаалтан нь харъяа хэлтсийнхээ дэд дарга, түүнтэй адилтгах албан тушаалтан менежерт хавсралт 1-н асуулгын дагуу бөглөж ажил гүйцэтгэх зөвшөөрлийн хүсэлт гаргаж зөвшөөрөл авсан байна.
- Хязгаарлагдмал орчинд ажиллах бригад нь 3-с доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ажиллана. /нэг хүн дотор нөгөө хүн гадна амсар, хаалган дээр байрлах ба байнга дотор байгаа хүнтэйгээ харилцаа холбоотой байна. 3 дахь хүн байнга нөгөө 2 ажилтанг хянаж, шаардлагатай багаж хэрэгслийг ойртуулж өгөх, бусад аюул эрсдэл үүсэхээс сэргийлж аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- Хязгаарлагдмал орчинд ажиллах ажилтныг ажиллах орчин, нөхцөл байдлаас нь хамаарч 5 минутаас илүүгүй хугацаанд солигдож байхаар зохицуулалт хийж ажиллана.

3.2.3 Ажлын удирдагч нь нарядад заасан аюулгүй байдлыг хангах бүх арга хэмжээний биелэлт, тэдгээрийн бүрэн хангалттай болсон эсэх, ажлыг аюулгүй гүйцэтгэх зохион байгуулалт болон ажил гүйцэтгэгчид тухайлсан зааварчилгаа өгөх, ажил гүйцэтгэгчээс бригадын гишүүдэд тухайлсан зааварчилгаа өгсөн эсэхийг тус тус хариуцна.

3.3 Өндөр ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагаа

3.3.1 Өндрийн ажил гүйцэтгэх ажилтан нь эрүүл мэндийн хувьд харшлах зүйлгүй, өндрийн ажил гүйцэтгэх сургалт, зааварчилгаанд хамрагдсан, учирч болох аюул эрсдэлийн талаар ойлголттой ажилтан байна.

3.3.2 Өндрийн ажил гүйцэтгэх тохиолдолд дараахыг мөрдөж ажиллана. Үүнд:

- Өндрийн ажлыг удирдан хяналт тавьж ажиллах албан тушаалтан нь гүйцэтгэх бригад, ажилчдын хамтаар ажил гүйцэтгэхийн өмнө ААДШ хийсэн байна.
- Ажил гүйцэтгэх зөвшөөрлийг тухайн ажлыг удирдан явуулах албан тушаалтан нь харъяа хэлтсийнхээ дэд дарга, түүнтэй адилтгах албан тушаалтан менежерт хавсралт 1-н асуулгын дагуу бөглөж ажил гүйцэтгэх зөвшөөрлийн хүсэлт гаргаж зөвшөөрөл авсан байна.
- Газрын гадаргуу, шалнаас болон хаалт хашилтгүй өндөрлөг хэсгийн ирмэгээс 2 метрээс бага зайд ажил гүйцэтгэж байгаа хүний хөлний ул хүртэл 1,5 метрээс дээш өндөрт ажил үүрэг гүйцэтгэх ажилтан өндрийн хамгаалалтын бүс, татлага хэрэглэнэ.
- Шаардлага хангаагүй баталгаажуулалт хийгээгүй өндрийн бүс, татлаг, дэгээ хэрэглэхийг хориглоно.
- Өндрийн ажил үүрэг гүйцэтгэх үед ажлын байрны эмх цэгцийг хангаж ажиллана.
- Өндөрт ажиллах үед тухайн орчны аюулгүй бүсийг тогтоож хамгаалах тууз, конус, хаалт хашилт тавьсан байна.
- Өндөрт ажиллахдаа багаж хэрэгслийг хүний хөлд тээглэх, өшиглөгдөж доош унах газар бүү орхи.
- Ирмэгийн хажууд эд зүйл орхих, шидэхийг хориглоно.
- Хэрэв угсардаг шат, тавцан талбайд байрлуулж ажиллахаар бол бат бэх хөдөлгөөнгүй байрлуулах арга хэмжээ авч ажиллана.
- Өндөрт ажиллах ажилчид хөдөлмөр хамгааллын хувцас, каск зайлшгүй өмссөн байна.

3.3.3 Ажлын удирдагч нь нарядад заасан аюулгүй байдлыг хангах бүх арга хэмжээний биелэлт, тэдгээрийн бүрэн хангалттай болсон эсэх, ажлыг аюулгүй гүйцэтгэх зохион байгуулалт болон ажил гүйцэтгэгчид тухайлсан зааварчилгаа өгөх, ажил гүйцэтгэгчээс бригадын гишүүдэд тухайлсан зааварчилгаа өгсөн эсэхийг тус тус хариуцна.

3.4 Газар хөндөх, ухах ажил хийж гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагаа

3.4.1 Газар хөндөх, ухах үйл ажиллагаа хийх гэж буй газар хэлтэс, гадны байгууллагын ажилчид тухайн гүйцэтгэх ажилтай холбоотой зааварчилгаанд хамрагдсан, учирч болох аюул эрсдэлийн талаар ойлголттой ажилтан байна.

3.4.2 "НУБИЭ" ХХК-ийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, түүний ойр орчимд газар шорооны ажлыг машин механизм ашиглан засвар,

үгсралтын ажил гүйцэтгэх гэж байгаа тохиолдолд дараахыг анхаарч ажиллана. Үүнд:

- Инженерийн шугам сүлжээний /бохир, цэвэр, дулаан, цахилгаан/ ойролцоо газар шорооны ажил хийх тохиолдолд ажил гүйцэтгэгч нь "НУБИЭ" ХХК-ийн холбогдох газар хэлтсээс тодруулга хийлгэн хавсралт 1-н дагуу ажил гүйцэтгэх зөвшөөрөл авсан байна.
- Ажил эхлэхийн өмнө харъяа газар, хэлтсийн холбогдох албан тушаалтныг байлцуулан хяналтын малталт хийж үзнэ.
- Газар шорооны ажил гүйцэтгэгч /удирдах албан тушаалтан/ нь ажил гүйцэтгэх хугацааны туршид инженерийн шугам сүлжээнд механик гэмтэл учруулахаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.
- Ухсан нүх, шуудуунд хүн унаж бэртэхээс сэргийлэх санамж бичиг, анхааруулах тэмдэг, шөнийн цагаар гэрэл ойх цацруулагч бүхий наалт, хаалт хашилт хийсэн байна.
- Инженерийн шугам сүлжээ ил гарсан тохиолдолд механизм ашиглаж ухахыг хориглоно. Учир нь гэмтээх эрсдэлтэй.
- Цахилгааны кабел шугамыг өвлийн цагт хөрсийг нь гэсгээхдээ гаднаас нь халаахгүй байх шаардлагыг мөрдөнө.

3.4.3 Ажлын удирдагч нь нарядад заасан аюулгүй байдлыг хангах бүх арга хэмжээний биелэлт, тэдгээрийн бүрэн хангалттай болсон эсэх, ажлыг аюулгүй гүйцэтгэх зохион байгуулалт болон ажил гүйцэтгэгчид тухайлсан зааварчилгаа өгөх, ажил гүйцэтгэгчээс бригадын гишүүдэд тухайлсан зааварчилгаа өгсөн эсэхийг тус тус хариуцна.

ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1 Ажлын аюулын дүн шинжилгээ хийх

4.1.1 Ажил гүйцэтгэх зөвшөөрөл шаардсан ажлыг уг ажлыг хийж гүйцэтгэх ажлын хэсэг, бригад, бүрэлдэхүүн нь ААДШ-г хавсралт-2-г ашиглаж хийнэ.

4.1.2 ААДШ-г дараах тохиолдлуудад хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Газар ухах, /хөндөх/
- Ил гал гаргах,
- Хязгаарлагдмал орчинд ажиллах,
- Өндөрт ажиллах,
- Шинэ техник тоног төхөөрөмж дээр анх удаа ажиллах.
- Цөөн давтамжтай хийгддэг эрсдэл өндөртэй ажлууд,
- Тухайн ажлын талаар боловсруулагдсан заавар нь аюул эрсдэлүүдийг бүрэн тодорхойлоогүй гэж үзвэл

ТАЙЛБАР: *Ажлын аюулын дүн шинжилгээ нь эрсдэлийн үнэлгээ хийхээс ялгагдах онцлог нь эрсдэлийн үнэлгээний матриц ашиглахгүй явдал юм.*

4.2 Ажил гүйцэтгэх зөвшөөрөл хүсэх

4.2.1 Цаг хугацаанд баригдаагүй, төлөвлөх боломжтой, гэхдээ учирч болох аюул эрсдэл, болзошгүй сөрөг үр дагавар их дараах ажлыг гүйцэтгэх тохиолдолд ААДШ-г хийж зөвшөөрөл авсан байна. Үүнд:

- Хязгаарлагдмал орчинд ажиллах,
- Өндрийн ажил гүйцэтгэх,
- Ил гал гаргах,
- Газар хөндөх, ухах,

4.2.2 Ажил гүйцэтгэх зөвшөөрөл олгогч албан тушаалтан нь хавсралт 1-н дагуу уг ажилтай холбоотой асуулгуудыг нэг бүрчлэн шалгаж тэмдэглэгдэсний үндсэн дээр зөвшөөрөл олгоно.

4.2.3 "НУБИЭ" ХХК-н эзэмшлийн бүсэд гадны байгууллагаар гэрээгээр ажил ажил гүйцэтгүүлэх болон шинээр инженерингийн шугам сүлжээ /дулаан, цэвэр, бохир усны хоолой, хаалт, худаг траншей, цахилгааны кабел шугам, трансформатор, интернет холболт / татах, холбох, солих, засварлах үйл ажиллагаанд "НУБИЭ" ХХК-ийн холбогдох газар, хэлтсийн удирдах албан тушаалтан /менежер, ахлах/ нь энэхүү журмын хавсралт 1-н асуумжийн дагуу бөглүүлж ажил гүйцэтгэх зөвшөөрөл олгоно.

ЖИЧ: *Хэрэв тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай хяналтын арга хэмжээ авагдаагүй байна гэж үзсэн тохиолдолд зөвшөөрөл олгохгүй.*

4.2.4 Шуурхай ажиллагаа буюу нэн яаралтай хойшлуулшгүй ажил үүрэг гүйцэтгэх тохиолдолд ажил гүйцэтгэх зөвшөөрлийн хүсэлтгүйгээр нарядаар уг ажлыг гүйцэтгэнэ.

4.3 Яаралтай үед мэдээлэл дамжуулах

4.3.1 Үйл ажиллагааны явцад гарсан аливаа осол, гал түймрийн аюул, ажилтан бэртэж гэмтсэн, ноцтой аюул эрсдэл үүссэн тохиолдолд ШУХТ-н 7128-7300 дугаарт үүссэн нөхцөл байдлын талаар яаралтай мэдэгдэнэ.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

1. Газар хэлтсийн нэр:.....
2. Байршил:.....
3. Хийгдэх ажил.....
4. Ямар чиглэлээр. */доогуур дурах/*
   1. Өндрийн ажил. 2.Хязгаарлагдмал орчин. 3.Ил гал гаргах. 4. Газар ухах
5. Зөвшөөрөл хүсэгч ажилтны албан тушаал, овог нэр:.....
   .....
6. Хянагч ажилтны нэр:.....албан тушаал:.....утас:.....
7. Гүйцэтгэх огноо:.....он .....сар.....өдөр.....

Ажил гүйцэтгэх ажилчид		
№	**Албан тушаал:**	**Овог нэр:**
1		
2		
3		
4		
5		

ШААРДЛАГАТАЙ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ			
	Тийм	**Үгүй**	**Тэмдэглэл**
Хөдөлмөр хамгааллын хувцас			
Каск			
Нүдний шил			
Ажлын гутал			
Амьсгал хамгаалах хэрэгсэл			
Нүүрний баг			
Ажлын бээлий			
Өндрийн бүс			
Амь олс, татлага, дэгээ			
Галын хор			
Радио станц			
Анхааруулах тэмдэг, конус, хаалт			
Бусад хамгаалалтын арга хэмжээ			
Тухайн хэсгийн газар дээрхи болон газар доорхи инженерийн шугам сүлжээний схем зурагтай танилцсан эсэх, /газар ухах үйл ажиллагаанд хамаарна./			
Тухайн ажилд холбогдох үйл ажиллагааны зөвшөөрөл ажилчдад танилцуулсан эсэх,			
Аюул ослын үед яаралтай мэдэгдэх газар, хэлтсийн холбогдох албан тушаалтны утасны дугаар мэдэж байгаа эсэх,			
Ажлын аюулын дүн шинжилгээ хийсэн эсэх,			
Тодруулга хийсэн эсэх */инженерингийн шугам сүлжээний зураг, схем/* **Газар ухах үйл ажиллагаанд хамаарна.**			

Зөвшөөрөл олгосон хүний нэр, албан тушаал:.....
.....
Зөвшөөрөл олгосон огноо:. .....он.....сар.....өдөр

ХАВСРАЛТ-2

АЖЛЫН АЮУЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хийгдэх ажил:			**Хаана:**		**Огноо:**
№	**Ажил гүйцэтгэх алхмууд**	**Аюул**	**Үр дагавар /Хор хөнөөл**	**Хяналтын арга хэмжээ**	**Хариуцагч**
	(Юу хийх гэж байгааг бичих)	(Надад/ бусдад мөн тоног төхөөрөмжинд хохирол учруулж болзошгүй ямар аюул байгааг бичих)	(Ямар хор хохирлууд учирч болох талаар бичих)	(Гарч болох хор хохирол, үр дагавраас ямар арга замаар сэргийлж болох талаар бичих)	(Хяналтын арга хэмжээг хариуцах хүний нэрийг бичих)
1					
2					
3					
4					
5					
6					

Ажлын аюулын дүн шинжилгээг хийсэн багийн бүрэлдэхүүн

№	Нэр	Албан тушаал	Гарын үсэг
1			
2			
3			
4			
5			
6			

ААДШ-Г ХЯНАСАН АЖЛЫН УДИРДАГЧ:...../ **/ ОГНОО:**

Ажил үүргийн өөрчлөлтийн тухай тэмдэглэл: *(Цаг агаарын нөхцөл байдал, ажлын цар хүрээ төлөвлөснөөс өөр болох гэх мэт...)*

Сунгалт хийсэн тухай тайлбар: *(Тус ААДШ – ний дагуу тухайн ажил үүргийг ажлын өдөр буюу нэг ээлжинд хийж дуусаагүй бол энэ ААДШ-г нэг удаа сунгаж дараагийн ээлжинд ашиглаж болно. Гэхдээ дараагийн багийн гишүүд үүнийг маш сайн уншиж ойлгосны үндсэн дээр доор гарын үсгээ зурснаар ажлаа эхлүүлнэ.Ажил үүрэг нь тодорхой хэмжээнд өөрчлөгдөх бол ААДШ- г дахин хийнэ гэдгийг санах.)*

№	Нэр	Албан тушаал	Огноо	Цаг, минут	Гарын үсэг
1					
2					
3					
4					
5					
6					

ХООСОН ҮЛДЭЭВ

БАТЛАВ:
НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

КИТАНАКА ТАКЭФУМИ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ДОТООД ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

2022.10.10

1. *Үзлэг шалгалтын зарчим:*

1.1 Дотоод хяналт шалгалт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.

2. *Үзлэг шалгалтын зорилго:*

2.1. "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын "Дотоод хяналтын 2022 оны ерөнхий төлөвлөгөө", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны зааврын хэрэгжилтийг хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтыг хэвшүүлэх, холбогдох заавар, журмын нийцтэй байдалд үнэлгээ өгөх,
2.2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Төв аймгийн мэргэжлийн хяналтын газар, ХАБЭА-н үндэсний хороо, ЗТХЯ-ны ХАБЭА-н салбар хороо, Иргэний нисэхий ерөнхий газрын ХАБЭА-н зөвлөл, Иргэний нисэхийн үндэсний төвийн ХАБЭА-н зөвлөл, НУБИЭ ХХК-ийн Аюулгүй ажиллагааны хэлтсээс гүйцэтгэсэн үзлэг шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, өгөгдсөн зөвлөмж, шаардлагын хэрэгжилтийг нягтлах,
2.3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх,
2.4. Компанийн явуулж буй нислэг үйлдвэрлэл, үйлчилгээ нь ХАБЭА-н хууль тогтоомжид заасан стандарт, шаардлагад хэрхэн нийцэж байгаа, учирч болох аюул эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлж, залруулж байгаа байдалд үнэлгээ хийх, залруулахад хүч нэмэгдүүлэх замаар компанийн удирдлагуудыг бодит мэдээллээр хангах, ХАБЭА-н удирдлагын тогтолцоог сайжруулахад уг үзлэг шалгалтын зорилго оршино.

3. *Хууль эрхзүйн үндэслэл:*

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйл, 32.1.6, 35.1,

- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол /дотоод хяналт шалгалт зохион байгуулах нийтлэг журам/,
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 253 дугаар тушаал "Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай"-ын 1.7 дахь заалт,
- "Нисэх буудлын өрөнхий заавар"-ын 4-р бүлгийн 4.1.5.2,
- Гүйцэтгэх захирлын 2022.05.31-ний А/10 дугаар тушаалын хавсралт "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК-ийн үйл ажиллагааны чиг үүрэг"-ийн 2.2 дахь заалт,
- Хөдөлмөрийн дотоод журмын 3.2.6 дахь заалт,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны зааврын 7.1 дэх заалт.

4. *Хяналт шалгалт явуулах чиглэл:*

Мэргэжлийн хяналтын газрын "ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ ХУУДАС", "ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС"-н асуултуудын хүрээнд,

5. *Төлөв:*

☒ төлөвлөгөөт ☐ төлөвлөгөөт бус

6. *Хяналт шалгалтад хамрагдах нэгж, үргэлжлэх хугацаа:*

Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 11 дүгээр сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулан 11 дүгээр сарын 21-ний дотор хяналт шалгалтын дүн, мэдээ тайланг гүйцэтгэх захиралд танилцуулна. Газар, нэгжийн хяналт шалгалтанд хамрагдах огноог доорх хүснэгтэд харуулав.

№	Газар, хэлтэс	Хэлтэс, хэсгийн нэр	Хамрагдах огноо
1	Захиргаа, санхүү удирдлагын газар	Захиргааны хэлтэс	X/17
		Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтэс	X/18
2	Газрын үйлчилгээний газар	Талбайн үйлчилгээний хэлтэс	XI/09
		Засварын хэсэг	XI/10
		Карго үйлчилгээний хэлтэс	XI/11
3	ШУХТ		X/19-20
4	Зорчигч терминалын газар	Зорчигч үйлчилгээний хэлтэс	X/21
		Тусгай үйлчилгээний хэлтэс	X/24
		Авто зогсоол, тээврийн хэлтэс	X/25
		Түрээсийн үйлчилгээ, зар сурталчилгааны хэлтэс	X/26

5	Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын газар	Аврах, гал унтраах хэлтэс	X/27
		Үйл ажиллагаа төлөвлөлтийн хэлтэс	X/28
6	Инженер, техникийн газар	Инженер, техникийн төлөвлөлтийн хэлтэс	X/31
		Аэродромын хэлтэс	XI/1
		Барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн хэлтэс	XI/2
		Бохир ус цэвэрлэх байгууламж	XI/3
		Цэвэр ус цэвэрлэх байгууламж	XI/4
		Дулааны станц	XI/7
		Мэдээлэл технологийн хэлтэс	XI/8
		Халаалт, агаар сэлгэлт, сантехникийн хэлтэс	XI/14
		Тусгай тоног төхөөрөмжийн хэсэг	XI/15
		Цахилгааны хэсэг	XI/16

Газар, хэлтсийн дарга, менежерүүд өөрийн нэгжийн холбогдох албан тушаалтанд ХАБЭА-н төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжыг урьдчилан танилцуулж, хариуцах албан тушаалтныг томилж холбогдох баримт, бичгийг бэлдүүлсэн байна.

7. Үзлэг шалгалтын бүрэлдэхүүн:

№	Нэрс	Албан тушаал
1	Н.Батзориг	Аюулгүй ажиллагааны менежер бөгөөд аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга
2	Н.Батчимэг	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ахлах мэргэжилтэн
3	С.Билгүүн	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн

8. Үзлэг шалгалтын дараа авах арга хэмжээ:

8.1. Гүйцэтгэх захирал нь үзлэг шалгалтын үр дүнг үндэслэн компанийн хэмжээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, бусад холбогдох эрх зүйн шаардлагын гүйцэтгэлийг хангахад дэмжлэг үзүүлнэ.

8.2. Аюулгүй ажиллагааны хэлтэс нь үзлэг шалгалтын тайланг гаргаж, илэрсэн зөрчил, дутагдлыг залруулахад мэргэжил аргазүйн зөвлөмж өгнө.

8.3. Үзлэг шалгалтад хамрагдсан газрын дарга нь үзлэг шалгалтад тусгасан зөвлөмжийн дагуу зөрчил, дутагдлыг залруулах ажлын төлөвлөгөө гарган, биелэлтийг хангаж үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлнэ.

ХЯНАСАН:
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА Н.БАТЗОРИГ

БОЛОВСРУУЛСАН:
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Н.БАТЧИМЭГ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН МЭРГЭЖИЛТЭН С.БИЛГҮҮН

БАТЛАВ
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ БӨГӨӨД АГААРЫН ХӨЛӨГ ШУВУУ, МАЛ АМЬТАНТАЙ МӨРГӨЛДӨХ АЮУЛААС СЭРГИЙЛЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Г.СУРМАА

АГААРЫГ ХӨЛГИЙГ ШУВУУ, МАЛ, АМЬТАНТАЙ МӨРГӨЛДӨХ АЮУЛААС СЭРГИЙЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2022.01.12

Зуунмод сум

ТУХАЙН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭГДСЭН НЭГЖИЙН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ(ТОО, ЧАНАР, ХУГАЦАА)-ИЙН ХҮРЭХ ТҮВШИН					
Д/д	Гүйцэтгэх ажил	Гүйцэтгэх хугацаа	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хариуцах эзэн
1	Төв аймгийн цэвэрлэх байгууламжаас гарсан саарал усыг тунгаах усан санд шувуу суулгахгүй байх арга хэмжээ авах талаар судлах, тесөв, ажлын тоо хэмжээг тодорхойлох	II улиралд	Төв аймгийн цэвэрлэхийн усан сан нь нисэх буудлын аэродромын аюулгүй бүсэд ордог ба тогоруу, хондон ангир, цахлай зэрэг агаарын хөлөгтэй мөргөлдөх аюултай усны шувууд цугладаг.	Төв аймгийн цэвэрлэхийн усан санд шувуу суулгахгүй байх тохиромжтой арга хэмжээг тодорхойлж, шаардлагатай хөрөнгийг 2023 оны төсөвт шийдвэрлэх	Төв аймгийн ЗДТГ
2	Аэродром орчмын аюулгүйн бүсэд олгогдсон газруудын мэдээллийг нэгтгэх	I улиралд	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/131 дугаар тушаалаар батлагдсан "Аэродромын төлөвлелт ба ашиглалт"-ын техникийн баримт бичгийн 7.3-т Аэродром орчмын аюулгүйн бүсийн газар ашиглалтын талаар зааж өгсөн.	Аэродром орчмын аюулгүйн бүсэд олгогдсон газруудын мэдээллийг нэгтгэснээр хориглосон үйл ажиллагаанд олгогдсон газрын нэгдсэн мэдээллийн сантай болно.	Төв аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
3	Ойртолтын бүсээр өнгөрч буй	II улиралд	Ойртолтын бүсээр өнгөрч буй	Автомашин зогсоохгүй	Төв аймгийн

	А0201 дугаартай Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто зам дагуу автомашин зогсоохгүй байх арга хэмжээ авах		А0201 дугаартай Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто зам дагуу ачаа тээврийн автомашинууд зогсон хог хаягдал хаяж, шувуу цуглуулан агаарын хөлөгтэй мөргөлдөх эрсдэл үүсгэж байна.	байснаар хог хаягдал үүсэхгүй шувуу цуглаагүй байна.	Цагдаагийн газрын дарга, Сэргэлэн сумын Засаг дарга
4	Нисэх буудлын орчимд үхсэн мал, амьтныг халдваргүйжүүлэлт хийж, зайлуулах	Тухай бүр	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.3.2, 7.3.3-д мал, амьтны сэг зэмийг халдваргүйжүүлэлт хийж, зөйлуулах талаар заасан байдаг ба мал, амьтны сэг зэмд тас, хон хэрээ, элээ зэрэг шувууд цуглан агаарын хөлөгтэй мөргөлдөх аюултай байдаг.	Нисэх буудал орчимд мал, амьтны сэг зэм үүссэн тухай бүр зөрчлийг арилган халдварт өвчин гарах, шувуу цуглахаас сэргийлсэн байна.	Төв аймгийн Цагдаагийн газрын дарга, Зуунмод сумын Засаг дарга, Сэргэлэн сумын Засаг дарга, Алтанбулаг сумын Засаг дарга
5	Нисэх буудал орчимд хориглосон үйл ажиллагаанд олгосон газар олголтыг цэгцлэх	I, II улиралд	Газрын тухай хуулийн 40-р зүйлд газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай заасан. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/131 дугаар тушаалаар батлагдсан "Аэродромын төлөвлөлт ба ашиглалт"-ын техникийн баримт бичгийн 7.5.3, 7.5.4-т Аэродром орчмын аюулгүйн бүсийн газар ашиглалтын талаар зааж өгсөн. Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНбД 30.01.04-ийн Заавал мөрдөх 7-р хавсралтад нисэх буудлын хяналтын цэгээс 15 км-ийн дотор хаягдал ялгаруулах болон мал нядалгааны газар байрлуулахыг хориглоно гэж заасан.	Аэродром орчимд хориглосон үйл ажиллагаанд хууль нийцүүлэн шаардлагатай арга хэмжээг авсан байна.	Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Зуунмод сумын Засаг дарга, Сэргэлэн сумын Засаг дарга, Алтанбулаг сумын Засаг дарга

6	Аэродром орчмын аюулгүйн бүсэд шинээр газар олгохоор төлөвлөх болон барилга байгууламж барих зөвшөөрөл олгох бол нисэх буудалтай зөвшилцөх	Жилдээ	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/131 дугаар тушаалаар батлагдсан "Аэродромын төлөвлөлт ба ашиглалт"-ын техникийн баримт бичгийн 7.5.3.2, 7.5.4.6-д заасан.	Тухай бүр нисэх буудалтай хамтарсан хурал зохион байгуулж зөвшилцөн тухайн асуудлыг шийдвэрлэсэн байна.	Зуунмод сумын Засаг дарга, Сэргэлэн сумын Засаг дарга, Алтанбулаг сумын Засаг дарга
7	Аэродром орчмын аюулгүйн бүсэд мал бэлчээх болон ойртолтын бүс, "А" бүсэд малтай айл буухыг хориглосон захирамж гаргах	1-р сард	Бөхөг гол дагуу болон нисэх буудал орчмоор малтай айлууд хавар, зун, намар нүүж ирэн бууж байгаа нь нисэх буудлын ойр орчим шувуу, зэрлэг амьтад цуглах болон мал амьтад тууш зам болон автозамд орж осол үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна.	Нисэх буудал орчмоор малтай айлууд буугаагүй, шувуу цуглах нөхцөл үүсгээгүй байна.	Сэргэлэн сумын Засаг дарга, Алтанбулаг сумын Засаг дарга
8	Сэргэлэн сумын төвлөрсөн хогийн цэгт шувуу суулгахгүй байх арга хэмжээ авах	Жилдээ	Төвлөрсөн хогийн цэгт тас, хон хэрээ, элээ зэрэг агаарын хөлөгтэй мөргөлдөх эрсдэлтэй шувууд олон тоогоор цуглардаг.	Сэргэлэн сумын төвлөрсөн хогийн цэгт малын сэг зэмийг зориулалтын нүхэнд хийж даран шувуу цуглах нөхцөл үүсгэхгүй байна.	Сэргэлэн сумын Засаг дарга
9	Зуунмод сумын төвлөрсөн хогийн цэгийн орчимд буй ил задгай хог хаягдлыг цэвэрлэн, газрын доройтлоос сэргийлэх	III улиралд	Зуунмод сумын төвлөрсөн хогийн цэгийн орчимд ил задгай зөвшөөрөлгүй хог хаях явдал гардаг.	Зуунмод сумын төвлөрсөн хогийн цэгийн орчимд буй ил задгай хог хаягдлыг цэвэрлэсэн байна.	Зуунмод сумын Засаг дарга
10	Нисэх буудлын орчимд үүссэн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж зайлуулах	Сар бүр Жилд 12-оос доошгүй удаа	Ил задгай хог хаягдал хаях тохиолдол байнга гардаг ба шувуудын анхаарлыг татаж цуглах нөхцөл үүсгэдэг.	Ил задгай хаясан хог хаягдлын эзэн холбогдогчийг тогтоож арга хэмжээ авахуулах, цэвэрлэж зайлуулан шувуу цуглах нөхцөл үүсгээгүй байна.	"Чингис хаан" ОУНБ, Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Зуунмод сумын Засаг дарга, Сэргэлэн сумын Засаг дарга, Алтанбулаг сумын Засаг дарга
11	Аэродром орчмын аюулгүйн бүсэд хог, малын сэг зэм, малын	II, III улиралд	Нисэх буудал орчимд үйл ажиллагаа явуулдаг иргэн,	Нисэх буудал орчимд үйл ажиллагаа	"Чингис хаан" ОУНБ

	гаралтай хог хаягдлыг ил задгай хаяхаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, аж ахуйн нэгжүүдэд шувууны аюулын талаар зураг хуудас тарааж мэдээлэл өгөх		ахуйн нэгжүүдийн шувууны аюулын тухай мэдээлэл дутмаг байдаг.	явуулдаг иргэн, ахуйн нэгж, байгууллагууд шувууны аюулын тухай ойлголттой болж хог хаягдлаа зориулалтын хогийн цэг хаядаг болж хэвших	
12	Аэродром орчмын аюулгүйн бүсэд буй цахилгаан дамжуулах шугамын тулгуурт шувуу үүрлэсэн даруйд үүрийг буулгах	II улиралд	Хэзрийн махчин шувууд хаврын улиралд цахилгаан дамжуулах шугамын тулгуур, үүрээ засаж үржин тоо толгой нь өсөнөөр агаарын хөлөгтэй мөргөлдөх эрсдэл нэмэгддэг.	Нисэх буудал орчимд буй цахилгаан дамжуулах шугамын тулгуурт шувуу үүрлээгүй байна.	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Зуунмод түгээх төвийн дарга

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
ТӨВ АЙМАГ ДАХЬ АГААРЫН ХӨЛӨГ ШУВУУ, МАЛ, АМЬТАНТАЙ МӨРГӨЛДӨХ АЮУЛААС СЭРГИЙЛЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
БӨГӨӨД "ЧИНГИС ХААН" ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ КАТО ТАКЭО

"ЧИНГИС ХААН" ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН ШУУРХАЙ УДИРДЛАГА,
ХЯНАЛТЫН ТӨВИЙН ШУВУУ, ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХЯНАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН Ү.ТӨВШИН

CHINGGIS KHAAN
INTERNATIONAL AIRPORT

ТӨВ АЙМАГ ДАХЬ АГААРЫН ХӨЛӨГ ШУВУУ, МАЛ, АМЬТАНТАЙ МӨРГӨЛДӨХ АЮУЛААС СЭРГИЙЛЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2022.04.22

Агуулга

1. Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөл байгуулах тухай Төв аймгийн Засаг даргын захирамж
2. 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
3. 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөны дагуу хийгдэж буй ажлуудаас


Салбар зөвлөл байгуулах хууль эрх зүйн шаардлага

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 48-р тушаалаар батлагдсан “Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр”-ийн 5.4-т “Зөвлөл нь аэродромын гэрчилгээ эзэмшигч нисэх буудал бүрт салбар зөвлөлтэй байна” гэж заасан байдаг.



Нислэгийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллахад аэродром орчмын аюулгүйн бүсэд шувуу, мал, амьтны аюулыг бууруулах менежментийг хэрэгжүүлэх нь чухал асуудлын нэг юм.

1. Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөлийг Төв аймгийн Засаг даргын 2021 оны А/579 тоот захирамжаар байгуулсан ба ажиллах журмыг хавсралтаар баталсан. Төв аймгийн Засаг даргын орлогч салбар зөвлөлийг даргалан, нисэх буудлын дарга Нарийн бичгийн даргаар ажиллаж байна.



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 21 өдөр Дугаар А/579 Хуулсан

Салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 дах, 29.1.6 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зам тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 48 дугаар тушаалаар батлагдсан "Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх чиглэлээр"-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөлийн ажлын бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн удирдагч:
-Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:
-Нисэх буудлын дарга
Гишүүн:
-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Зам тээвэр, газрын харилцааны салбарын ахлагч, төсөвлөлт хариуцсан мэргэжилтэн
-Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
-Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
-Аймгийн Цэргийн штабын дарга
-Аймгийн Онцгой байдлын газрын дарга
-Аймгийн Цагдаагийн газрын дарга
-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
-Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга
-Аймгийн Мал эмнэлгийн газрын дарга
-Аймгийн Цэцэглэн түгээх шуудан салбарын захирал
-Зүүнмод сумын Засаг дарга
-Сэргэлэн сумын Засаг дарга
-Алтанбулаг сумын Засаг дарга

2. Чиглэлийн хэрэгжүүлэх явцтай холбоотой шаардлагатай хүсэлт, санал зөвлөмжийг цаг тухайд нь ажлын хэсгийн даргад /Х.Сүрэнжав/-д гүйцэтгүүлэхийг даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.МӨНХБААТАР

4121011468

Салбар зөвлөлийн ажиллах журам

Аймгийн Засаг даргын 2021 оны
09 дүгээр сарын 21 -ны өдрийн
А/337 -р захирамжийн хавсралт

ТӨВ АЙМАГ ДАХЬ АГААРЫН ХӨЛӨГ ШУУВУУ, МАЛ, АМЬТАНТАЙ МӨРГӨЛДӨХ АЮУЛАА СЭРГИЙЛЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий үндэс

1.1. Энэхүү журмаар Төв аймаг дахь "Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөл" (цаашид "Зөвлөл" гэх)-ийн үйл ажиллагаг зохицуулна.

1.2. Зөвлөл нь агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулыг бууруулах талаар зөвлөмж, шийдвэр гаргах, аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хэрэгжилтэд үнэлэлт өгөх, энэ талын үйл ажиллагаатай холбоотой төрийн, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаг уялдуулан зохицуулах үүрэгтэй орон тооны бус ажлын хэсэг мөн.

1.3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа олон улсын иргэний нисэхийн Чикагогийн конвенц, Иргэний нисэхийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Аэродромын стандарт, Иргэний нисэхийн багц дүрэм болон холбогдох бусад хууль, дүрэм, стандартыг удирдлага болгоно.

1.4. Зөвлөлийн үйл ажиллаганы зардлыг Төв аймаг, нисэх буудлын жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

Хоёр. Зөвлөлийн зохион байгуулалт

2.1. Зөвлөлийн ажлыг удирдан хэлбэр нь хурал байх бөгөөд хуралд гарсан шийдвэр нь зөвлөмж зэрэг үүрэг даалгавар хэлбэртэй байна.

2.2. Зөвлөлийн хурлыг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд тухай бүрд хуралдуулна.

2.3. Зөвлөлийн хэлэлцэх асуудлыг зөвлөлийн даргын шийдвэрээр зарлан хуралдуулна.

2.4. Зөвлөлийн гишүүдийн гуравны хөрөөс багагүй нь оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.

2.5. Зөвлөлийн хурлыг зөвлөлийн дарга даргалах, хурлын дэгийг мөрдүүлнэ.

2.6. Зөвлөлийг хурлын материалыг ажлын гурваас доошгүй өдрийн өмнө гишүүдэд тараасан байна.

2.7. Хурлаар хэлэлцэх зарим асуудлаар салбарын мэргэжлээс бусдаа ажлын хэсэг байгуулж санал, дүгнэлтийг нь сонсож болно.

2.8. Зөвлөлийн хурлын шийдвэр нь олонхийн санаа үндэслэнэ. Санаа тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн санаатай шийдвэр гаргана.

2.9. Зөвлөл нь аливаа асуудлыг судлах, хэрэгжүүлэхтэй холбоотойгоор судалгааны болон техникийн ажлын хэсгүүд байгуулан ажиллуулж болох ба ажлын хэсгийг тухай бүр зөвлөлийн дарга томилно.

2.10. Шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг нь үйл ажиллагаандаа өөрөөрөө удирдлагаа буй холбогдох мэргэжилтнүүд, тодорхой мэргэжлийн экспертүүдийг татан оролцуулж болно.

Гурав. Зөвлөлийн үндсэн үүрэг

3.1. Зөвлөл нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргаанд төв байгууллагаас батлагдсан "Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр"-ийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаг зохицуулах үндсэн үүргийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1. Агаарын хөлийн шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюул, эрсдэл, сүйрэлээс урьдчилан сэргийлэхэд төрийн, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн анхаарлыг хандуулах, үйл ажиллагаг зохицуулах, тангэрийн харилцан хамтын ажиллагаг сайжруулах;

3.1.2. Агаарын хөлийн шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэхтэй холбоотой гарсан алхаг, завсар гаргах;

3.1.3. Шувуу, мал, амьтны аюулаас урьдчилан сэргийлэхэд ашиглагт технологи, тоног төхөөрөмж, арга хэлбэлүүдыг судалж нэвтрүүлэх;

3.1.4. Шувуу, мал, амьтнаас учруулах аюулаас сэргийлэх үйл ажиллагаанд хөтөлбөрийг судалгаанд үр дүн, дүгнэлтэд тохируулан нисэх буудалд хийх, хэрэгжилтийг хангах;

3.1.5. Шувуу, мал, амьтнаа учруулах аюулыг бууруулах, урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаат мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан олон нийтэд сурталчилах;

3.1.6. Шувуу, мал, амьтны аюулаас сэргийлэх, аюулгүй ажиллагаат хангахтай холбоотой уулзалт семинар, сургалтыг нисэх буудлын ажилтнууд, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад зохион байгуулах;

3.1.7. Нисэх буудлуудын аэродромын аюулгүйн бүсэд тохиолдох шувуу болон бусад амьтныг тандалт судалгаат гүйцэтгэх мэргэжлийн байгууллага, зөвлөхүүдтэй хамтран ажиллах, үүсч болох эрсдэлийг урьдчилан тооцож, арилгах арга хэмжээг авах;

3.1.8. Судалгаа шинжилгээний үр дүнд уялдуулж үйл ажиллагаг зохион байгуулах:

Дөрөв. Хэлмэдэх асуудал, зөвлөлийн эрх

4.1. Зөвлөл нь дор дурдсан асуудлыг хэлэлцэж гаргах зөвлөмж зэрэг үүрэг даалгавар өгнө. Үүнд:

4.1.1. Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх эрсдэлийн үнэлгээ;

4.1.2. Шувуу, мал, амьтны мөргөлдөөн аюулыг бууруулахаар хэрэгжүүлж байгаа алхаа төсөл, тайлан;

4.1.3. Судалгаа шинжилгээний үр дүн, түүнд тулгуурлан гүйцэтгэсэн ажлын тайлан;

4.1.4. Нисэх буудлын ерөнхий төлөвлөгөө болон нисэх буудлын аэродром орчмын аюулгүйн бүсийн газар ашиглалт нь тухайн аймаг, сумын төлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан эсэх талаарх санал;

4.1.5. Зөвлөлийн үйл ажиллаганы тайлан, үр дүн;

4.1.6. Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдсөн мэдээлэл, тайлан;

4.1.7. Холбогдох бусад асуудал;

Тав. Зөвлөлийн нарийн бичгийн дарга

5.1. Нарийн бичгийн даргад нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1.1. Зөвлөлийн хурлын болгоа ажлыг хангах хурлыг зохион байгуулах, холбогдох бичиг, мэдээллийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргаанд байгууллагад танилцуулах;

5.1.2. Зөвлөлийн үйл ажиллаганы жилийн төлөвлөгөө боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

5.1.3. Зөвлөлийн хуралдсан зөвлөмж, шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг Зөвлөлд танилцуулах;

5.1.4. Зөвлөлийн үйл ажиллаганы жилийн тайлан зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх;

---оОо---

НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ ХХК

2022 он 11 сар 04 Төв аймаг Сэргэлэн сум

ХӨӨРЧ БУУХ ЗУРВАСЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ БАГИЙН ГУРАВДУГААР ХУРЛЫН ШИЙДВЭР

"Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Хөөрч буух зурвасын аюулгүй ажиллагааны багийн 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж, ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Агаарын хөлгийн хөдөлгүүр асаах цэгийг явгалах зам "F" дээр, агаарын хөлгийн мөстөлтийн эсрэг үйлчилгээ хийх байршлыг явгалах зам "F" болон агаарын хөлгийн зогсоол 7, 8, 9 дээр хуваарилах зохицуулалтыг "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Шуурхай удирдлага, хяналтын төвийн дарга /М.Тегсбаяр/-д,
2. Агаарын хөлгийн хөдөлгүүр асаах цэг болон агаарын хөлгийн мөстөлтийн эсрэг үйлчилгээ хийх, байршлын тэмдэглэгээ хийхийг "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Инженер Техникийн Газрын Аэродромын хэлтсийн дарга /Б.Менхжаргал/-д,
3. Дээрх шийдвэртэй холбоотойгоор "Нисэх буудлын ерөнхий заавар"-т нэмэлт өөрчлөлт оруулах болон Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны байцаагчаар хянуулж, баталгаажуулахыг "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Аюулгүй ажиллагааны менежер бөгөөд Аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга /Н.Батзориг/-д
4. Хурлаар хэлэлцсэн бусад асуудлуудыг судалж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, гишүүдэд хүргүүлэхийг багийн нарийн бичгийн дарга, аюулгүй ажиллагааны ахлах мэргэжилтэн /Б.Туяацэцэг/-д

тус тус даалгав.

ХБЗ-ЫН ААБ-ИЙН ДАРГА,
НУБИЭ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ КИТАНАКА ТАКЭФУМИ

99

"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн
гүйцэтгэх захирлын 2022 оны 10 дугаар сарын 05
өдрийн А/141 дугаар тушаалын хавсралт

"НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ" ХХК

NEW ULAANBAATAR INTERNATIONAL AIRPORT LLC

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮРЭМ

FIRE SAFETY RULE

2022 он

100

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Зорилго

Энэхүү "Галын аюулгүй байдлын дүрэм"/цаашид Дүрэм гэх/-ийн зорилго нь Компанийн хэмжээнд учирч болзошгүй гал түймрийн аюулаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ажлыг зохион байгуулах, хариуцах албан тушаалтныг тодорхойлох, галын аюулгүй байдлын үндсэн шаардлагуудыг тогтооход оршино.

2. Галын аюулгүй байдлын эрх зүйн орчин

"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК нь үйл ажиллагаандаа Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж болон Компанийн хэмжээнд мөрдөхөөр баталсан дараах баримт бичгийг мөрдөнө.

- Галын аюулгүй байдлын дүрэм;
- Байгууламжуудын Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө; /Барилга байгууламж бүрийн онцлог, ажилтан, үйлчлүүлэгчийн тоо, ажиллах цагийн хуваарь, галаас хамгаалах, гал унтраах анхан шатны багаж, хэрэгслийн байдал, усан хангамж, зам гарц, эдийн засгийн үзүүлэлт гэх мэт судалгааг багтааж, гал унтраах бүрэлдэхүүн, галын бүлгэмд ашиглагдах баримт бичиг/
- Галын дуудлага, дохиолол ирсэн үед авах арга хэмжээний журам; /Нисэх буудлын барилга байгууламжуудаас галын дохиолол илэрсэн, дуудлага ирсэн үед ажиллах ШУХТ, АБХТ, АГУХ, ИТГ, Галын бүлгэмийн ажилтнуудын авах арга хэмжээг журамласан баримт бичиг/
- Нисэх буудлын Ерөнхий зааврын 3 дугаар бүлэг, Онцгой нөхцөлийн төлөвлөгөө, 3.7.3. /Нисэх буудлын барилга байгууламжид их хэмжээний гал түймэр гарч, дэлгэрсний улмаас онцгой нөхцөл үүссэнийг Нисэх буудлын эзэжийн менежер зарласан тохиолдол/

3. Нэр томьёоны тодорхойлолт, товчилсон үг

3.1. "Галын аюулгүй байдал" гэж учирч болзошгүй гал түймрийн аюулаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан байдлыг;

3.2. "Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж" гэж барилга байгууламж дахь гал түймрийг илрүүлэх, мэдээлэх, унтраах автомат тоног төхөөрөмж, утаа зайлуулах систем, гал унтраах усан хангамж, хүн нэг бүрийн болон нийтийн тусгай аврах хэрэгслийг;

3.3. "Гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгсэл" гэж гал түймэр үүсвэрлэн гарсан

ONE. GENERAL PROVISIONS

1. The purpose

The purpose of this "Fire Safety Rule"/hereinafter referred to as Rule/ is to organize the protection of human life, health, property, the environment and public interest that can occur at the Company level; to identify the responsible personnel; and to establish the basic fire safety requirements.

2. Legal framework of fire safety

"New Ulaanbaatar International Airport" LLC will follow the following Laws of Fire Safety and documents approved by the Company in its operations:

- Fire safety rule;
- Plan on urgent fire fighting in facilities; /Features of each facility, number of employees and customers, working schedule, primary firefighting equipment, water supply, road and exits, including studies such as economic indicators, and documents to be used by firefighting units and fire brigades/
- Fire call and alarm procedure are received; /Document regulating the measures to be taken by the employees of firefighting support unit, OC, SCC, RFFD, EGD when a fire alarm is detected in the airport facilities and a call is received/
- Chapter 3 of the Aerodrome manual, Emergency Plan, 3.7.3. /A case where the airport Duty manager announced that an emergency situation arose due to a large-scale fire that broke out and spread in the airport facilities/

3. Definitions, abbreviations.

3.1. "Fire safety" means the protection of human life, health, property, environment and public interests from possible fire hazards;

3.2. "Fire protection equipment" means automatic equipment for detecting, reporting, and extinguishing fires in buildings, smoke removal systems, fire extinguishing water supply, special rescue equipment for each person and public;

3.3. "Primary firefighting tools" are various fire extinguishers used to limit combustion at the source of a fire, substances that neutralize

101

эхлэлийн үед шаталтыг хязгаарлах зориулалтаар хэрэглэх төрөл бүрийн гал унтраагуур, агаар дахь тэсрэх болон галын аюултай хольцыг саармагжуулах бодис, хүрз, галын дэгээ, хөрөө, сүх, цариул, хувин (конус хэлбэртэй), жоотуу, элстэй сав/хайрцаг (0,5м3 багтаамжтай, хүн ергөөд явах боломжтой 8-10кг-аар савласан эсвэл ууталсан байж болно), галд тэсвэртэй бүтээлэг, (бусад: саармагжуулагч бодис, усан сан, ус сорох, шахах хөөрөг, галын хоолой, хушуу г.м. зэрэг болно.

explosive and flammable mixtures in the air, shovels, fire hooks, saws, axes, pickax, buckets (cone-shaped), bag/box with sand (with a capacity of 0.5 m3, can be packed or bagged with 8-10 kg easy to be carried by a person), fire-resistant blankets, (others: neutralizing substances, pools, water suction and pumping bellows , fire hoses, beak etc.

3.4. "Галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг" гэж галын аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журам, заавар, норм, стандартыг;

3.4. "Fire safety norms and normative documents" means rules, regulations, instructions, norms and standards related with ensuring fire safety;

3.5. "Галын аюултай бүтээгдэхүүн" гэж галын эх үүсвэрээс болон химийн урвалын үйлчлэлээр хялбар авалцан асах, хорт хий, утаа ялгаруулах, тэсэрч дэлбэрэх аюултай бодис, материалыг;

3.5." Fire Hazardous Materials" means hazardous substances and materials that are easily ignited by a fire source or chemical reaction which results burning, emiting toxic gases, smoking, or exploding;

3.6. Товчилсон үг:
ШУХТ – Шуурхай удирдлага, хяналтын төв
АБХТ – Аюулгүй байдлын хяналтын төв
ААБГ – Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын газар
ААХ – Аюулгүй ажиллагааны хэлтэс
АГУХ – Аврах, гал унтраах хэлтэс
ЗТГ – Зорчигч терминалын газар
ИТГ – Инженер техникийн газар
ГҮГ- Газрын үйлчилгээний газар

3.6. Abbreviations:
OC – Operation center
SCC – Security control center
SSD – Safety and security department
SMO – Safety management office
RFFD – Rescue firefighting division
PTD – Passenger terminal department
EGD – Engineering department
GHD – Ground handling department

4. Галын аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага

Энэ зүйлд орсон шаардлагыг Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа Засгийн газрын 2016 оны 339 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Галын аюулгүй байдлын үндсэн дүрмээс ишлэн татсан бөгөөд нэг эх үүсвэрээс өөрх үүднээс энэхүү дүрэмд холбогдох хэсгийг тусгасан болно.

4. General requirements for fire safety

This section sets out the relevant requirements cited and sourced solely from Basic Rules of Fire Safety approved by the Appendix to Government Resolution No. 339 of 2016, which is in force throughout Mongolia for ensuring fire safety.

4.1. Барилга, байгууламжуудын хийц бүтээцийн шийдэл нь гал түймэр гарсан тохиолдолд ажилтнуудын аюулгүй байдлыг хангахуйц, гал түймрийг бага хохиролтойгоор унтраах боломцоог хангасан байна.

4.1. The fire protection solutions for buildings and structures ensure the safety of personnel in the event of a fire, and the possibility of fire-fighting with minimal damage.

4.2. Гал түймэр гарсан үед барилга байгууламжаас дүрвэн гарах схемийг урьдчилан боловсруулж нийтэд харагдахуйц газарт байрлуулсан байх ба шаардлагатай байгууламжууд дээр аваарын гэрлэн дохиолол, дүрвэн гарах чиглэлийг заагч хэрэгслээр тоноглосон байна.

4.2. Prepare and place evacuation plans of buildings in a place that is visible to the public, and equip required facilities with emergency lighting and evacuation direction indicators in the event of a fire.

4.3. Галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авч хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол явуулж байна.

4.3. Take all fire prevention measures and conduct preventive inspections regularly.

4.4. Галын аюулаас сэргийлж барилга байгууламж, өрөө тасалгаа бүрд цахилгаан хэрэгслийг хэрхэн ашиглах талаарх зөвлөмжийг байрлуулсан байна.

4.4. Place recommendations on how to use electrical appliances in every building and room to prevent fire.

4.5. Өрөө тасалгааны нөөц түлхүүрийг тусгай хайрцагт хийж лацдан жижүүрийн ажилтанд хадгалуулж яаралтай тохиолдолд Нисэх буудлын эзэлжийн менежерийн шийдвэрээр гаргаж хэрэглэнэ.

4.5. Seal and keep the spare keys of the rooms in a special box and by the shift employee.

4.6. Ажилтнууд нь тамхи татах тусгай цэгт татсан тамхиныхаа гапыг бүрэн унтрааж зориулалтын саванд хаядаг байна.

4.6. The employees put out the cigarettes smoked at the special smoking point and throw them in the designated container.

4.7. Ажлын цаг дуусмагц албан болон ахуйн хэрэглээний цахилгаан хэрэгслүүдийг эх үүсвэрээс нь салгаж, гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байна.

4.7. Office electrical appliances must be unplugged from the source at the end of working hours to prevent from fire.

4.8. Тэсрэх, галын аюултай бодис, материалын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын дүрэм журам, зөвшөөрөгдөх хэм хэмжээнд байна.

4.8. Rules and regulations of explosive, flammable substances and materials storage, transportation and use shall be within the acceptable standards.

4.9. Гал унтраах автомашины усны эх үүсвэрт хүрэх зам гарц, хонгил, нүхэн гарц нь автомашин явах бүрэн бололцоотой, өвлийн цагт цас, мөснөөс цэвэрлэгдсэн байнгын бэлэн байдалд байна.

4.9. The fire engines shall have full access to the roads, tunnels and tunnel exits leading to water sources and prepared and cleaned from snow and ice during winter.

4.10. Барилга байгууламжийг түрээслэх гэрээнд тухайн барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг хангах талаар тусгасан байна.

4.10. The tenant agreement shall include the fire safety of the leasing facility.

4.11. Технологийн нөхцөлөөр олон хүн байх шаардлагагүй, дээврийн хөндий, техникийн давхар, зоорины давхрын хаалгыг цоожтой байлган, түлхүүр хадгалсан газрын мэдээллийг хаалган дээр зааж өгсөн байна. Эдгээр газрын цонхыг шилэлсэн, байнга хаалттай байна.

4.11. Keep the rooftop, AGFL, vault doors not used by many people due to technological conditions locked and place the information of key location on the door. The windows of such places shall be glass and kept closed.

4.12. Шатах хий, шингэнээр (түлшээр) цэнэглэдэг гэр ахуйн хэрэгслийг ашиглахдаа үйлдвэрээс гаргасан аюулгүй ажиллагааны шаардлагыг чанд мөрдөнө.

4.12. Strictly follow the safety requirements issued by the factory when using appliances filled with combustible gas or liquid (fuel).

4.13. Цахилгаан шат нь гал түймэр гарсан үед барилгын 1 дүгээр давхарт автоматаар зогсож хаалга нь нээлттэй байхаар хийгдсэн байна.

4.13. The elevator is designed to automatically stop on the 1st floor of the building in case of fire and the door will be open.

4.14. Холбогдох хууль тогтоомж, баримт бичигт тусгагдсан бусад шаардлагууд.

4.14. Other requirements set forth in applicable laws and regulations.

ХОЁР. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

TWO. STRUCTURE OF FIRE SAFETY

5. Ерөнхий зүйл

5.1. Компанийн хэмжээнд галын аюулгүй байдлыг хангуулах үүрэг хүлээсэн зохион байгуулалтын нэгж нь Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын газар болно.

5. General

5.1. Safety and Security Department is the unit responsible for ensuring fire safety within the company.

5.2. Галын аюулгүй байдлыг хангах ажиллагааны нэг чухал хэсэг бол аюулыг таних, илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, бууруулах арга хэмжээ бөгөөд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд нийт ажилтан, албан хаагчийн сонор сэрэмж, оролцоо, үүрэг хариуцлага хамгаас чухал юм.

5.3. Нисэх буудлын барилга байгууламжид байр, талбай түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын галын аюулгүй байдлын үүрэг, хариуцлага нь түрээсийн гэрээгээр зохицуулагдах ба уг гэрээгээр хүлээсэн үүрэг болон тухайн байгууламжийн гал унтраах шуурхай төлөвлөгөөний хэрэгжилтээр хангагдана.

5.2. The most important part of the fire safety operation in implementing risk management is hazard recognition, detection, risk assessment, and mitigation measures, and the vigilance, participation, and responsibility of all employees.

5.3. The fire safety obligations and responsibilities of the tenants operating in the airport facilities shall be regulated by the tenant agreement and shall be fulfilled by the obligations seth forth in the agreement and the implementation of the fire emergency plan of the facility.

6. Албан тушаалтан, ажилтны эрх, үүрэг

6.1. Компанийн удирдлагын эрх, үүрэг;

6.1.1. Галын аюулгүй байдлыг хангах зорилгоор мэргэжлийн байгууллага, ажилтан, хуулийн этгээдээс мэргэжил арга зүйн туслалцаа, зааварчилга, зөвлөгөө авах эрхтэй;

6.1.2. Галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг биелүүлэх, галын аюулгүй байдлыг хариуцсан албан тушаалтныг томилох;

6.1.3. Галын аюулгүй байдлын дүрэм, гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг баталгаажуулах;

6.2. Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын газрын эрх, үүрэг:

6.2.1. Компанийн хэмжээнд галын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн ажлыг төлөвлөх зохицуулах;

6.2.2. Нисэх буудлын хэмжээнд Галын аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

6.2.3. Гал түймрийн аюулын эрсдэлийн үнэлгээ хийлгэх;

6.2.4. Галын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг төлөвлөх, зохицуулахдаа гал түймрийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлах;

6.2.5. Энэ дүрэм болон байгууламжуудын гал унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулах, сайжруулах;

6.2.6. Байгууламжийн болон үйлдвэрлэл үйлчилгээний чиглэл, онцлогт тохирсон гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжөөр хангах, зардлыг нь жил бүрийн төсөвт тусгах;

6.2.7. Байгууламжууд дээр галын аюулгүй байдлын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэг хийх, зөвлөмж өгөх, гарсан дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;

6. Rights and obligations of officials and employees

6.1. Company management rights and obligations;

6.1.1. To obtain professional and methodological assistance, instructions and advice from professional organizations, employees and legal entities in order to ensure fire safety;

6.1.2. To appoint employee responsible for fire safety to comply with the requirements of fire safety norms and regulatory documents;

6.1.3. To approve fire safety rules and fire emergency plans;

6.2. Rights and obligations of the SSD:

6.2.1. Plan and coordinate work aimed at ensuring fire safety within the company;

6.2.2. Organize the implementation of fire safety legislation at the airport level;

6.2.3. Conduct a fire risk assessment;

6.2.4. Plan and manage fire safety measures according to the risk assessment;

6.2.5. Develop and improve this Rule and fire emergency plan of facilities;

6.2.6. Provide with the basic fire fighting tools and fire protection equipment suitable for the characteristics of facilities and operation services and include cost in each year budget;

6.2.7. Conduct planned and unplanned fire safety inspections at facilities, make recommendations, and make organizations

to take measures to eliminate any non-compliances;

6.2.8. Гал түймрийн аюулаас сэргийлэх, галын аюулгүй байдлыг хангах талаар сургалт, сурталчилгаа явуулах;

6.2.8. Conducting trainings and advertisings on fire prevention and fire safety;

6.2.9. Галын бүлгэмийг сургаж, дадлагажуулах;

6.2.9. Train and give on the job practice to the firefighting support unit;

6.2.10. Бусад.

6.2.10. Others.

6.3. Компанийн эзэмшил бүхий барилга байгууламжууд дээр үйл ажиллагаа явуулж байгаа энэ дүрмийн Хавсралт 1-д заасан зохион байгуулалтын нэгж, түүний удирдлага нь дараах үүрэг хүлээнэ.

6.3. Organizational units specified in Appendix 1 of this Rule operating in company facilities and their management shall undertake the following obligations:

6.3.1. Тухайн байгууламж дээр галын аюулаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой дүрэм, журам, стандартыг ханган ажиллах;

6.3.1. To comply with the rules, regulations and standards related to the prevention of fire hazards in the facility;

6.3.2. Энэ үйл ажиллагаанд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 3 шатны хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх;

6.3.2. To implement the 3-level control system of Labor safety and health in this activity;

6.3.2.1. Ажлын байрны галын аюулгүй байдлын шаардлага хангасан байдлыг шалгах;

6.3.2.1.To check compliance with fire safety requirements of the workplace;

6.3.2.2. Техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хэвийн ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хянах;

6.3.2.2. To control normal operation and integrity of technical equipment and tools;

6.3.2.3. Ажилтнуудын галын аюулын талаарх мэдлэг чадвар, сургалт, зааварчилгаанд хамрагдсан байдлыг шалгах;

6.3.2.3. To check the knowledge, training and instruction of employees about fire hazards;

6.3.3. Гал түймрийн хяналтын улсын байцаагч, мэргэжлийн байгууллагын болон энэ дүрмийн 6.2.7-д заасан үзлэг шалгалтаар өгсөн зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх;

6.3.3. Implement the requirements and recommendations of the state inspector of fire control, professional organizations and requirements stated in 6.2.7 of this rule;

6.3.4. Байгууламж дээр байгаа гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн ажиллагааг энэ дүрмийн Хавсралт 2-т заасан хяналтын хуудсаар сард нэг удаа баталгаажуулах;

6.3.4. Inspect the operation of primary firefighting equipment at the facility according to the checklist specified in Appendix 2 of this rule monthly;

6.3.5. Гал түймэр унтраах үйл ажиллагаанд шуурхай дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

6.3.5. Provide prompt support and assistance in firefighting activities;

6.3.6. Гал түймэр гарсан үед тухайн барилга байгууламжид байгаа хүний тоог үнэн зөв мэдээлэх;

6.3.6. Accurately report the number of people in the facility at the time of fire;

6.3.7. Галын бүлгэмийг томилгоожуулах:

6.3.7. Appointing a firefighting support unit;

6.4. Галын аюулгүй байдлыг хангах талаар нийт ажилтны эрх:

6.4. Rights of all employees regarding the fire safety:

6.4.1. Гал түймэр гарсан үед амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалуулах;

6.4.1. To being protected in life, health, and property in the event of a fire;

6.4.2. Гал түймрийн шалтгаан нөхцөлийг тогтооход биечлэн оролцох;

6.4.2. To personally participate in determining the cause of the fire;

6.4.3. Гал түймэртэй холбогдолтой үнэн зөв мэдээлэл авах

6.4.3. To get relevant and accurate information regarding the fire;

6.4.4. Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг холбогдох байгууллагаас шаардах.

6.4.4. To require the relevant organization to hold accountable the person who violates the laws on fire safety.

6.5. Галын аюулгүй байдлыг хангах талаар нийт ажилтны үүрэг:

6.5. Obligations of all employees regarding the fire safety:

6.5.1. Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

6.5.1. To comply with the fire safety law and legislation;

6.5.2. Нисэх буудлын барилга, байгууламжид гал түймэр гарч байгаа эсхүл гал түймэр гарсан байж болзошгүй шинж тэмдэг (утаа гарах, үнэртэх, орчны дулааны хэм ихсэх гэх мэт) илрүүлсэн тохиолдолд АГУХ-ын 71287311, АБХТ-ийн 71287350, ШУХТ-ийн 71287300 дугаарын утас руу яаралтай мэдэгдэх;

6.5.2. To call immediately to RFFD-71287311, Security control center 71287350,OC-71287300 in case there is a fire in the airport building or facilities, or signs of a possible fire (e.g., smoke, smell, high ambient temperature, etc.);

6.5.3. Гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, унтраах үйл ажиллагаанд бололцоотой дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

6.5.3. To provide possible support and assistance in fire prevention, rescue and firefighting activities;

6.5.4. Галын аюулгүй байдал, энэ дүрмийн шаардлагатай холбоотой зөрчил, дутагдал, мэдээллийг 71287350 дугаарт шуурхай мэдээлэх;

6.5.4. To promptly report violations and deficiencies regarding the fire safety and this rule requirements to 71287300;

6.5.5. Ажлын байран дээрх галын аюулгүй байдлыг хангаж ажиллах;

6.5.5. To provide fire safety in workplace;

6.5.6. Ажил тарах болон ажлын байраа удаан хугацаанд эзэнгүй орхих тохиолдолд бүх гэрэл чийдэн, компьютер болон бусад цахилгаан хэрэгслүүд, шаардлагагүй тоног төхөөрөмжүүдийг унтрааж хүчдэлээс салгаж явахыг хэвших, бусдадаа зүй ёсны шаардлага тавих.

6.5.6. To make a habit of turning off all lights, computers, and other electrical appliances and unnecessary equipment and disconnecting them from the power supply, and make reasonable demands on others in the case of leaving work or leaving the workplace unoccupied for a long time.

7. Галын аюулгүй байдлыг хангах сургалт, сургуулилт

7. Fire safety training and exercises

7.1. Ажилд шинээр орсон ажилтнуудад галын аюулгүй байдлын танилцах сургалт хийх, энэ дүрмийг танилцуулах, мөн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн чиглэсэн сургалт зохион байгуулах, нийт ажилтнуудад ажлын байранд галын аюулгүй байдлыг хангах талаар зөв дадал зуршил бий болгох чиглэлээр ухуулах, таниулах ажлыг ААА&Б болон мэргэжлийн байгууллага хамтран зохион байгуулах бөгөөд Компанийн зохион байгуулалтын нэгжийн удирдлагууд нь ажилтнуудыг бүрэн хамруулах ажлыг хариуцна.

7.1. SSD in cooperation with professional organization will be responsible for organizing fire safety training, introducing this rule for all new employees, organizing necessary trainings to promote the fire safety in workplace for all employees to create awareness and habits, The company is responsible for the full involvement of employees.

7.2. Байгууламжийн гал унтраах шуурхай төлөвлөгөөнд Галын бүлгэмд ажиллахаар тодорхойлсон ажилтанд чиглүүлэх сургалт, дадлагыг хагас жил тутамд ААА&Б-ын Гал аюулаас сэргийлэх ажиллагааны мэргэжилтэн хариуцан явуулж, чадвар эзэмшсэн байдлыг үнэлж, зохих арга хэмжээ авч ажиллана.

7.2. SSD Fire prevention officer is responsible for organizing trainings and exercises to the employees designated in Firefighting support unit every six months and evaluate their skills and take necessary actions.

7.3. Жилд нэг удаа Компанийн аль нэг байгууламжид болзошгүй гал ослын үед авах хариу арга хэмжээний дасгал сургуулилтыг ААА&Б-ын Аврах гал унтраах хэлтэс дангаараа эсхүл Төв

7.3. The RFFD solely (or in cooperation with EMA of Tuv Province) is responsible for organizing tactical exercise of response measures in case of fire emergency in any of the facilities of the company once a year.

аймгийн ОБГ-тай хамтран зохион байгуулна.

7.4. Сургалтын төрөл, давтамж нь ажлын байрны галын аюулгүй байдлын эрсдэл, байгууламжийн гал унтраах шуурхай төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг, үйл ажиллагааны судалгаа, хэрэгцээ шаардлагад үндэслэсэн байна. /Хавсралт 3/

7.4. The type and frequency of training will be based on the fire safety risks of the workplace, the obligations included in firefighting emergency plan, operation research and needs/Appendix 3/.

8. Гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгсэл

8.1. Байгууламжийн гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл нь Монгол Улсын стандарт MNS 5566:2020 /Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм/-ын дагуу хангагдсан байна.

8. Primary firefighting equipment

8.1. The primary firefighting equipment of the facility is provided in accordance with the standard of Mongolia MNS 5566:2020 /Requirements and norms for primary firefighting equipment in companies, organizations, and buildings and facilities.

9. Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж.

9.1. Компани нь барилга байгууламж дахь гал түймрийг илрүүлэх, мэдээлэх, унтраах автомат тоног төхөөрөмж, утаа зайлуулах систем, гал унтраах усан хангамжтай байна.

9.2. Галын дохиоллын систем нь галыг эрт илрүүлэх зориулалт бүхий систем бөгөөд нисэх буудлын бүх барилга, байгууламжууд галын дохиоллын нэгдсэн системд холбогдсон байна.

9.3. Галын дохиоллын систем нь программ хангамж, галын удирдлагын самбар, гар мэдээлэгч, дуут болон гэрлэн дохионы төхөөрөмж, олон төрлийн мэдээлэгч (утааны, дулааны, дөлний, туяаны)-ээс бүрдэнэ.

9.4. Байгууламжийн гал түймрээс хамгаалах хэрэгсэл, галын анхан шатны багаж хэрэгслийн тоо хэмжээ, байрлал нь ААБГ-аас боловсруулсан тухайн байгууламжийн гал унтраах шуурхай төлөвлөгөөнд тодорхой заагдсан байх ба энэ дүрмийн 6.2.7-д заасан үзлэг шалгалтаар баталгаажуулан, сайжруулна.

9.5. Галын дохиоллын системийн ашиглалтын бэлэн байдлыг НУБИЭ ХХК-ийн Инженер техникийн газар хариуцах ба систем хариуцсан 24 цагаар ажиллах инженер техникийн ажилтантай байна.

9.6. Галын дохиоллыг хүлээн авах, зохицуулах ажилтан нь ААБГ-ын Аюулгүй байдлын эзлжийн ахлагч байна.

9.7. Галын дохиоллын дагуу ажиллах журмыг ААБГ-аас боловсруулж, баталгаажуулна.

9. Fire protection equipment.

9.1. The company shall be equipped with automatic equipment for detecting, reporting and extinguishing fires in buildings, smoke removal systems, and fire fighting water supply.

9.2. The fire alarm system is a system for early detection of fire, and all buildings and facilities of the airport are connected to the integrated fire alarm system.

9.3. A fire alarm system shall consist of software, a fire control panel, manual call points, sound and light alarm devices, and various types of detectors (smoke, heat, flame, radiation).

9.4. Number and location of the fire protection equipment and primary firefighting equipment is reflected in each Building fire safety plan which is developed by SSD, and it will be confirmed and improved by fire inspection specified in clause 6.2.7 of this Rule,

9.5. The EGD is responsible for the readiness of the fire alarm system software, and shall have a 24-hour engineer and technician responsible for the system.

9.6. The person responsible for receiving and coordinating the fire alarm is the Security center supervisor of SSD.

9.7. SSD is responsible for developing and approving the measures to be taken when fire call and alarm received procedure.

10. Нисэх буудал дээр үйл ажиллагаа явуулж буй гадныи байгууллагын галын аюулгүй байдал.

10.1. Нисэх буудал дээр үйл ажиллагаа явуулж буй гаднын байгууллагууд өөрийн эзэмшиж буй өрөө тасалгаа, явуулж буй үйл ажиллагаатай холбоотой галын аюулгүй байдлыг хангах үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хүлээнэ.

10.2. Нисэх буудалд үйл ажиллагаа явуулж буй гадны байгууллагуудын эзэмшиж буй өрөө тасалгаа, явуулж буй үйл ажиллагааны галын аюулгүй байдлын асуудал тухайн байгууламжийн гал унтраах шуурхай төлөвлөгөөнд тусгагдсан байж болно.

10.3. Энэ дүрмийн 10.1, 10.2-т заасан нөхцөл нь нисэх буудлын емч хөрөнгө цаашилбал үйл ажиллагаанд нөлөөлөхөөс сэргийлж үзлэг шалгалт хийх, зөвлөмж өгөх, сануулах, үйл ажиллагааг нь зогсоох эрхийг түрээсийн гэрээгээр зохицуулна.

10.4. Компанийн түрээсийн асуудал хариуцсан ажилтан түрээслэгчийн галын аюулгүй байдлын асуудлаар ААА6Г-ын Гал унтраах, сэргийлэх ажиллагааны мэргэжилтнээс мэргэжил арга зүйн зөвлөмж, туслалцаа авч хамтран ажиллана.

10. Fire safety of external organizations operating at the airport.

10.1. External organizations operating at the airport are responsible for ensuring fire safety in their rooms and operations in accordance with the law.

10.2. The rooms and operation fire safety issues in facilitoes of external organizations operating at the airport can be included in firefighting emergency plan.

10.3. Conduct inspection to prevent the conditions specified in 10.1 and 10.2 of this rule from affecting the airport property, give recommendations, warn, and stop the operation according to the tenant agreement.

10.4. The employee responsible for the tenants will get technical advice and assistance from fire prevention officer of SSD and cooperate regarding the tenant's fire safety.

11. Галын эрсдэлтэй ажил үйлчилгээ явуулах үеийн галын аюулгүй байдал

11.1. Галын эрсдэлтэй ажил үйлчилгээнд нисэх буудлын үйл ажиллагаанд хамаарах дараах ажил үйлчилгээ орох бөгөөд үүгээр хязгаарлахгүй. Үүнд:

a/ өвс шатаах;

b/ мастик хайлуулах, гагнуур хийх, төмөр тастах гэх мэт ил гал/дөл, оч/ гарган явуулах ажлууд.

c/ агаарын хөлөгт зорчигчтой сумалгаа хийх;

d/ шатахуун асгарсан бохирдлыг цэвэрлэх ажил;

e/ ажил гүйцэтгэгчийн зүгээс галын эрсдэлтэй гэж үзсэн болон галын дохиоллыг идэвхгүй болгох шаардлагатай бусад ажил;

11.2. Галын аюулын эрсдэлтэй ажил, үйлчилгээ явуулах этгээд Нисэх буудлын ээлжийн менежер, ААА6Г-ын даргад урьдчилан мэдэгдэж, энэ дүрмийн Хавсралт 4-д заасан маягтын дагуу зөвшөөрөл авна.

11.3. ААА6Г-ын дарга нь галын аюулын эрсдэлийг бууруулах, хянах арга хэмжээг чиглүүлж, галын аюулгүй байдлыг хангасан, тухайлсан зааварчилга авсан байдлыг үндэслэн зөвшөөрлийг олгоно.

11. Measures to ensure fire safety during the performance of fire-hazardous work and services

11.1. Fire-hazardous work and services include, but are not limited to, the following airport operations. It includes:

a/ open fire activities such as burning grass;

b/ activities involving open fire /flame, sparks, such as melting mastic, welding, metal cutting, etc.

c/ refuelling the aircraft with passengers inside;

d/ cleaning up spilled fuel;

e/ other works that can be fire- hazardous according to body who is performing the work.

11.2. The person who will perform the work and services shall notify the airport duty manager and the head of the SSD in advance and obtain permission according to the form specified in Appendix 4 of this rule.

11.3. The head of the SSD will give permission by directing to reduce and control the risk of fire safety and based on fulfillment of fire safety requirements and Labor safety directions.

11.4. Агаарын хөлөгт зорчигчтой сумалгаа хийх тохиолдолд Нисэх буудлын эзэлжийн менежерээс зөвшөөрөл авч, АГУХ-ийн галын хамгаалалтын үйлчилгээ авна.

11.5. Нисэх буудлын эзэлжийн менежер нь галын аюултай ажил үйлчилгээ явуулах үед тухайн газарт эсвэл объектод, саадгүй нэвтрэх боломжтой байх аврах гарц, орцыг тодорхойлох болон бусад холбогдох зөвлөмж өгч болох ба ААХ, АБХТ, АГУХ-т мэдэгдсэн байна.

11.4. Receive paid fire protection services of the Airport during refuelling the aircraft with passengers inside with the approval of the airport duty manager.

11.5. Airport duty manager of the airport may give other relevant recommendations for the identification of emergency exits and entrances that will allow unhindered access to the place or object when performing fire-hazardous work and services, and notify the SMO, SCC and RFFD.

ГУРАВ. БУСАД

12. Галын аюулгүй байдлыг хангах зорилгоор барилга байгууламжид хориглох зүйл.

12.1. Барилга байгууламжийн хоорондох галын аюулгүйн зайг бараа материал хураах, автомашины зогсоол болгох зэргээр ашиглах;

12.2. Барилга байгууламжийн ойр орчимд хялбар авалцан асах шатамхай шингэн, шахсан болон шингэрүүлсэн хийн савыг хяналтгүйгээр орхих

12.3. Технологийн горимыг нь хэмжих хяналтын төхөөрөмж нь салгаатай, эсхүл эвдрэл гэмтэлтэй тоног төхөөрөмжийг ажиллуулах;

12.4. Зоорины болон хагас зоорины давхарт дүрмээр зөвшөөрөгдсөнөөс бусад шатамхай болон хялбар авалцан асах шингэн, дарь, тэсэрч дэлбэрэх бодис, материал, хийн баллон зэрэг галын аюултай бодис, материалыг хадгалах, хэрэглэх;

12.5. Дээврийн хонгил, техникийн давхар, салхивчийн камерын өрөө, шатны хөндий зэргийг үйлдвэрлэл, засвар хийхэд ашиглах, тэдгээрт шатамхай материал, тоног төхөөрөмж, үйлдвэрийн бүтээгдэхүүн хадгалах;

12.6. Цахилгаан урсдаг шатны өмнөх талбай, шатны талбай зэрэгт худалдаа болон бусад ажил, үйлчилгээ явуулах, агуулахын зориулалтаар ашиглах;

12.7. Гадна аврах шат, тагт хоорондын шатны талбай, хавхалга хаалт, дамжин өнгөрөх зам, аврах зам гарцыг хаах, гарцын талбайг багасгаж эд зүйл хураах, байрлуулах;

12.8. Өрөө тасалгаа, хувцас хэрэгслийг бензин, түлш зэрэг шатах бодис, материалаар цэвэрлэх, угаах, хөлдсөн шугам хоолойг ил гал, бамбар, гал үлээгчээр гэсгээх (зөвхөн халуун ус, элс ууруар гэсгээнэ);

12.9. Ажлын байранд цэвэрлэгээний тостой материалыг орхих;

12.10. Аврах зам, гарц, хаалгыг хааж (хонгил, гарц, үүдний өрөө, цахилгаан шатны талбай, шатны тавцан, дээвэрт гарах

THREE. OTHERS

12. Prohibited items in buildings and facilities in order to ensure fire safety.

12.1. Use of fire safety spaces between buildings for stockpiling and parking;

12.2. Leaving flammable liquids, compressed and liquefied gas containers unattended near the buildings;

12.3. Use of equipment with disconnected or damaged technology mode;

12.4. Storage and use of inflammable and easily ignited liquids, gunpowder, explosive substances, materials, and gas cylinders in ground and semi-ground floors;

12.5. Use of roof tunnels, technical floors, ventilation chamber rooms, and stairwells for production and repair, storage of flammable materials, equipment, and industrial products in them;

12.6. Use of the area in front of the electric escalator, the area of the stairs, etc. for trade and other works and services, as well as for storage;

12.7. Blocking the outdoor emergency stairs, the area of the stairs between the balconies, the valve block, the passageway, the emergency exits, placing and storing items that are narrowing the exit area;

12.8. Clean and wash rooms and clothing with combustible substances and materials such as gasoline and fuel, defrost the frozen pipelines with open fire, torches, and fire blowers (defrost only with hot water, sand and steam);

12.9. Leaving cleaning oil materials in the workplace;

12.10. Close emergency routes, exits, doors (such as tunnels, exits, hallways, elevators, stairways, roof exits, doors), store various

гарц, хаалга зэргийн) тэрэл бүрийн хог хаягдал, бараа материал, эд зүйл хураах, тоног төхөөрөмж байрлуулах, хаалгыг онгойхгүйгээр бэхлэх;

12.11. Гал түймэр гарсан үед автоматаар хаагддаг хаалт, хаалганы зориулалтыг өөрчлөх, авах;

12.12. Барилга, байгууламжуудын гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах;

12.13. Галын дохиоллын системийг удирдлагын самбараас унтраах, тохиргоог өөрчлөх ажлыг ИТГ-ийн систем хариуцсан инженер, АБХТ-ийн зохицуулагч, АГУХ-ийн дуудлага хүлээн авагчаас бусад ажилчид хийх;

12.14. Тамхи татах цэгээс бусад газарт тамхи татах;

garbage, inventory, items, equipment, lock the doors without opening them;

12.11. Change or remove shutters and doors that automatically close in case of fire;

12.12. Improper use of primary firefighting equipment of buildings and facilities;

12.13. The work of turning off the fire alarm system from the control panel and changing the settings shall be done by employees other than the engineer of EGD, security control center, and watchroom operator of RFFD;

12.14. Smoking in places other than smoking areas;

13. Хяналт

13.1. Компанийн удирдлага болон ААБГ нь энэхүү дүрмийн биелэлтэд хяналт тавина.

13.2. Энэхүү дүрмийг зөрчсөн ажилтанд холбогдох хууль тогтоомж, компанийн Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрмийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

13. Monitoring.

13.1. The company's management and SSD will monitor the implementation of this rule.

13.2. An employee who violates this rule will be held accountable in accordance with the Internal Labor Regulations, Code of Conduct, and relevant laws of "New Ulaanbaatar International Airport" LLC.

Хавсралт/*Appendix/* 1

НУБИЭ ХХК-ийн эзэмшлийн барилга байгууламжуудын галын аюулаас урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ажилтан

/Employee responsible for fire prevention of facilities of *NUBIA LLC/*

№	Барилга, байгууламж */Building and facility/*	Харьяалах нэгж */Unit/*	Албан тушаал */Position/*
1	Зорчигч терминалын барилга */Passenger terminal building/*	ЗТГ */PTD/*	Хэлтсийн менежер */Division Manager/*
2	Бизнес танхим */Business lounge/*		Хэлтсийн менежер */Division Manager/*
3	Дулаан зогсоол /Heated garage/		Хэлтсийн менежер */Division Manager/*
4	Газрын үйлчилгээний барилга */GSE building/*	ГҮГ */GHD/*	Талбайн үйлчилгээний менежер */Division Manager/*
5	Карго терминалын барилга */Cargo terminal building/*		Ачаа шуудан үйлчилгээний менежер */Division Manager/*
6	Бохир ус цэвэрлэх байгууламж */Sewage treatment plant/*	ИТГ */EGD/*	Бохир ус цэвэрлэх байгууламжийн инженер */STP engineer/*
7	Цэвэр усны байгууламж */Water treatment plant/*		Цэвэр усны байгууламжийн инженер /WTP engineer/
8	Цахилгааны үндсэн дэд өртөө */Main Substation/*		Цахилгааны ахлах инженер */Electrical senior engineer/*
9	Аэродромын барилга */Aerodrome/*		Аэродромын хэлтсийн дарга */Division Manager/*
10	Дулааны станц /Heating plant/		Дулааны станцын ахлах инженер /Senior engineer/
11	Бүх техникийн өрөө */Technical rooms/*		Хариуцсан инженерүүд /Engineers/
12	Захиргааны барилга /Administration building/	ААБГ */SSD/*	Галын аюулаас сэргийлэх ажиллагааны мэргэжилтэн /Fire prevention officer/
13	Авран хамгаалах гал унтраах албаны байр */Fire station/*		Аврах гал унтраах хэлтсийн дарга /RFFD manager/
14	Хамгаалалтын постууд */Security posts/*		Аюулгүй байдлын үйл ажиллагааны мэргэжилтэн /Security operation officer/

Хавсралт/*Appendix/* 2

Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл нэг бүрийн хяналтын карт:
/Check card for each primary firefighting equipment:/

.....-.....он/year/

Нэгжийн нэр/*Organization name/*: .....

Багаж хэрэгслийн нэр төрөл/Types of tools/.....

Сар */Month/*	Чанар байдлын тэмдэглэл */Quality Notes/*	Шалгасан албан тушаалтны гарын үсэг */Signature/*	Сар */Month/*	Чанар байдлын тэмдэглэл */Quality Notes/*	Шалгасан албан тушаалтны гарын үсэг */Signature/*
1			1		
2			2		
3			3		
4			4		
5			5		
6			6		
7			7		
8			8		
9			9		
10			10		
11			11		
12			12		

Хавсралт/*Appendix*/ 3

Галын аюулгүй байдлын сургалт, дасгал сургуулилт

/Fire safety training and exercise/

№	Сургалт */Training & exercise/*	Зорилго */Purpose/*	Оролцох ажилтнууд */Participants/*	Хугацаа */Period/*	Холбогдох баримт бичиг */Relevant document/*
1	Танилцуулах сургалт: Галын аюул, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ажилтны үүрэг оролцоо, гал гарсан үед авах анхан шатны арга хэмжээ Orientation training: */Fire hazard, prevention measures, responsibilities of employees, first steps taken in case of fire/*	Компанийн галын аюулгүй байдлын баримт бичгүүдийг шинэ ажилтнуудад танилцуулж, ерөнхий ойлголт өгөх */Introduce Fire safety documents of the Company to new employees for general understanding/*	Компанийн болон хамтран ажиллагч байгууллагуудын шинэ ажилтнууд */New employees of the Company and airport related parties/*	Жилд 4-өөс доошгүй удаа */At least 4 times a year/*	Нисэх буудлын ерөнхий зааврын 2.7 */Clause 2.7 of the Aerodrome Manual/*
2	Ажлын байран дээрх сургалт: Тухайн барилга байгууламжийн гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө, галын бүлгэмийн гишүүн бүрийн үүрэг, оролцоог сургаж, дадлагажуулах */On the job training:* *To train and practice each member of the firefighting support unit for the building fire safety plan and its responsibilities/*	Байгууламж бүрийн онцлогт нийцүүлсэн "Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах замаар шуурхай ажиллагаар хангах */Ensure prompt operation by implementation of the "Building fire safety plan" which is developed in accordance with features of facilities/*	Галын бүлгэмийн гишүүд */Members of the firefighting unit/*	Жилд 2-оос доошгүй удаа */At least 2 times a year/*	Галын аюулгүй байдлын тухай Монгол Улсын хуулийн 17.2.4 дэх заалт */Clause 17.2.4 of the Fire safety law of Mongolia/*
3	Галын ослын үед авах хариу арга хэмжээний дасгал сургуулилт (Төв аймгийн ОБГ-тай хамтран зохион байгуулах) */Exercise:* *Response exercise in case of fire (Arrange with Emergency management office of Tuv province)/*	Галын аюулгүй байдлын баримт бичгийн нийцлийг шалгах, сайжруулах. гал гарсан үеийн хариу арга хэмжээний чадавхийг сайжруулах */Review and improve compliance with fire safety documents and improve response capabilities in case of fire/*	АГУХ, эмнэлгийн хэсэг, тухайн байгууламжийн ажилтнууд */RFFD, fist aid section, employees of the facility/*	Жилд 1-ээс доошгүй удаа */At least once a year/*	Онцгой нөхцөлийн төлөвлөгөөний 3.5 */Clause 3.5 of the Emergency Plan/*

Тайлбар: Галын аюулгүй байдлын сургалт, дасгал сургуулилтыг дээрх хугацаанд баригдалгүй хэрэгцээ шаардлагад болон Эрх бүхий байгууллагаас иргүүлсэн зөвлөмжид үндэслэн нэмэгдүүлэн зохион байгуулж болно.

/Remark: Fire safety trainings and exercises can be organized in addition based on the needs, requirements and recommendation of the Authorized organization./

Хавсралт/*Appendix*/ 4

Галын эрсдэлтэй ажил, үйлчилгээ гүйцэтгэх зөвшөөрлийн хуудас
Form for permission to perform fire-hazardous work and activities

1. **Зөвшөөрөл хүсэгчийн бөглөх хэсэг** */Part to be completed by the applicant/*:

Ажил, үйлчилгээ */Work and service/*: .....
.....
Байршил */Location/*:.....
.....
Хугацаа */Date/*: .....
Хийж гүйцэтгэх бүрэлдэхүүн (албан тушаал, нэр, утас) */Performing bodies (position, name, phone number)/*:.....
.....
Галын аюулгүй байдлаа хангасан байдал */Measures taken to ensure fire safety/*: .....
.....
.....
Галын аюулгүй байдал хангаж ажиллах тухайлсан зааварчилгаа өгсөн ажилтны мэдээлэл */Information of the employee who gave instructions on occupational safety and fire safety/*:
.....
Зөвшөөрөл хүсэгч */Applicant/*:

Байгууллага /нэгж/ *Organization /Unit/*	Албан тушаал *Position*	Нэр *Name*	Огноо *Date*	Гарын үсэг *Signature*

2. **Зөвлөмж** */Notification/*:
   a. Ажлын байрны галын аюулгүй байдлаа хангаж ажиллах */Ensure workplace fire safety/*.
   b. Гал унтраах нэгжийн хамгаалалтгүй ажиллах бол зөөврийн гал унтраагуур ажлын байранд бэлэн байлгах */If you are going to work without the protection of a fire extinguishing unit, keep a fire extinguisher ready at the workplace/*.
   c. Галын дохиолол салгасан бол ажил дуусмагц хариуцсан инженерт мэдэгдэж галын дохиоллыг хэвийн ажиллагаанд оруулах */If the fire alarm is disconnected, notify the engineer in charge of the completion of the work and put the fire alarm into normal operation/*.

3. **Зөвшөөрөл олгогчийн бөглөх хэсэг** */Part to be completed by the authority/*:

Зөвшөөрөл олгосон огноо */Date of Permit/*: .....

Гал унтраах нэгжийн хамгаалалт шаардлагатай эсэх
/Whether protection of the firefighting unit is required/: □ Тийм □ Үгүй

Тухайн байршлын галын дохиоллын систем салгах эсэх
/Whether to disconnect the fire alarm system of the location/: □ Тийм □ Үгүй

Бусад */Other arrangements/*: _____

Зөвшөөрсөн */Approved by/*:

Албан тушаал *Position*	Нэр *Name*	Шийдвэр *Decision*	Огноо *Date*	Гарын үсэг *Signature*
ААБГ-ын дарга				

Хянасан */Reviewed by/*:

Галын аюулаас сэргийлэх ажиллагааны мэргэжилтэн */Fire prevention officer/*

Албан тушаал *Position*	Нэр *Name*	Шийдвэр *Decision*	Огноо *Date*	Гарын үсэг *Signature*

Галын дохиолол хариуцсан инженер */Fire alarm system engineer/*:

Албан тушаал *Position*	Нэр *Name*	Шийдвэр *Decision*	Огноо *Date*	Гарын үсэг *Signature*

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн
А/154 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0006843

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: "НЬЮ-УБ" ИНТЕРНЭЙШИЛ ЭЙРПОРТ ХХК

Хаяг: СЭРГЭЛЭН СУМ 4 ДҮГЭЭР БАГ

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: ЦЭВЭР УСНЫ БАЙГУУЛАМЖ

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал хэрэглэж байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.
Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3/

Олгосон: 2022 он 08 сар 16 өдөр

Хүчинтэй хугацаа: 2024 он 08 сар 16 өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

ТӨВ

дарга ХУРАНДАА

аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
цолтой Н.ТӨМӨРБААТАР

ТӨВ

Дүгнэлт гаргасан:

аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
АХМАД цолтой А.БЭХ-ОЧИР

Гал түймрийн улсын хяналтын байцаагч

/тэмдэг дарна/

Онцгой байдлын сонгон газрын дарга
2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн
А/154 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0006852

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: "НЬЮ-УБ" ИНТЕРНЭЙШИЛ ЭЙРПОРТ

Хаяг: СЭРГЭЛЭН СУМ 4 ДҮГЭЭР БАГ

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл:

ЦАХИЛГААН ТҮГЭЭХ ДЭД ӨРТӨӨ

5	Намрын нүүдлийн судалгаа	2022.08.10-2022.10.15 (5 хоног) 2022.08.15-2022.08.31 (5 хоног) 2022.09.05-2022.09.26 (5 хоног) 2022.09.30-2022.10.10 (5 хоног)	- Суурин болон намрын нүүдлийн үед дайран өнгөрөх шувуудын судалгаа - Харууц сайтай цэгээс ажиглах судалгаа (аэродромын талбайн дотор 2, гадна 6 цэг) - Шугаман замналын судалгаа (аэродромын талбайн 15 км радиуст тохиолдох амьдрах орчин бүрт замналын судалгаа)	- С. Гомбобаатар - Ж. Мөнх-Эрдэнэ - П. Даваасүрэн - Б. Юмжирмаа - А. Бүжинлхам	- Судалгааны арга зүй, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу намрын нүүдлийн хээрийн судалгааг чанартай гүйцэтгэж, шинжлэх ухааны үндэслэлтэй өгөгдөл цуглуулсан байна. - Судалгааны талбайн ажиглалтын цэгүүд болон түүний орчимд замналын аргын дагуу бүртгэсэн байна. - Шувуудын намрын нисэлтийн өндөр, нисэн өнгөрөх хугацаа, идэвхжил, нягтшил, давтамж, тохиолдцын намрын улирлын мэдээлэл бүрдсэн байна.

2. Хөхтөн амьтдын судалгаа

№	Зорилт ба гүйцэтгэх судалгаа	Хээрийн судалгаа гүйцэтгэх огноо (ажиллах хугацаа)	Гүйцэтгэх ажил	Хариуцах эзэн ба судлаачид	Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт
ТУРАГ (ТОМ) ХӨХТӨН (Тураг хөхтөн амьтдын судалгаа гүйцэтгэх зардал төсөвт багтаагүй ба шувууны судалгаатай хамт гүйцэтгэхээр төлөвлөлөө)					
1	Өвлийн судалгаа	2021.12.06-2021.12.20 (5 хоног) 2022.01.10-2022.01.28 (5 хоног) 2022.02.07-2022.02.25 (5 хоног) 2022.11.17-2022.11.30 (5 хоног)	- Нисэх буудал орчим өвлийн улиралд тохиолдох хөхтөн амьтдын судалгаа - Харууц сайтай цэгээс ажиглах судалгаа (аэродромын талбайн дотор 2, гадна 6 цэг) - Шугаман замналын судалгаа (аэродромын талбайн 5 км радиуст тохиолдох амьдрах орчин бүрт замналын судалгаа)	- С. Шар - Ж. Мөнх-Эрдэнэ - П. Даваасүрэн - Б. Юмжирмаа - А. Бүжинлхам	- Судалгааны арга зүй, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу өвлийн улиралд хээрийн судалгааг чанартай гүйцэтгэж, шинжлэх ухааны үндэслэлтэй өгөгдөл цуглуулсан байна. -Өвлийн улиралд тохиолдох хөхтөн амьтдын зүйлийн бүрдэл, тохиолдоц, тархалт, тоо толгой, идэвхжилийг тогтооно.
2	Хаврын судалгаа	2022.03.21-2022.03.31 (5 хоног) 2022.04.11-2022.04.29 (5 хоног) 2022.05.02-2022.05.12 (5 хоног)	- Нисэх буудал орчим хаврын улиралд тохиолдох хөхтөн амьтдын судалгаа - Харууц сайтай цэгээс ажиглах судалгаа (аэродромын талбайн дотор 2, гадна 6 цэг) - Шугаман замналын судалгаа (аэродромын талбайн 5 км радиуст тохиолдох амьдрах орчин бүрт замналын судалгаа)	- С. Шар - Ж. Мөнх-Эрдэнэ - П. Даваасүрэн - Б. Юмжирмаа - А. Бүжинлхам	- Судалгааны арга зүй, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хаврын хээрийн судалгааг чанартай гүйцэтгэж, шинжлэх ухааны үндэслэлтэй өгөгдөл цуглуулсан байна. - Судалгааны талбай болон түүний ойролцоо хавар тохиолдох амьтдын ажиглалт хийж, бүртгэсэн байна. - Хөхтөн амьтдын хаврын улиралд тохиолдох зүйлийн бүрдэл, тохиолдоц, тархалт, тоо толгой, идэвхжилийг тогтооно.
3	Зуны судалгаа	2022.05.02-2022.05.16 (5 хоног) 2022.06.06-2022.06.20 (5 хоног) 2022.07.18-2022.07.25 (5 хоног) 2022.07.29-2022.08.10 (5 хоног)	- Нисэх буудал орчим зуны улиралд тохиолдох хөхтөн амьтдын судалгаа - Харууц сайтай цэгээс ажиглах судалгаа (аэродромын талбайн дотор 2, гадна 6 цэг) - Шугаман замналын судалгаа (аэродромын талбайн 5 км радиуст тохиолдох амьдрах орчин бүрт замналын судалгаа)	- С. Шар - Ж. Мөнх-Эрдэнэ - П. Даваасүрэн - Б. Юмжирмаа - А. Бүжинлхам	- Судалгааны талбайд зуны хээрийн судалгааг чанартай гүйцэтгэж, шинжлэх ухааны үндэслэлтэй өгөгдөл цуглуулсан байна. -Хөхтөн амьтдын зуны улиралд тохиолдох зүйлийн бүрдэл, тохиолдоц, тархалт, тоо толгой, идэвхжилийг тогтооно.
4	Намрын судалгаа	2022.08.10-2022.10.15 (5 хоног) 2022.08.15-2022.08.31 (5 хоног)	- Нисэх буудал орчим намрын улиралд тохиолдох хөхтөн амьтдын судалгаа	- С. Шар - Ж. Мөнх-Эрдэнэ - П. Даваасүрэн - Б. Юмжирмаа	- Судалгааны арга зүй, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу намрын хээрийн судалгааг чанартай гүйцэтгэж, шинжлэх ухааны үндэслэлтэй өгөгдөл цуглуулсан байна.

293

		2022.09.05-2022.09.26 (5 хоног) 2022.09.30-2022.10.10 (5 хоног)	- Харууц сайтай цэгээс ажиглах судалгаа (аэродромын талбайн дотор 2, гадна 6 цэг) - Шугаман замналын судалгаа (аэродромын талбайн 5 км радиуст тохиолдох амьдрах орчин бүрт замналын судалгаа)	- А. Бүжинлхам	-Хөхтөн амьтдын камрын улиралд тохиолдох зүйлийн бүрдэл, тохиолдоц, тархалт, тоо толгой, идэвхжилийг тогтооно.
ЖИЖИГ ХӨХТӨН (МЭРЭГЧ)					
5	Өвлийн судалгаа	2021.12.06-2021.12.20 (5 хоног) 2022.02.07-2022.02.25 (5 хоног)	- Аэродромын талбай болон түүний орчим өвлийн улиралд тохиолдох жижиг хөхтөн амьтдын судалгаа (аэродромын талбай дотор болон 5 км радиуст амьдрах орчны олон янз байдлыг харгалзан гүйцэтгэнэ)	- С. Шар - Д. Өсөхжаргал - С. Лхам	- Судалгааны арга зүй, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу өвлийн улиралд хээрийн судалгааг чанартай гүйцэтгэж, шинжлэх ухааны үндэслэлтэй өгөгдөл цуглуулсан байна. - Жижиг хөхтөн амьтдын зүйлийн бүрдэл, тоо толгой, нягтшил, тохиолдоцыг тогтооно.
6	Хаврын судалгаа	2022.04.11-2022.04.29 (10 хоног)	- Аэродромын талбай болон түүний орчим хаврын улиралд тохиолдох жижиг хөхтөн амьтдын судалгаа (аэродромын талбай дотор болон 5 км радиуст амьдрах орчны олон янз байдлыг харгалзан гүйцэтгэнэ)	- С. Шар - Д. Өсөхжаргал - С. Лхам	- Судалгааны арга зүй, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хаврын хээрийн судалгааг чанартай гүйцэтгэж, шинжлэх ухааны үндэслэлтэй өгөгдөл цуглуулсан байна. - Судалгааны талбай болон түүний ойролцоо хавар тохиолдох амьтдын ажиглалт хийж, бүртгэсэн байна. - Жижиг хөхтөн амьтдын зүйлийн бүрдэл, тоо толгой, нягтшил, тохиолдоцыг тогтооно.
7	Зуны судалгаа	2022.07.17-2022.07.31 (10 хоног)	- Аэродромын талбай болон түүний орчим зуны улиралд тохиолдох жижиг хөхтөн амьтдын судалгаа (аэродромын талбай дотор болон 5 км радиуст амьдрах орчны олон янз байдлыг харгалзан гүйцэтгэнэ)	- С. Шар - Д. Өсөхжаргал - С. Лхам	- Судалгааны талбайд зуны хээрийн судалгааг чанартай гүйцэтгэж, шинжлэх ухааны үндэслэлтэй өгөгдөл цуглуулсан байна. - Жижиг хөхтөн амьтдын зүйлийн бүрдэл, тоо толгой, нягтшил, тохиолдоцыг тогтооно.
8	Намрын судалгаа	2022.09.05-2022.09.26 (10 хоног)	- Аэродромын талбай болон түүний орчим зуны улиралд тохиолдох жижиг хөхтөн амьтдын судалгаа (аэродромын талбай дотор болон 5 км радиуст амьдрах орчны олон янз байдлыг харгалзан гүйцэтгэнэ)	- С. Шар - Д. Өсөхжаргал - С. Лхам	- Судалгааны арга зүй, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу намрын хээрийн судалгааг чанартай гүйцэтгэж, шинжлэх ухааны үндэслэлтэй өгөгдөл цуглуулсан байна. - Жижиг хөхтөн амьтдын зүйлийн бүрдэл, тоо толгой, нягтшил, тохиолдоцыг тогтооно.

3. Судалгааны өгөгдөл боловсруулах, тайлан бичих

№	Зорилт ба гүйцэтгэх судалгаа	Хэзрийн судалгаа гүйцэтгэх огноо (хугацаа)	Гүйцэтгэх ажил	Хариуцах эзэн ба оролцогчид	Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт
1	Эхлэлийн тайлан	2021.11.....-2021.12.01 (25 хоног)	- Хэзрийн судалгаа гүйцэтгэх арга зүй, төлөвлөгөө, багийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх ажлын талаарх эхлэлийн тайлан бичих.	- С. Гомбобаатар - Ж. Мөнх-Эрдэнэ	- Эхлэлийн тайланг гэрээний дагуу захиалагч талд хүргүүлсэн байна.
2	Явцын тайлан	2022.02.01-2022.03.01 (30 хоног)	- Өвлийн судалгааны үр дүнг боловсруулж, явцын тайлан бичих.	- Ж. Мөнх-Эрдэнэ - П. Даваасүрэн - С. Шар	- Өвлийн судалгааны үр дүнг боловсруулж, захиалагч талд явцын тайланг гэрээний дагуу тайлагнасан байна.
3	Эцсийн тайлан	2022.10.01-2022.11.01 (30 хоног)	- Судалгааны өгөгдөл боловсруулах, нэг жилийн мониторинг судалгааны үр дүнгээр эцсийн тайлан бичих, шувуунаас сэргийлэх төлөвлөгөө боловсруулах, захиалагч талд хүргүүлэх.	- С. Гомбобаатар - Ж. Мөнх-Эрдэнэ - С. Шар - Судлаачид	- Хэзрийн судалгааны үр дүнг сайтар боловсруулж, захиалагч талд ажлын даалгавар, гэрээний дагуу тайлагнасан байна.

БАТЛАВ:

"МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ"-ИЙН ЗАХИРАЛ

.....

Д. ЗАЯАБААТАР

БАТЛАВ:

"НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ ХХК "- ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

КАТО ТАКЕО

ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН ШИНЭ НИСЭХ БУУДАЛ ОРЧМЫН ШУВУУ, ХӨХТӨН АМЬТДЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН



©МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж-3,
МУИС-ийн хичээлийн II байр 121 тоот
Утас: 98092223; 98100148
И-мэйл: munkherdene.mos@gmail.com

УЛААНБААТАР 2022

ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН ШИНЭ НИСЭХ БУУДАЛ ОРЧМЫН ШУВУУ, ХӨХТӨН АМЬТДЫН СУДАЛГААНЫ ЯВЦЫН ТАЙЛАН

Гэрээний дугаар:
2021 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн 269/21

Хээрийн судалгаа гүйцэтгэсэн хугацаа:
2021 оны 12, 2022 оны 1-12-р сар

Судалгааг захиалж, санхүүжүүлсэн:
Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК

Гүйцэтгэсэн:
Монгол Улсын Их Сургууль,

Судалгаанд оролцож, хамтран ажилласан:
Монгол Шувуу Судлалын Нийгэмлэг
Монголика Консалтинг

Тайлан бичсэн:
магистр Ж.Мөнх-Эрдэнэ, магистр П.Даваасүрэн

Тайланг хянасан:
Доктор, проф. С.Гомбобаатар

Зохиогчийн эрх:
Энэхүү тайлангийн зохиогчийн эрх нь Монгол Улсын Их Сургууль©, Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК ©-т хадгалагдана. Уг төлөвлөгөөнд дурдсан үг, өгүүлбэр, гэрэл зураг, үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг зөвшөөрөлгүй хувилан олшруулах, тараах, аливаа бүтээлд ашиглахыг хориглох бөгөөд цаашид ашиглах асуудлыг зохиогчийн эрх бүхий байгууллагууд шийдвэрлэнэ.

АГУУЛГА

УДИРТГАЛ 4
ЗОРИЛГО 5
Зорилт: 5
СУДАЛГААНЫ ТАЛБАЙН ОНЦЛОГ 6
Уур амьсгал 6
Гадаргын ус 7
Ургамалжилт 7
Амьтны аймаг 8
АРГА ЗҮЙ, МАТЕРИАЛ 9
Харууц сайтай цэгээс ажиглах: 9
Шугаман замнал: 11
Багийн бүрэлдэхүүн, хугацаа 13
СУДАЛГААНЫ ҮР ДҮН 14
Шувуу 14
Зүйлийн бүрдэл 14
Тохиолдоц ба давтамж 20
Шувуудын агаарын хөлөгтэй мөргөлдөх эрсдэлийн үнэлгээ 21
Хөхтөн 26
ИШ ТАТСАН БҮТЭЭЛ 29
ХАВСРАЛТ ..... **Error! Bookmark not defined.**
Хавсралт 1. Чингис хаан нисэх буудалд цэгэн ажиглалтын аргаар судалгаа гүйцэтгэсэн огноо, хугацаа ..... **Error! Bookmark not defined.**

УДИРТГАЛ

Монгол улсад агаарын тээврийн салбар үүсэж хөгжөөд 96 дахь жилтэйгээ золгож байна. Агаарын хөлгийн нислэгийн аюулгүй ажиллагаа нь нисэх буудал буюу аэродромын хангалт, үйлчилгээтэй салшгүй холбоотой. Аэродром гэдэг нь агаарын хөлгийн хөөрөх, буух, зогсоход зориулан барьсан хуурай газар, усан гадаргуун цогцолбор байгууламж юм.

Агаарын хөлгийн нислэгийн үед гарсан зөрчлүүд нь хүний буруутай үйл ажиллагаанаас гадна цаг агаарын тааламжгүй үзэгдэл, агаарын хөлгийн техникийн дутагдал, гадны биет, гал түймэр, хөхтөн амьтад, шувууны мөргөлт гэх мэт олон аюултай хүчин зүйлээс шалтгаалсан байдаг. Эдгээрээс агаарын хөлөг шувуутай мөргөлдсөн тохиолдлын тоо дээгүүр байр суурь эзэлдэг ба Европын Нислэгийн Аюулгүй Ажиллагааны Агентлагаас хийсэн 2011-2015 оны зөрчлийн судалгааны үр дүнгээс харахад хамгийн өндөр хувийг эзэлсэн байна (Annual safety review, 2016). Шувууны мөргөлтөөс шалтгаалж нислэг саатах, систем гэмтэх, хэвийн бус газардах, гал түймэр гарах, сүйрэх гэх мэт үр дагаврууд гарч болзошгүй.

Манай орны хувьд сүүлийн жилүүдэд нислэгийн давтамж, тоо харьцангуй нэмэгдсэнтэй холбоотойгоор шувуутай мөргөлдөх зөрчлийн тоо хэмжээ ихсэх хандлагатай байна (Юмжирмаа, 2017). Шувуу агаарын хөлөгтэй мөргөлдсөнөөр өөрөө эндэж, агаарын хөлөгт тодорхой хэмжээний гэмтэл учруулдаг бөгөөд гэмтэл нь шувууны биеийн жин, тоо толгой болон мөргөсөн эд анги, агаарын хөлгийн хурднаас ихээхэн хамаарна (Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр, 2016).

Иймд нисэх буудал орчим тохиолдох шувуудын тохиолдоц, тоо толгой, идэвхжил, зан төрх, нисэх өндөр, нисэн өнгөрөх хугацаа, нүүдлийн зам, хугацаа зэрэг мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэй нарийвчлан судалж, эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагатай (Юмжирмаа, 2017).

Бид хээрийн судалгааг хавар, намрын нүүдэл, үржлийн болон өвөлжиж буй үеийг хамруулан гүйцэтгэж, ажлын даалгавар, гэрээний дагуу өгөгдлийг боловсруулж байна.

ЗОРИЛГО

Энэхүү судалгаа нь Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын орчимд хавар, намрын нүүдэл, үржлийн болон өвөлжиж буй үеийг хамруулан шувуудын болон хөхтөн амьтдын мониторинг судалгаа гүйцэтгэх, зүйлийн бүрдэл, тоо толгой, тархалт, шилжилт хөдөлгөөнийг судлан тогтоох, агаарын хөлөгтэй мөргөлдөх өндөр эрсдэлтэй зүйлийг тодорхойлох, тэдгээрийн шалтгаан, агаарын хөлөгт аюул учруулах эрсдэлийг тодорхойлох, аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар зөвлөмж гаргах үндсэн зорилготой. Бид энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавин ажиллана.


Зорилт:

- Судалгааны талбай, түүний орчимд тохиолдох боломжтой шувуудын талаарх урьд хэвлэгдсэн бүтээлүүдийг шүүх, эмхэтгэх, урьдчилсан жагсаалт үүсгэх,
- Хээрийн судалгаанд ашиглах шаардлагатай багаж, төхөөрөмжийг бэлтгэх, багийн гишүүдийг томилох, ажлын даалгаврын шаардлагад нийцүүлж үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө, арга зүй болон хөдөлмөр хамгааллын заавар боловсруулах,
- Судалгааны батлагдсан арга зүй, үйл ажиллагааны төлөвлөгөөг чанд баримтлан шувууны хээрийн судалгааг буудал орчмын 15 км радиус, хөхтөн амьтдын судалгааг 5 км радиус талбайг хамруулан хийж гүйцэтгэх,
- Судалгааны талбайн хүрээнд шувуудын зүйлийн бүрдлийг цэгэн ажиглалтын болон шугаман замнал (line transect)-ын аргаар тогтоож, зүйл тус бүрийн тархалт, тоо толгойн нягтшил (бодгаль/км2), идэвхжилийн цаг хугацаа, зан төрх, нүүдэл, шилжилтийн зам, нисэлтийн өндөр (газрын гадаргаас дээших өндөр, м) зэргийг тодорхойлох, анализ хийх,
- Шувуу, зэрлэг амьтдын агаарын хөлөгт аюул учруулах эрсдэлийг олон улсад түгээмэл хэрэглэгддэг David C. Paton "Bird risk assessment model for airports and aerodromes" (2009) болон Документ 9137-3 (2020)-т заасан арга аргачлалын дагуу үнэлэх, улмаар эрсдэлтэй шувуудыг илрүүлэх, эрэмбэлэх,
- Аюулын өндөр эрсдэлтэй шувууд болон тэдгээрийн судалгааны талбайн (аэродром орчим) хүрээн дэх үүрний байршил, олон давтамжтай тохиолдох байршил, нислэгийн замнал, улирал, цаг хугацааны хамаарал, нисэх өндрийн мэдээллийг ялган тодорхойлох,
- Ажиглалтын мэдээлэлд үндэслэн тухайн нисэх буудлаар дайран өнгөрөх шувуудын нүүдлийн гол замын чиглэл, тохиолдох давтамжийг харуулсан зураглалыг ArcGis программ ашиглан гаргах,
- Судалгааны талбайн хүрээнд ялангуяа аэродромын талбайн хүрээнд тохиолдох мэрэгч амьтдын зүйлийн бүрдэл, тархалт, тоо толгойн судалгаа хийх,
- Эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар авах менежментийн төлөвлөгөө, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

СУДАЛГААНЫ ТАЛБАЙН ОНЦЛОГ

Бид Улаанбаатар хотын төвөөс баруун урагш 194^0-т, агаарын шугамаар 30 км, авто замаар 50 км алсад орших Чингис хаан нисэх буудалд төвтэй 15 км радиустай тойрог талбайд шувуу, зэрлэг амьтны судалгааг хийж гүйцэтгэлээ (газрын зураг 1). Нисэх буудлын талбай орчимд хуурай хээр, уулын хээр, ойт хээр, хад хадан цохио бүхий чулуурхаг уулс, уулс хоорондын хөндий, ус намгархаг голын хөндий, жижиг нуур, Бөхөгийн гол зэрэг амьдрах орчны олон янз ихтэй.

Газрын зураг 1. Судалгааны талбай



Уур амьсгал

Чингис хаан нисэх буудал нь Монгол орны төв хэсэгт ойт хээрийн бүсэд орших эрс тэс уур амьсгалтай, өргөн хөндий бүхий газар юм. Уур амьсгалын зэрэглэлээр хуурайдуу мужид байрших учраас өвөл хүйтэн, зун халуун байдаг онцлогтой. Жилийн хамгийн дулаан 7-р сард агаарын дундаж температур Зуунмод, Сэргэлэн, Алтанбулагт +15-20^{0}C, хамгийн хүйтэн 1-р сарын агаарын дундаж температур -19.9—26.6^{0}C хооронд хэлбэлзэнэ. Агаарын жилийн дундаж температур -1.6^{0}C, салхины жилийн дундаж хурд 3.1 м/сек байна. Хөшигийн хөндий орчимд дунджаар

248.5 мм хур тунадас унадаг ба дийлэнх (235.2мм) нь дулаан улиралд (11-3-р сард) орно. Өвлийн улиралд уулархаг газар нутгийн хөндийд хүйтэн агаар хуралдаж тогтон, харьцангуй хүйтэн өвөл болдог бөгөөд -35.7^{0}C хүрч хүйтэрнэ.

Гадаргын ус

Хэнтийн нурууны баруун өмнөд салбар уулс, Богд хан уулын өмнө сугаас эх аван урсах Зуунмодны гол Баясгалант уулын орчимд Бөхөгийн гол нэртэй болж, цааш урсан Туул голд цутгадаг. Зуунмодны голын сав газрын эх ой модтой, голын хөндий эхэндээ 100-250 м өргөн, голдирлын тахиржилт харьцангуй бага, хөндий уужим болж голын тахиржилт ихсэхийн хирээр үндсэн голдирлоосоо 200-250 м хүртэл холдох салаа татуурга үүсгэх ба адагтаа нарийсдаг (зураг 1).

Зураг 1. Бөхөгийн гол ба нуурын хөндий





Ургамалжилт

Хөшигийн хөндий ургамал газарзүйн мужлалын хувьд А.А.Юнатовын (1950) ангиллаар Төв Хэнтийн уул тайга ба Хэнтийн өмнөд хэсгийн уулын хээрийн тойргуудын зааг нутагт байрлана. Геоботаникийн мужлалыг В.И.Грубов (1962), Н.Өлзийхутаг (1989) нар ургамал газарзүйн 16 тойрогт хуваахдаа Хөшигийн хөндийг Монгол-дагуурын уулын ойт хээрийн тойрогт хамруулжээ. Хэнтийн ойн урд төгсгөл, тал хээрийн хойд захтай нийлэх, мөн уулын хээр, хуурай хээрийн уулзвар учраас ургамлын нөмрөгийн хувьд нэлээд өвөрмөц онцлогтой. Тус нутагт адамсын шарилж (*Artemisia Adamsii*), имт гичгэнэ (*Potentilla bifurca*), ширэг улалж (*Carex duriuscula*), өлчир агь (*Artemisia frigrida*) зэрэг зүйл ургамлын зэрэгцээ мэрэгч амьтдын амьдралын ул мөрийг илэрхийлэгч, нүх, үлий орчимд ургадаг үсхий нохойн хэл (*Panzeria lanata*), жижиг навчит харгана (*Caragana microphylla*), доройтсон буюу мал

байнга бэлчдэг нутагт зонхилон ургадаг нангиад цагаан суль (*Leymus clunensis*) зэрэг ургамал зонхилно (Мөнх-Эрдэнэ нар 2020).

Амьтны аймаг

Тус нисэх буудал нь А. Г. Банников (1954)-ын Монгол орны амьтны аймгийн мужлалаар Монгол дагуурын хээр, Хэнтийн нурууны тойргийн хилийн зааг бүхий нутагт байрлана (Цэгмид, 1969). Чингис хаан нисэх буудал, түүний ойр орчимд 6 баг 13 овгийн 22 зүйл хөхтөн амьтан тэмдэглэгджээ. Үүнээс хамгаалалтын талбай орчим болон ойролцоох нутгаар улийн цагаан оготно, хярс, дагуур огдой, бор туулай түгээмэл тохиолдоно. Мэрэгч амьтдаар хооллодог үнэг, хярс, мануул, хотны үен, хээрийн солонго, өмхий хүрэн зэрэг мах идэшт амьтад идэш тэжээл даган байршина. Мөн өвлийн улиралд цагаан зээр цөөн тоогоор орж ирнэ (Мөнх-Эрдэнэ нар 2020).

АРГА ЗҮЙ, МАТЕРИАЛ

Хээрийн судалгаа гүйцэтгэх болон ажиглалтын цэгийг сонгохдоо ажлын даалгавар, тухайн нисэх буудлын холбогдох албаны хүмүүстэй санал солилцож, тэдгээрийн санал, хүсэлтийг тусган ажиллав. Хээрийн мониторинг судалгааг харууц сайтай цэгээс ажиглах (vantage point) болон шугаман замналын арга зүйн дагуу гүйцэтгэлээ (Scottish Natural Heritage, 2014l; Krebs, 2013).

Харууц сайтай цэгээс ажиглах:


Хээрийн судалгаанд манай оронд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, түгээмэл ашигладаг харууц сайтай цэгээс ажиглах (vantage point) аргыг ашиглав (Scottish Natural Heritage, 2014). Аэродромын талбайд 3 км радиус бүхий 2 цэг, онгоц буух, хөөрөх зурвасын дагуу хоёр тийшээ 15 км хүртэлх зайд мөн ижил радиус бүхий тус бүр 2 буюу нийт 4 цэг, нисэх буудлын хойно, урд талд 2 цэг буюу нийт 8 цэгийг сонгож ажиглалт судалгааг хийн, тохиолдсон бүх шувуу, амьтдыг бүртгэв. (хүснэгт 1; газрын зураг 2; хавсралт 1).

Ажиглалтыг өглөө нар мандахаас жаргах хүртэлх хугацаанд буюу өглөө, өдөр, оройн цагаар гүйцэтгэсэн. Нэг цэг дээр тасралтгүй 3 цаг ажиглаж дараагийн цэг дээрээс үргэлжлүүлсэн. Ажиглалтын цэгээс шувуудын нисэж буй зай, өндрийг зөв тодорхойлоход судлаачдын туршлага маш чухал үүрэгтэй. Ажиглагчаас амьтан хүртэлх зайг зай хэмжигч (range finder) багажаар, харин амьтан буй байршлын өнцгийг луужин ашиглаж бүртгэв. Үүнээс гадна судалгааны талбайд буй ногооны талбай, хашаа, өндөр хүчдэлийн шугам, айлын гэр, байшин, нисэх буудлын байгууламж, худаг гэх мэт хөдөлгөөнгүй объектуудын байршил, тэдгээрийн хоорондын болон ажиглалтын цэг хүртэлх зай зэргийг газарзүйн байршил тодорхойлогч (GPS) болон сансрын зураг (google earth) ашиглан урьдчилан тодорхойлсон ба үүнийг шувуудын шилжилтийн зайг тодорхойлоход ашиглав. Нисэж буй өндрийг өндөр хэмжих багаж, эсвэл байгалийн болон хиймэл объектын өндөртэй харьцуулан тодорхойлов.

Хүснэгт 1. Ажиглалтын цэгийн солбицол, ажигласан хугацаа.

№	Цэгэн ажиглалтын дугаар	Солбицол		Тайлбар
		N	E	
1	VPH1	47.652740°	106.802690°	Нисэх буудлын аэродромын талбай
2	VPH2	47.642550°	106.838590°	Нисэх буудлын аэродромын талбай
3	VPH3	47.662160°	106.821210°	Нисэх буудлын хойд талд
4	VPH4	47.647190°	106.901160°	Хөөрч, буух зурвасын дагуу
5	VPH5	47.633050°	106.975980°	Хөөрч, буух зурвасын дагуу
6	VPH6	47.615889°	106.820750°	Нисэх буудлын урд талд
7	VPH7	47.656499°	106.782936°	Хөөрч, буух зурвасын дагуу
8	VPH8	47.656990°	106.705510°	Хөөрч, буух зурвасын дагуу
9	VPH9	47.633230°	106.760963°	Нуурын ойролцоох цэг. Хавар, намрын нүүдлийн үед ажиглалт хийнэ.

Газрын зураг 2. Судалгааны талбай, ажиглалтын цэгүүдийн байршил.



295

Шугаман замнал: Нисэх буудлын аэродромын талбайгаас 15 км радиуст байршиж буй шувуу, хөхтөн амьтдын зүйлийн бүрдэл, тохиолдцыг тодорхойлохын тулд шугаман замналын арга (Krebs, 2013) -ыг ашиглав. Судалгааны талбайг бүрэн хамруулах боломж, амьдрах орчны олон янз байдал зэргийг харгалзан нийт 376.18 км урттай замналын аргаар судалгаа гүйцэтгэж өгөгдөл цуглууллаа (газрын зураг 3). Замналыг 20 км/цаг-аас илүүгүй хурдтай машинаар болон явганаар явж амьтдын байршил, зүйлийн нэр, тоо толгой, ажиглагдсан зай, өнцөг зэрэг мэдээллийг нэг бүрчлэн тусгайлан бэлтгэсэн хүснэгтийн дагуу тэмдэглэв. Туулсан замыг хэмжихдээ машины зай хэмжигчийн заалт болон GPS багаж ашигласан.


Тохиолдсон бүх амьтдыг бүртгэсэн ба хээрийн нөхцөлд танихад хүндрэлтэй зүйлүүдийн гэрэл зургийг авч тодорхойлох бичиг, гарын авлага (Brazil, 2009; Svensson et al., 2010; Gombobaatar et al., 2011; Gombobaatar and Christopher, 2019; Гомбобаатар нар, 2020) ашиглан тодорхойллоо. Баг, овог, төрөл, зүйлийн ангилал зүйн дараалал, нэрсийг "Biodiversity of Mongolia: names, distribution and identification of vertebrate species" (Gombobaatar, 2019) -ийг тулгуур бүтээл болгож ашиглав. Зүйлийн Монгол нэрийг Монгол орны Биологийн олон янз байдлын ангилал зүйн зөвлөлийн 2019 онд шинэчлэн найруулснаар оноов.

Хээрийн судалгаанд телескоп (Vortex, Lieca), хөл, 8x42 дуран (Swarovski, Eagle Optics), GPS (Garmin), луужин, зай хэмжигч (Bushnell, Uni-T), Nikon D7100 камер 150-600 мм-ийн дуран зэрэг багаж төхөөрөмжийг ашиглалаа.

Зураг 2. Судалгаанд ашигласан зарим багажууд.



Газрын зураг 3. Судалгааны талбай, шугаман замналын маршрут.



Багийн бүрэлдэхүүн, хугацаа

Төслийн баг Монгол орны шувуу, хөхтөн амьтдын биологи, экологийн судалгаа, өндөр хүчдэл, сэргээгдэх эрчим хүч (салхин сэнс), шувууд агаарын хөлөгт үзүүлэх нөлөөллийн судалгааны чиглэлээр олон жил ажилласан туршлагатай, мэргэжлийн судлаачдаас бүрдсэн баг ажиллаж байна (хүснэгт 2).

Бид Чингис хаан нисэх буудал орчмын хээрийн мониторинг судалгааг өвлийн улиралд 2021 оны 12-р сар, 2022 оны 1, 2-р сард тус тус гүйцэтгэсэн бөгөөд дараах бүрэлдэхүүнтэй ажиллав (зураг 1, хавсралт 1). Судалгаа гүйцэтгэсэн огноо, хугацааны дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү.

Хүснэгт 2. Төслийн багийн бүрэлдэхүүн.

	Нэр	Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв	Ажлын туршлага /жилээр/	Хариуцсан ажил
1	Доктор, проф. С.Гомбобаатар	Монгол орны төвийн бүсийн идлэг шонхор (*Falco cherrug milvipes*)-ын биологи, экологи ба хамгаалал	Амьтан судлал, шувуу судлалын чиглэлээр 29 жил	Зөвлөх, Шувуу, хөхтний судалгаа
2	Доктор, дэд проф. С.Шар		Амьтан судлал, хөхтөн судлалын чиглэлээр 40 жил	Зөвлөх, Хөхтний судалгаа
3	Магистр Ж.Мөнх- Эрдэнэ	Цэций уулын салхин сэнснээс шувуудад үзүүлэх нөлөө, шийдвэрлэх арга зам	Амьтан судлал, шувуу судлалын чиглэлээр 12 жил	Төслийн удирдагч, шувуу, хөхтний судалгаа
4	Магистр П.Даваасүрэн	Салхит уулын салхин сэнснээс Тарважи бүргэд (*Aquila nipalensis*)-д үзүүлэх нөлөө, хамгаалах арга зам	Амьтан судлал, шувуу судлалын чиглэлээр 6 жил	Шувуу, хөхтний судалгаа
5	Магистр Б.Юмжирмаа	Чингис хаан олон улсын нисэх буудал орчмын шувууд, тэдгээрийн агаарын хөлөгт учруулах эрсдэлийн судалгаа	Шувуу судлалын чиглэлээр 10 жил	Шувуу, хөхтний судалгаа
6	Судлаач Б.Цэвээнпүрэв	-	Амьтан судлал, Шувуу судлалын чиглэлээр 8 жил	Шувуу, хөхтний судалгаа
7	Б.Хулан	-	МУИС, Биологийн тэнхим 4-р дамжааны оюутан	Шувуу, хөхтний судалгаа
8	О.Энхжин	-	МУИС, Биологийн тэнхим 3-р дамжааны оюутан	Шувуу, хөхтний судалгаа
9	Жолооч Н.Уганбат	-	Мэргэшсэн жолооч, 25 жил	Жолооч

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шувуу

Зүйлийн бүрдэл

Нисэх буудлын талбай болон түүний орчим дахь хад чулуурхаг болон нүцгэн уулс, хадан цохио гуу жалга, суурин газар, харгана, бутлаг ургамал бүхий хөндий, хээр, уулын хээр, ус намгархаг жижиг нуур, голын хөндий зэрэг ялгаатай амьдрах орчинд 126 зүйл шувуу тэмдэглэв (хүснэгт 3).

Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан дансны шалгууруар Олон улсад "Устаж болзошгүй" зэрэглэлтэй идлэг шонхор, "Ховордож болзошгүй" зэрэглэлтэй нөмрөг тас; бүс нутаг (Монгол орны)-ийн хэмжээнд "Эмзэг" зэрэглэлтэй идлэг шонхор тус тус бүртгэгджээ (зураг 3, хүснэгт 3). Мөн САЙТИС-ын конвенцийн 2-р хавсралт (CITES)-д 6 зүйл, Зэрлэг амьтны нүүдлийн зүйлийг хамгаалах тухай Конвенц (CMS)-ийн 1,2-р хавсралтад 6 зүйл шувуу тэмдэглэгдсэн (Gombobaatar and Monks, 2011; Монгол улсын Улаан ном, 2016; Гомбобаатар ба Төвшин, 2019) (хүснэгт 3).

Зураг 3. Судалгааны талбайд тохиолдох ховордлын зэрэглэлтэй шувууд.



Идлэг шонхор



Нөмрөг тас

Хүснэгт 3. Чингис хаан нисэх буудал орчимд тохиолдох шувуудын зүйлийн жагсаалт, экологийн статус, хамгаалал .

No	Шинжлэх ухааны нэр	Монгол нэр	Англи нэр	Хөшигт хэрийн судалгаа 2021-2022	Мөнх-Эрдэнэ нар, 2020	Гомбобаатар нар, 2017	Нисэх буудал орчим дахь экологийн статус	Бүс нутгийн статус	Олон улсын статус	Монгол улсын улаан ном, 2016	CITES-ийн 1, 2-р хавсралт	CMS-ийн 1, 2-р хавсралт
1	*Acanthis flammea*	Дөлөн цэгцүүхэй	Redpoll		+		ӨО	LC	LC			
2	*Accipiter gentilis*	Үлэг харцага	Northern Goshawk		+	+	ДӨ	LC	LC		II	
3	*Accipiter nisus*	Морин харцага	Eurasian Sparrowhawk		+	+*	ДӨ	LC	LC		II	
4	*Actitis hypoleucos*	Хайргын хөгчүү	Common Sandpiper	+	+		BV	LC	LC			II
5	*Aegypius monachus*	Нөмрөг тас	Cinereous Vulture	+	+	+	СӨ	LC	NT		II	II
6	*Aix galericulata*	Мандир үранхажин	Mandarin Duck	+			SV	NA	LC			
7	*Alauda arvensis*	Боролзой болжмор	Eurasian Skylark	+	+	+	НӨ	LC	LC			
8	*Anas acuta*	Шовтгор алаг нугас	Northern Pintail	+			BV	LC	LC			II
9	*Anas crecca*	Ногоохон нугас	Eurasian Teal	+	+	+*	ДӨ	LC	LC			II
10	*Anas platyrhynchos*	Зэрлэг нугас	Mallard	+	+	+*	ДӨ	LC	LC			II
11	*Anthropoides virgo*	Өвөгт тогоруу	Demoiselle Crane	+	+	+*	НӨ	LC	LC		II	II
12	*Anthus godlewskii*	Годлевскийн шийхнүүхэй	Blyth's Pipit	+	+*	+*	BV	LC	LC			
13	*Anthus hodgsoni*	Бөртөт шийхнүүхэй	Olive-backed Pipit	+			BV	LC	LC			
14	*Anthus richardi*	Хээрийн шийхнүүхэй	Richard's Pipit	+	+*	+*	НӨ	LC	LC			
15	*Anthus spinoletta*	Харзны шийхнүүхэй	Water Pipit	+			BV	LC	LC			
16	*Antigone vipio*	Цэн тогоруу	White-naped Crane	+			BV	VU	VU	+	I	I,II
17	*Apus apus*	Хурын ураацай	Common Swift	+	+	*	НӨ	LC	LC			
18	*Apus pacificus*	Хондлой цагаан ураацай	Pacific Swift		+*	+*	НӨ	LC	LC			
19	*Aquila chrysaetos*	Цармын бүргэд	Golden Eagle	+	+	+	СӨ	LC	LC		II	II

20	*Aquila nipalensis*	Тарважи бүргэд	Steppe Eagle	+	+	+	НӨ	LC	EN		II	I, II
21	*Ardea cinerea*	Хөх дэглий	Grey Heron	+			BV	LC	LC			
22	*Athene noctua*	Хотны бүргэхэй	Little Owl	+	+*	+*	СӨ	LC	LC		II	
23	*Aythya ferina*	Улаан хүзүүт шүмбүүр	Common Pochard	+			BV	LC	VU			II
24	*Bubo bubo*	Эгэл шаршувуу	Eurasian Eagle-Owl		+*	+*	RB	LC	LC		II	
25	*Buteo buteo*	Ойн сар	Common Buzzard	+			BV	LC	LC		II	
26	*Buteo hemilasius*	Шилийн сар	Upland Buzzard	+	+	+	СӨ	LC	LC		II	II
27	*Buteo japonicus*	Дорнын сар	Eastern Buzzard	+	+		BV	LC	LC			II
28	*Buteo lagopus*	Тарлан сар	Rough-legged Buzzard	+	+	+*	ӨО	LC	LC		II	II
29	*Calandrella cheleensis*	Дэрсний жиргэмэл	Asian Short-toed Lark	+	+	+	НӨ	LC	LC			
30	*Calcarius lapponicus*	Бүүлгат хөмрөг	Lapland Longspur		+*	+*	ӨО	LC	LC			
31	*Calidris alpina*	Хар элсэг	Dunlin		+*	+*	РМ	LC	LC			II
32	*Calidris ferruginea*	Хадуур элсэг	Curlew Sandpiper		+*	+*	РМ	LC	NT			II
33	*Calidris minuta*	Одой элсэг	Little Stint	+			РМ	LC	LC			II
34	*Calidris ruficollis*	Шартүрүүт элсэг	Red-necked Stint	+	+*	+*	РМ	LC	NT			
35	*Calidris subminuta*	Савар элсэг	Long-toed Stint		+*	+*	РМ	LC	LC			
36	*Calidris temminckii*	Темминкийн элсэг	Temminck's Stint	+	+*	+*	РМ	LC	LC			II
37	*Calliope calliope*	Өнгөлүүрт гургалдай	Siberian Rubythroat	+			BV,PM	LC	LC			
38	*Charadrius dubius*	Нарийн хиазат	Little Ringed Plover	+	+	+*	ДӨ	LC	LC			II
39	*Chroicocephalus ridibundus*	Хүрэн толгойт цахлай	Black-headed Gull	+	+*	+*	ДӨ	LC	LC			
40	*Circus cyaneus*	Саарал хулд	Hen Harrier	+	+		BV	LC	LC		II	II
41	*Circus spilonotus*	Дорнын хулд	Eastern Marsh Harrier	+			B,M	LC	LC		II	
42	*Clanga clanga*	Бор бүргэд	Greater Spotted Eagle	+			RBV,PM	E	VU	+	II	I,II
43	*Columba livia*	Хөхвөр таггаа	Rock Dove	+	+	+	RB	LC	LC			
44	*Columba rupestris*	Хадны таггаа	Hill Pigeon		+*	+*	RB	LC	LC			
45	*Corvus corax*	Хон хэрээ	Northern Raven	+	+	+	RB	LC	LC			
46	*Corvus corone*	Хар хэрээ	Carrion Crow	+	+	+	RB	LC	LC			

47	*Corvus dauuricus*	Алагтуу хэрээ	Daurian Jackdaw	+	+		НӨ	LC	LC			
48	*Corvus frugilegus*	Турлиах хэрээ	Rook	+	+	+	НӨ	LC	LC			
49	*Coturnix japonica*	Наран бөднө	Japanese Quail	+			BV	LC	NT			
50	*Cuculus canorus*	Эгэл хөхөө	Common Cuckoo		+*	+*	BV	LC	LC			
51	*Cygnus cygnus*	Гангар хун	Whooper Swan		+	+	ДӨ	LC	LC			II
52	*Emberiza cioides*	Хүрэн чихт хөмрөг	Meadow Bunting		+		RB	LC	LC			
53	*Emberiza fucata*	Шархөмсөгт хөмрөг	Chestnut-eared Bunting			+*	BV	LC	LC			
54	*Emberiza leucocephalos*	Цагаан шанаат хөмрөг	Pine Bunting	+			BV,PM	LC	LC			
55	*Emberiza pallasi*	Цагаан хэвэлт хөмрөг	Pallas's Bunting	+			BV	LC	LC			
56	*Emberiza pusilla*	Борлог хөмрөг	Little Bunting	+	+	+*	ДӨ	LC	LC			
57	*Emberiza schoeniclus*	Цагаан хүзүүт хөмрөг	Reed Bunting	+			BV	LC	LC			
58	*Emberiza spodocephala*	Хөх түрүүт хөмрөг	Black-faced Bunting	+			BV,PM	LC	LC			
59	*Eremophila alpestris*	Эвэрт болжмор	Horned Lark	+	+	+	RB	LC	LC			
60	*Falco cherrug*	Идлэг шонхор	Saker Falcon	+	+	+	RB	Э	EN		II	I, II
61	*Falco naumanni*	Зээрд шонхор	Lesser Kestrel		+		BV	LC	LC		II	I,II
62	*Falco subbuteo*	Шууман шонхор	Eurasian Hobby		+	+*	BV	LC	LC		II	II
63	*Falco tinnunculus*	Начин шонхор	Common Kestrel	+	+	+	RB	LC	LC		II	II
64	*Ficedula albicilla*	Хурган намнаа	Taiga Flycatcher	+			НӨ	LC	LC			
65	*Fringilla coelebs*	Дуулгат бужирга	Common Chaffinch	+			BV,PM	LC	LC			
66	*Fringilla montifringilla*	Алаг бужирга	Brambling	+			BV,PM	LC	LC			
67	*Gallinago gallinago*	Шөвгөн хараалж	Common Snipe	+	+	+*	ДӨ	LC	LC			II
68	*Gelochelidon nilotica*	Бахим хараалай	Gull-billed Tern	+			BV	LC	LC			II
69	*Geokichla sibirica*	Шивэр хөөндэй	Siberian Thrush	+			BV	LC	LC			
70	*Grus grus*	Хархираа тогоруу	Common Crane	+			BV	NT	LC	+	II	II
71	*Hieraaetus pennatus*	Бахим бүргэд	Booted Eagle	+	+*	+*	ДӨ	LC	LC			II
72	*Himantopus himantopus*	Эгэл хилэнжигүүр	Black-winged Stilt		+*	+*	BV	LC	LC			II

302

73	*Hirundo rustica*	Асрын хараацай	Barn Swallow	+	+*	+*	НӨ	LC	LC			
74	*Lanius borealis*	Умардын дунхай	Northern Shrike	+			RB	LC	LC			
75	*Lanius cristatus*	Ухаа дунхай	Brown Shrike	+			НӨ	LC	LC			
76	*Lanius sphenocercus*	Хүл дунхай	Chinese Grey Shrike	+			BV	DD	LC			
77	*Larus mongolicus*	Монгол цахлай	Mongolian Gull	+	+	+	ДӨ	LC	LC			
78	*Limosa limosa*	Морин цууцал	Black-tailed Godwit		+*	+*	ДӨ	LC	NT			II
79	*Linaria flavirostris*	Бор цэгцүүхэй	Twite		+		RB	LC	LC			
80	*Mareca falcata*	Гэзэгт нугас	Falcated Duck	+			RBV	NT	NT	+		
81	*Mareca penelope*	Зээрт нугас	Euraslan Wigeon	+			BV	LC	LC			II
82	*Mareca strepera*	Бор нугас	Gadwall	+	+*	+*	ДӨ	LC	LC			II
83	*Melanocorypha mongolica*	Монгол болжмор	Mongolian Lark	+	+	+	RB	LC	LC			
84	*Milvus migrans*	Сохор элээ		+	+	+	НӨ	LC	LC		II	II
85	*Monticola solitarius*	Цэнхэр жижир	Blue Rock Thrush	+			PM	NA	LC			
86	*Motacilla alba*	Хөх цэгцгий	White Wagtail	+	+	+*	НӨ	LC	LC			
87	*Motacilla cinerea*	Уулын цэгцгий	Grey Wagtail	+	+*	+*	ДӨ	LC	LC			
88	*Motacilla citreola*	Шартүрүүт цэгцгий	Citrine Wagtail	+	+	+*	ДӨ	LC	LC			
89	*Motacilla flava*	Шар цэгцгий	Western Yellow Wagtail			+*	НӨ	LC	LC			
90	*Muscicapa dauurica*	Дагуурын намнаахай	Asian Brown Flycatcher	+			BV	LC	LC			
91	*Numenius arquata*	Морин тутгалжин	Eurasian Curlew		+*	+*	ДӨ	LC	LC			II
92	*Oenanthe isabellina*	Бүжимч чогчиго	Isabelline Wheatear	+	+	+*	НӨ	LC	LC			II
93	*Oenanthe oenanthe*	Адууч чогчиго	Northern Wheatear	+	+	+*	НӨ	LC	LC			
94	*Oenanthe pleschanka*	Мяраан чогчиго	Pied Wheatear		+*	+*	BV	LC	LC			
95	*Otis tarda*	Хонин тоодог	Great Bustard		+	+*	PM	VU	VU	+	II	I,II
96	*Passer domesticus*	Оронгийн боршувуу	House Sparrow		+	+	СӨ	LC	LC			
97	*Passer montanus*	Хээрийн бор шувуу	Euraslan Tree Sparrow	+	+	+	СӨ	LC	LC			
98	*Perdix dauurica*	Дагуур ятуу	Daurian Partridge	+	+*	+*	RB	LC	LC			
99	*Petronia petronia*	Хадны бор шувуу	Rock Sparrow	+			RB	LC	LC			
100	*Phalacrocorax carbo*	Турагт гогой	Great Cormorant	+			BV	LC	LC			
101	*Phalaropus lobatus*	Нарийн сэлээхэй	Red-necked Phalarope		+*	+*	PM	LC	LC			II
102	*Phoenicurus auroreus*	Дагуур гал сүүлт	Daurian Redstart	+	+		НӨ	LC	LC			II

103	*Phylloscopus proregulus*	Жирхэн дуучшувуу	Pallas's Leaf Warbler	+			BV,PM	LC	LC			
104	*Pica pica*	Алаг шаазгай	Eurasian Magpie	+	+	+*	СӨ	LC	LC			
105	*Pluvialis fulva*	Азийн сувээцагаан	Pacific Golden Plover		+*	+*	PM	LC	LC			
106	*Pyrrhocorax pyrrhocorax*	Улаанхошуут жунгаа	Red-billed Chough	+	+	+	СӨ	LC	LC			
107	*Recurvirostra avosetta*	Алаг ээтэн	Pied Avocet	+	+*	+*	ДӨ	LC	LC			II
108	*Spatula clypeata*	Халбага нугас	Northern Shoveler	+			BV	LC	LC			II
109	*Spatula querquedula*	Цагаан хөмсөгт нугас	Garganey	+			BV	LC	LC			II
110	*Streptopelia orientalis*	Дорнын хүүрзгэнэ	Oriental Turtle Dove	+			BV	LC	LC			
111	*Tadorna ferruginea*	Хондон ангир	Ruddy Shelduck	+	+	+	ДӨ	LC	LC			II
112	*Tadorna tadorna*	Анхидал ангир	Common Shelduck	+	+	+*	ДӨ	LC	LC			II
113	*Tringa erythropus*	Хар хөгчүү	Spotted Redshank		+*	+*	PM	LC	LC			II
114	*Tringa glareola*	Шугуйн хөгчүү	Wood Sandpiper	+			BV	LC	LC			II
115	*Tringa ochropus*	Цагаан сүүлт хөгчүү	Green Sandpiper	+			BV	LC	LC			II
116	*Tringa stagnatilis*	Бүрдний хөгчүү	Marsh Sandpiper	+	+*	+*	BV	LC	LC			II
117	*Tringa totanus*	Улаанхөлт хөгчүү	Common Redshank	+	+	+	ДӨ	LC	LC			II
118	*Turdus atrogularis*	Хар гүеэт хөөндэй	Black- throated Thrush	+			BV,PM	LC	LC			
119	*Turdus eunomus*	Хүрэн хөөндэй	Dusky Thrush	+					LC			
120	*Turdus naumanni*	Науманны хөөндэй	Naumann's Thrush	+	+		BV,PM	LC	LC			
121	*Turdus obscurus*	Халиун хөөндэй	Eyebrowed Thrush	+			BV,PM	LC	LC			
122	*Turdus ruficollis*	Улаан гүеэт хөөндэй	Red-throated Thrush	+			BV,PM	LC	LC			
123	*Upupa epops*	Бөвөөлжин өвөөлж	Common Hoopoe	+	+*	+*	НӨ	LC	LC			
125	*Vanellus vanellus*	Умардын хавтгаалж	Northern Lapwing	+	+	+	BV	LC	NT			II
126	*Zoothera aurea*	Алаг хөөндэй	White's Thrush	+			ДӨ	LC	LC			

Товчлол, тэмдэглэгээ:

Ховордлын зэрэглэл. **EN**-Устаж болзошгүй; **VU**-Эмзэг; **NT**-Ховордож болзошгүй; **LC**-Анхааралд ертөхөөргүй;
I, II- 1, 2-р Хавсралтад бүртгэгдсэн; + -Тухайн бүтээлд бүртгэгдсэн

Экологийн статус. **RB**-Суурин үрждэг; **WV**-Өвөл орж ирдэг; ?-тодорхойгүй.

Тохиолдоц ба давтамж

Судалгааны явцад нийт 8,588 (давтамж (n) =1,405) бодгаль шувуу бүртгэгдсэн ба үүнээс хамгийн их нь эвэрт болжмор 2,214 бодгаль, улаан хошуут жунгаа 1,141 бодгаль, Монгол болжмор 799 бодгаль, хон хэрээ 621, боролзой болжмор 560, шилийн сар 543 бодгаль байна (хүснэгт 4).

Хамгийн олон давтамжтай эвэрт болжмор (n=281), хон хэрээ (n=195), Монгол болжмор (n=158), шилийн сар (n=140), улаан хошуут жунгаа (n=113) тэмдэглэгдэв (зураг 4, хүснэгт 4).

Зураг 4. Судалгааны талбайд хамгийн олон давтамжтай тэмдэглэгдсэн шувууд.

1. Эвэрт болжмор 2. Улаан хошуут жунгаа 3. Хадны боршувуу 4. Шилийн сар 5. Хон хэрээ



Шувуудын агаарын хөлөгтэй мөргөлдөх эрсдэлийн үнэлгээ

Энэхүү эрсдэлийн үнэлгээг David C. Paton "Bird risk assessment model for airports and aerodromes" (2009), Документ 9137-3 (2012)-ийн 6-р бүлэгт заасан аргачлал буюу MNS 6942: 2021 "Аэродром орчимд агаарын хөлгийг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх" Монгол улсын стандартад заасан аргачлалын дагуу хийж гүйцэтгэв.

Судалгааны явцад бүртгэгдсэн шувуудын биеийн жингийн мэдээллийг https://birdsoftheworld.org/, http://datazone.birdlife.org/, https://sibirds.ru/, https://www.oiseaux-birds.com/, https://animaldiversity.org/, https://www.birdmongolia.com/ болон бусад байгууллагын цахим хуудаснаас авч ашигласан бөгөөд шувуудын агаарын хөлөгт учруулах хүндрэлийн үнэлгээг шувууны хамгийн их жингээр тооцсон болно. Шувуудын сүргийн хэмжээ, тохиолдох магадлалыг илүү бодитой тооцохын тулд тухайн нисэх буудлын орчимд хийсэн өөрсдийн ажиглалтын судалгааны мэдээлэлд буюу шувуудын дундаж тоо, тархалт, нягтшил, нисэх өндөр зэрэгт тулгуурлав.

Эрсдэлийн үнэлгээгээр агаарын хөлөгт аюул учруулах өндөр эрсдэлтэй (III түвшин) шувуудад Улаан хошуут жунгаа, Нөмрөг тас, Өвөгт тогоруу, Шилийн сар, Хондон ангир, Сохор элээ, Гангар хун, Начин шонхор, Алагтуу хэрээ, Монгол цахлай, Хон хэрээ, Тарважи бүргэд, Хөхвөр тагтаа, Идлэг шонхор, Ногоохон нугас, Монгол болжмор, Дэрсний жиргэмэл, Эвэрт болжмор, Хээрийн боршувуу, Боролзой болжмор, Хадны бор шувуу, Хөх дэглий, Тураг гогой, Шовтгор алаг нугас бүртгэгджээ (хүснэгт 4).

Хүснэгт 4. Хөшигийн хөндийн шувуудын аюулын эрсдэлийн эрэмбэ дараалал

№	Шувууны нэр	Англи нэр	Биеийн жин, гр	Биеийн жингийн үнэлгээний үтга	Сүргийн үнэлгээний үтга	Нийт оноо	Аюул (хор үршиг)	Агаарын хөлөгтэй мөргөлдөх магадлал	Эрсдэлийн түвшин
1	Улаан хошуут жунгаа	Red-billed Chough	280-430	8	4	32	Маш өндөр	Маш өндөр	III
2	Нөмрөг тас	Cinereous Vulture	7,500-12,000	32	2	64	Маш өндөр	Өндөр	III
3	Өвөгт тогоруу	Demoiselle Crane	2,000-3,000	16	4	64	Маш өндөр	Бага	III
4	Шилийн сар	Upland Buzzard	1,000-1,300	16	2	32	Маш өндөр	Маш өндөр	III
5	Хондон ангир	Ruddy Shelduck	900-1,600	16	2	32	Маш өндөр	Маш өндөр	III

6	Сохор элээ	Black Kite	800-1,100	8	4	32	Маш өндөр	Дунд	III
7	Гангар хун	Whooper Swan	10,000-12,000	32	2	64	Маш өндөр	Бага	III
8	Начин шонхор	Common Kestrel	180-240	8	4	32	Маш өндөр	Бага	III
9	Алагтүү хэрээ	Daurian Jackdaw	220	8	4	32	Маш өндөр	Бага	III
10	Монгол цахлай	Mongolian Gull	1,000-1,800	16	2	32	Маш өндөр	Бага	III
11	Хон хэрээ	Northern Raven	800-1,520	16	4	64	Маш өндөр	Маш өндөр	III
12	Тарважи бүргэд	Steppe Eagle	2,600-4,800	16	2	32	Маш өндөр	Бага	III
13	Хөхвөр таггаа	Rock Dove	240-360	8	2	16	Өндөр	Маш өндөр	III
14	Идлэг шонхор	Saker Falcon	800-1,300	16	2	32	Маш өндөр	Бага	III
15	Ногоохон нугас	Eurasian Teal	200-450	8	2	16	Өндөр	Дунд	III
16	Монгол болжмор	Mongolian Lark	41-50	2	4	8	Дунд	Маш өндөр	III
17	Дэрсний жиргэмэл	Asian Short-toed Lark	20-24	2	4	8	Дунд	Маш өндөр	III
18	Эвэрт болжмор	Horned Lark	30-45	2	4	8	Дунд	Маш өндөр	III
19	Хээрийн боршувуу	Eurasian Tree Sparrow	19-29	2	2	4	Бага	Маш өндөр	III
20	Боролзой болжмор	Eurasian Skylark	29-50	2	4	8	Дунд	Маш өндөр	III
21	Хадны бор шувуу	Rock Sparrow	26-39	2	4	8	Дунд	Өндөр	III
22	Хөх дэглий	Grey Heron	1,020-2,070	16	2	32	Маш өндөр	Бага	III
23	Тураг гогой	Great Cormorant	2,600-3,700	16	2	32	Маш өндөр	Бага	III
24	Шовтгор алаг нугас	Northern Pintail	450-1450	16	1	16	Өндөр	Маш бага	II
25	Дагуур ятуу	Daurian Partridge	200-400	8	2	16	Өндөр	Маш бага	II
26	Турлиах хэрээ	Rook	310-500	8	2	16	Өндөр	Маш бага	II
27	Зэрлэг нугас	Mallard	800-1,900	16	2	32	Маш өндөр	Маш бага	II
28	Умардын хавтгаалж	Northern Lapwing	180-230	8	2	16	Өндөр	Маш бага	II
29	Анхидал ангир	Common Shelduck	900-1,600	16	2	32	Маш өндөр	Маш бага	II
30	Хонин тоодог	Great Bustard	3,800-6,500	32	1	32	Маш өндөр	Маш бага	II
31	Цармын бүргэд	Golden Eagle	3,300-6,500	32	1	32	Маш өндөр	Маш бага	II
32	Эгэл шаршувуу*	Eurasian Eagle-owl	2,100-3,200	16	2	32	Маш өндөр	Маш бага	II
33	Бор нугас*	Gadwall	700-1,000	8	2	16	Өндөр	Маш бага	II
34	Тарлан сар	Rough-legged Buzzard	800-1,300	16	1	16	Өндөр	Маш бага	II
35	Морин туталжин*	Eurasian Curlew	750-920	8	2	16	Өндөр	Маш бага	II
36	Морин цуцал*	Black-tailed Godwit	280-340	8	2	16	Өндөр	Бага	II
37	Хүрэн толгойт цахлай*	Black-headed Gull	260-335	8	2	16	Өндөр	Маш бага	II
38	Алаг ээтэн*	Pied Avocet	225-395	8	2	16	Өндөр	Маш бага	II
39	Хондлойцагаан ураацай*	Pacific Swift	40-45	2	4	8	Дунд	Дунд	II
40	Зээрд шонхор	Lesser Kestrel	180-240	8	2	16	Өндөр	Маш бага	II
41	Хар хэрээ	Carrion Crow	460-580	8	2	16	Өндөр	Маш бага	II
42	Саарал хулд	Hen Harrier	350-530	8	2	16	Өндөр	Маш бага	II
43	Науманны хөөндэй	Naumann's Thrush	77-81	4	2	8	Дунд	Дунд	II
44	Борлог хөмрөг	Little Bunting	12-19	2	2	4	Бага	Өндөр	II
45	Бахим хараалай	Gull-billed Tern	220-300	8	2	16	Өндөр	Маш бага	II

46	Гээгт нугас	Falcated Duck	420-770	8	2	16	Өндөр	Маш бага	II
47	Зээрт нугас	Eurasian Wigeon	500-1,000	8	2	16	Өндөр	Бага	II
48	Ойн сар	Common Buzzard	550-1,300	16	1	16	Өндөр	Маш бага	II
49	Улаан хүзүүт шүмбүүр	Common Pochard	700-1,100	16	1	16	Өндөр	Бага	II
50	Халбага нугас	Northern Shoveler	400-820	8	2	16	Өндөр	Маш бага	II
51	Цагаан хөмсөгт нугас	Garganey	340-580	8	2	16	Өндөр	Маш бага	II
52	Бор бүргэд	Greater Spotted Eagle	1,600-3,000	16	1	16	Өндөр	Маш бага	II
53	Цэн тогоруу	White-naped Crane	5,000-5,600	32	1	32	Маш өндөр	Маш бага	II
54	Хадны таттаа*	Hill Pigeon	240-360	8	1	8	Дунд	Маш бага	I
55	Бахим бүргэд*	Booted Eagle	600-1,000	8	1	8	Дунд	Маш бага	I
56	Алаг шаазгай	Azure-winged Magpie	155-260	8	1	8	Дунд	Маш бага	I
57	Шүүман шонхор	Eurasian Hobby	130-320	8	1	8	Дунд	Маш бага	I
58	Дорнын сар	Eastern Buzzard	525-1,000	8	1	8	Дунд	Маш бага	I
59	Асрын хараацай*	Barn Swallow	15-20	1	4	4	Бага	Маш бага	I
60	Улаг харцага	Northern Goshawk	300-390	8	1	8	Дунд	Маш бага	I
61	Морин харцага	Eurasian Sparrowhawk	186-260	8	1	8	Дунд	Маш бага	I
62	Эгэл хилэнжиргүүр*	Black-winged Stilt	150-200	4	2	8	Дунд	Маш бага	I
63	Хайргын хөвчүү	Common Sandpiper	40-60	4	2	8	Дунд	Бага	I
64	Улаанхөлт хөвчүү	Common Redshank	105-150	4	2	8	Дунд	Маш бага	I
65	Хар хөвчүү*	Spotted Redshank	110-175	4	2	8	Дунд	Маш бага	I
66	Азийн сувээцагаан*	Pacific Golden Plover	70-142	4	2	8	Дунд	Маш бага	I
67	Бурдний хөвчүү*	Marsh Sandpiper	55-85	4	2	8	Дунд	Маш бага	I
68	Хадуур элсэг*	Curlew Sandpiper	54-66	4	2	8	Дунд	Маш бага	I
69	Хар элсэг*	Dunlin	39-57	4	2	8	Дунд	Маш бага	I
70	Хуран чихт хөмрөг	Meadow Bunting	21-26	2	2	4	Бага	Дунд	I
71	Бүүлгат хөмрөг*	Lapland Longspur	20-34	2	2	4	Бага	Бага	I
72	Бүжимч чоргито	Isabelline Wheatear	27-31	2	2	4	Бага	Бага	I
73	Оронгийн боршувуу	House Sparrow	23-37	2	2	4	Бага	Бага	I
74	Хурын ураацай	Common Swift	38-45	2	4	8	Дунд	Маш бага	I
75	Хотны бүргэхэй*	Little Owl	160-180	4	1	4	Бага	Маш бага	I
76	Бөвөөлжин өвөөлж*	Common Hoopoe	60-80	4	2	8	Дунд	Маш бага	I
77	Эгэл хөхөө*	Common Cuckoo	90-110	4	1	4	Бага	Маш бага	I
78	Нарийн хиазат	Little Ringed Plover	31-47	2	2	4	Бага	Бага	I
79	Шөвгөн хараалж	Common Snipe	93-145	4	1	4	Бага	Маш бага	I
80	Савар элсэг*	Long-toed Stint	20-32	2	2	4	Бага	Маш бага	I
81	Улбар түрүүт элсэг*	Red-necked Stint	22-43	2	2	4	Бага	Маш бага	I
82	Тимминскийн элсэг*	Temminck's Stint	23-35	2	2	4	Бага	Маш бага	I
83	Бор цэгцүүхэй	Twite	14-18	1	2	2	Маш бага	Бага	I
84	Дагуур галсүүлт	Daurian Redstart	14-19	1	1	1	Маш бага	Маш бага	I
85	Адуун чоргино	Northern Wheatear	19-35	2	1	2	Маш бага	Бага	I

86	Хэзрийн шийхнүүхэй*	Richard's Pipit	23-38	2	1	2	Маш бага	Маш бага	I
87	Годлевскийн шийхнүүхэй*	Blyth's Pipit	23-28	2	1	2	Маш бага	Маш бага	I
88	Мяраан чогчиго*	Pied Wheatear	16-25	2	1	2	Маш бага	Маш бага	I
89	Хөх цэгцгий	White Wagtail	18-30	2	1	2	Маш бага	Бага	I
90	Шартүрүүт цэгцгий	Citrine Wagtail	13-22	1	1	1	Маш бага	Маш бага	I
91	Уулын цэгцгий*	Grey Wagtail	14-21	1	1	1	Маш бага	Маш бага	I
92	Хүрган намнаа	Taiga Flycatcher	10-14	2	1	2	Маш бага	Маш бага	I
93	Умардын дунхай	Northern Shrike	56-79	2	1	2	Маш бага	Маш бага	I
94	Ухаа дунхай	Brown Shrike	27-37	2	1	2	Маш бага	Бага	I
95	Шэр цэгцгий	Western Yellow Wagtail	12-26	2	1	2	Маш бага	Бага	I
96	Алаг хөвөндэй	White's Thrush	100-140	4	2	8	Дунд	Маш бага	I
97	Шархөмсөгт хөмрөг	Chestnut-eared Bunting	14-21	2	1	2	Маш бага	Бага	I
98	Алаг бужирга	Brambling	21-29	2	1	2	Маш бага	Бага	I
99	Бөртөт шийхнүүхэй	Olive-backed Pipit	17-26	2	1	2	Маш бага	Бага	I
100	Дагуурын намнаахай	Asian Brown Flycatcher	11-12	2	1	2	Маш бага	Маш бага	I
101	Дүүлгэт бужирга	Common Chaffinch	18-29	2	1	2	Маш бага	Маш бага	I
102	Мандир үранхайжин	Mandarin Duck	420-700	8	1	8	Дунд	Маш бага	I
103	Одой элсэг	Little Stint	20-40	2	2	4	Бага	Маш бага	I
104	Өнгөлүүрт гүргалдай	Siberian Rubythroat	16-29	2	2	4	Бага	Маш бага	I
105	Улаан гүеэт хөвөндэй	Red-throated Thrush	63-103	4	2	8	Дунд	Бага	I
106	Халиун хөвөндэй	Eyebrowed Thrush	65-110	4	2	8	Дунд	Маш бага	I
107	Хар гүеэт хөвөндэй	Black- throated Thrush	54-110	4	2	8	Дунд	Маш бага	I
108	Харзны шийхнүүхэй	Water Pipit	19-27	2	1	2	Маш бага	Маш бага	I
109	Хөх түрүүт хөмрөг	Black-faced Bunting	14-26	2	1	2	Маш бага	Маш бага	I
110	Хүрэн хөвөндэй	Dusky Thrush	62-88	2	2	4	Бага	Дунд	I
111	Цагаан сүүлт хөрчүү	Green Sandpiper	75-85	2	2	4	Бага	Маш бага	I
112	Цагаан хүзүүт хөмрөг	Reed Bunting	15-24	2	2	4	Бага	Маш бага	I
113	Цэнхэр жинжир	Blue Rock Thrush	37-61	2	1	2	Маш бага	Маш бага	I
114	Шүгүйн хөрчүү	Wood Sandpiper	50-80	2	2	4	Бага	Бага	I
115	Дорнын хүлд	Eastern Marsh Harrier	370-780	8	1	8	Дунд	Маш бага	I
116	Дорнын хүүрэгэнэ	Oriental Turtle Dove	165-274	8	1	8	Дунд	Маш бага	I
117	Жирхэн дүүчигүүр	Pallas's Leaf Warbler	4-7	2	2	4	Бага	Маш бага	I
118	Наран бөдөө	Japanese Quail	100-160	4	2	8	Дунд	Маш бага	I
119	Хул дунхай	Chinese Grey Shrike	70-92	2	1	2	Маш бага	Маш бага	I
120	Цагаан хөвэлт хөмрөг	Pallas's Bunting	14-20	2	1	2	Маш бага	Маш бага	I

121	Цагаан шаазгай хөмрөг	Pine Bunting	19-37	2	1	2	Маш бага	Маш бага	I
122	Шивэр хөвөндэй	Siberian Thrush	60-90	2	1	2	Маш бага	Маш бага	I

Хөхтөн

Чингис хаан" ОУ-ын шинэ нисэх буудал орчимд гүйцэтгэсэн судалгааны үр дүн, өмнө хийгдсэн БОНБНУ-ий тайлан, Батсайхан нар, 2022 бүтээлтэй харьцуулан үзэхэд 6 баг 13 овгийн 22 зүйл хөхтөн амьтан тэмдэглэгджээ. Үүнээс Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан дансны шалгууруар олон улсын болон бүс нутгийн ховордлын зэрэглэлтэй Монгол тарвага, хярс, шар үнэг, саарал чоно зэрэг амьтад байна. Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсад худалдаалах тухай Конвенцийн хавсралтад шар үнэг, саарал чоно, Зэрлэг амьтны нүүдлийн зүйлийг хамгаалах тухай Конвенцийн хавсралтад буурал сармаахай тус тус тэмдэглэгдсэн байна (Clark *et all.*, 2006; CITES., 2001; Шар ба Лхагвасүрэн, 2019) (хүснэгт 5; зураг 5).

"Чингис хаан" ОУ-ын шинэ нисэх буудал орчимд гүйцэтгэсэн судалгааны үр дүн, өмнө хийгдсэн БОНБНУ-ий тайлан, Батсайхан нар, 2022 бүтээлтэй харьцуулан үзэхэд 6 баг 13 овгийн 22 зүйл хөхтөн амьтан тэмдэглэгджээ. Үүнээс Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан дансны шалгууруар олон улсын болон бүс нутгийн ховордлын зэрэглэлтэй Монгол тарвага, хярс, шар үнэг, саарал чоно зэрэг амьтад байна. Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсад худалдаалах тухай Конвенцийн хавсралтад шар үнэг, саарал чоно, Зэрлэг амьтны нүүдлийн зүйлийг хамгаалах тухай Конвенцийн хавсралтад буурал сармаахай тус тус тэмдэглэгдсэн байна (Clark *et all.*, 2006; CITES., 2001; Шар ба Лхагвасүрэн, 2019) (хүснэгт 5; зураг 5).

Хүснэгт 5. "Чингис хаан" ОУ-ын нисэх буудал орчимд тохиолдох хөхтөн амьтдын зүйлийн жагсаалт

